



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ
САНХҮҮГИЙН МЭРГЭШСЭН ИНСТИТУТ

Номч Боржигон
Норовсамбуугийн ОДГЭРЭЛ

САНХҮҮГИЙН ЧӨЛӨӨТ БҮСЭД
ТУЛГУУРЛАН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ, ЗАРИМ АРГА ЗАМ



Мэргэжлийн индекс
E04120101

Бизнесийн удирдлагын
Мастерын зэрэг горилсон судалгааны ажил

Удирдсан
Б.Даваажаргал /МВА/

Улаанбаатар. 2024



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ
САНХҮҮГИЙН МЭРГЭШСЭН ИНСТИТУТ

Номч Боржигон
Норовсамбуугийн ОДГЭРЭЛ

САНХҮҮГИЙН ЧӨЛӨӨТ БҮСЭД
ТУЛГУУРЛАН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ, ЗАРИМ АРГА ЗАМ



Мэргэжлийн индекс
E04120101

Бизнесийн удирдлагын
Мастерын зэрэг горилсон судалгааны ажил

Удирдагч: Б.Даваажаргал /МВА/

Шүүмжлэгч: Ж.Дэлгэрсайхан /МВА/

Улаанбаатар. 2024

ГАРЧГИЙН ТОВЬЁГ

МЭДЭГДЭХ ХУУДАС	i
ТАЛАРХАЛ	ii
ТОВЧ ХУРААНГУЙ.....	iii
ABSTRACT	iv
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	viii
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	ix
УДИРТГАЛ.....	10
Судалгааны ажлын үндэслэл.....	10
Судалгааны ажлын зорилго.....	12
Судалгааны ажлын зорилтууд	12
Судалгааны ажлын арга зүй	13
Судалгааны ажлаас хүлээгдэж буй үр дүн.....	13
Судлагдсан байдлын судалгаа	13
I БҮЛЭГ. ОНОЛЫН СУДАЛГАА	21
1.1 Чөлөөт бүсийн үүсэл, хөгжил	21
1.2 Санхүүгийн системийн интеграцичлал.....	27
1.3 Үндэстний өрсөлдөх давуу талын онол буюу Майкл Портерын Даймонд загвар	33
II БҮЛЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА	37
2.1 Монгол улсын санхүүгийн салбарын өнөөгийн байдал.....	37
2.2 Монгол улсын чөлөөт бүсийн өнөөгийн байдал.....	45
III БҮЛЭГ. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГАА.....	50
3.1 Амжилттай кэйс туршлага-Астана санхүүгийн чөлөөт бүс.....	50
3.2. Санхүүгийн системийн өрсөлдөх чадвар /Даймонд модель/.....	55
IV БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ	61
4.1. Астана санхүүгийн чөлөөт бүсийн хөгжлийн стратеги	61
4.2. Казакстан улсын санхүүгийн зах зээлийн хөгжил.....	67
ДҮГНЭЛТ	74
САНАЛ ЗӨВЛӨМЖ	76
НОМ ЗҮЙ.....	i
ХАВСРАЛТ	iii

МЭДЭГДЭХ ХУУДАС

Энэхүү судалгааны ажил нь миний өөрийн бүтээл болохыг баталж байна. Энэхүү бүтээл нь СЭЗИС-ийн оюуны өмч болох бөгөөд тус сургуулийн номын сан судалгааны ажлыг нийтийн хүртээл болгохыг зөвшөөрч байна.

Магистрантын нэр: Н.Одгэрэл

Гарын үсэг:

Огноо: 2024.01.29

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны ажлыг удирдан чиглүүлж, хийж гүйцэтгэхэд гүн туслалцаа үзүүлсэн Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Сургуулийн эрхлэгч Б.Даваажаргал багшид гүн талархал илэрхийлж байна.

Энэхүү судалгааны ажлын дүгнэлт, санал, зөвлөмж нь зөвхөн судлаач миний байр суурийг илэрхийлж байгаа болно.

ТОВЧ ХУРААНГУЙ

1995 онд Монгол Улсын Их Хурлаас “Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай” үзэл баримтлалыг баталснаас хойш өнөөдрийн байдлаар худалдааны чөлөөт бүс гурав байгуулагдсан байна.

Дэлхийн дээрх олон улс чөлөөт бүс байгуулах замаар эдийн засгаа эрчимжүүлж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах гэж хичээж байгаа энэ цаг үед тухайн чөлөөт бүс амжилттай хэрэгжих эсэх нь түүний өрсөлдөх чадвартай салшгүй холбоотой юм. Иймд, санхүүгийн чөлөөт бүс байгуулах замаар санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх боломж бий эсэхийг Монгол Улсын санхүүгийн зах зээлийн өрсөлдөх чадварыг нь үнэлэх замаар судлах нь зохимжтой гэж үзсэн. Өрсөлдөх чадварыг үнэлэхдээ Майкл Портерын Үндэстний өрсөлдөх чадварын давуу талын онол буюу Даймонд загварыг ашиглан нийт 19 хүчин зүйлсийг хоёрдогч өгөгдөлд дүн шинжилгээ хийх замаар үнэлсэн. Үнэлгээний үр дүнд Монгол Улсын санхүүгийн зах зээлийг санхүүгийн чөлөөт бүс байгуулах замаар хөгжүүлэх боломжтой ч, чөлөөт бүсэд Английн эрх зүйн системийг хэрэглэх боломжийг нарийвчлан судлах, бизнесийн орчинг цогцоор нь бүрдүүлэхгүйгээр чөлөөт бүс байгуулах нь амжилтгүй туршлагын тоог нэмэгдүүлэхээс өөр үр дүнгүй гэсэн дүгнэлтэд хүрч, цаашид эрх зүйн систем, хууль, тогтоомж, газарзүйн байршлын судалгааг нарийвчлан нарийвчлан хийх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж, одоо байгаа чөлөөт бүсийг хөгжүүлэх, эсхүл шинээр байгуулахаар төлөвлөж буй чөлөөт бүсийн үйл ажиллагааны дүрэм, журмыг бүрэн боловсруулах, олон улсын түвшний өндөр ур чадвар бүхий мэргэжилтэнг татах таатай нөхцөл бүрдүүлэх арга замыг нарийвчлан тодорхойлох, виз олголтын журам болон ажиллаж, амьдрах таатай орчинг хэрхэн сайжруулах алхамуудыг тодорхойлох зөвлөмжийг боловсруулсан.

Түлхүүр үг: *Санхүүгийн зах зээл, санхүүгийн төв, чөлөөт бүс, санхүүгийн чөлөөт бүс, эдийн засгийн чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүс, гадаадын шууд хөрөнгө оруулалт, өрсөлдөх чадвар, Даймонд загвар.*

ABSTRACT

In 1995, the Mongolian Parliament approved the concept of “Establishment of Free Economic Zones”, so far three free trade zones have been established.

At the time, majority of countries in the world are trying to stimulate their economies and attract foreign direct investment by creating free zones, the success of the free zones is inextricably linked to its competitiveness. Thus, it was considered appropriate to study whether there is a possibility of developing the financial market through the establishment of a financial free zone by evaluating the competitiveness of the Mongolian financial market. In evaluating competitiveness, nineteen factors were evaluated by secondary data analysis using Micheal Porter’s theory of National Competitive Advantage “Diamond model”. As a result of evaluation, it was possible to develop the Mongolian financial market by creating financial free zone. But it was a vital for success that a study of possibility of applying the English jurisdiction to the free zone and a creation of a comprehensive business environment. In the future, it is recommended to carry out a detailed study of the legal system, laws, regulations, and geographical location. To develop the existing and creating free zones, it is necessary that to draft and approve all the operating rules, regulations, instructions and manuals, to determine in detail ways to create favorable conditions for attracting international experts with high-level skills, to simplify visa procedures, as well as to identify steps for improving living and working environment.

Key words: *Financial market, international finance center, free zone, financial free zone, economic free zone, special economic free zone, foreign direct investment, competitiveness, Diamond model.*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Санхүүгийн зах зээлийн төвлөрөл /2023 оны I улирлын байдлаар, тэрбум₮/	10
Хүснэгт 2. Хөгжиж буй орнуудын санхүүгийн зах зээлийн үзүүлэлт	11
Хүснэгт 3. Чөлөөт бүсийн эдийн засагт үзүүлэх үр нөлөө	14
Хүснэгт 1.1. Эдийн засгийн чөлөөт бүсийн хэлбэр	23
Хүснэгт 1.2. Эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжлийн үе	24
Хүснэгт 1.3. Чөлөөт бүс байгуулах зорилго	25
Хүснэгт 1.4. Дэлхийн Топ 10 ОУСТ	30
Хүснэгт 1.5. Ази-Номхон далайн бүс нутгийн Топ 15 ОУСТ.....	31
Хүснэгт 1.6. Үнэлгээний хүчин зүйлс	32
Хүснэгт 2.1. Санхүүгийн салбарын голлох үзүүлэлт /2023 оны I улирлын байдлаар/.....	38
Хүснэгт 2.2. МУ-ын Хөрөнгийн зах зээлд болсон үйл явдлын он цагийн дараалал	40
Хүснэгт 3.1. АСЧБ санхүүгийн зах зээлд оролцогчдын тоо	52

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ.....	10
Зураг 2. Зээлийн дундаж хүүгийн харьцуулалт.....	12
Зураг 1.1. Чөлөөт бүсийн тоон үзүүлэлт	21
Зураг 1.2. ЧБ-ийн бүтэц, зохион байгуулалтын хэлбэр	26
Зураг 1.3. Үндэсний өрсөлдөх давуу талын онол буюу Даймонд загвар.....	33
Зураг 2.1. Санхүүгийн системийн бүтэц	37
Зураг 2.2. Зээлийн багцын чанарын үзүүлэлт	39
Зураг 2.3. ББСБ-ийн нийт хөрөнгө, зээлийн дүн, эздийн өмчийн дүн ба өсөлт	39
Зураг 2.4. ББСБ-ын өр төлбөр ба өсөлт	39
Зураг 2.5. Зах зээлийн үнэлгээ, ТОП-20 индексийн өөрчлөлт	44
Зураг 2.6. Даатгалын салбарын нийт хөрөнгө, нөөц сан ба өсөлт	44
Зураг 2.7. Ази-Европыг холбосон замын маршрут	46
Зураг 2.8. Ази-Европыг холбосон замын маршрут дагуух хүн амын тоо	46
Зураг 2.9. МУ-ын гадаад худалдааны эргэлт /сая\$/	47
Зураг 2.10. Алтанбулаг ЧБ-ийн гадаад худалдааны эргэлт /сая\$/	47
Зураг 2.11. УБ хотын дагуул хот, ЭЗТБ-ийн ерөнхий төлөвлөгөө	49
Зураг 2.12. УБ хотын ойролцоох ЭЗЧБ-ийн ерөнхий төлөвлөгөө	49
Зураг 3.1. Казакстан улс болон МУ-ын газарзүйн байршил	51
Зураг 3.2. Биржид бүртгэлтэй компани болон арилжааны хэмжээ, данс эзэмшигчдийн тоо	52
Зураг 3.3. АСЧБ-ийн бүтэц, зохион байгуулалт	53
Зураг 3.4. Шүүх болон Арбитрын журмаар шийдвэрлэсэн маргааны статистик үзүүлэлт	53
Зураг 3.5. МУ-д арбитрын журмаар шийдвэрлэгдсэн маргааны статистик үзүүлэлт	54
Зураг 3.6. Стратеги, бүтэц, өрсөлдөөн бүлгийн шинжилгээний үр дүн.....	56
Зураг 3.7 Хүчин зүйлсийн нөхцөл байдлын бүлгийн шинжилгээний үр дүн.....	57
Зураг 3.8. Эрэлтийн нөхцөл байдал бүлгийн шинжилгээний үр дүн	58
Зураг 3.9. Хамааралтай болон дэмжих салбар бүлгийн шинжилгээний үр дүн.....	59
Зураг 3.10. Санхүүгийн зах зээлийн нийт үнэлгээ	60
Зураг 4.1. Астана хот уруу шууд нислэг үйлддэг хотуудын газрын зураг	64
Зураг 4.2. АСЧБ-ийн нутаг дэвсгэр.....	65

Зураг 4.3 Гишүүдийн тоо, 2018 он	Зураг 4.4 Гишүүдийн тоо, 2023 он.....	67
Зураг 4.5 Ашигт ажиллагааны үзүүлэлт.....		70
Зураг 4.6. Арилжааны үзүүлэлт.....		70
Зураг 4.7. Зах зээлийн үнэлгээ.....		71
Зураг 4.8. Зах зээлийн үнэлгээ /Астана, KASE/.....		71
Зураг 4.9. Жижиг хөрөнгө оруулагчдын тоо.....		72
Зураг 4.10. Оршин суугч бус этгээдийн хувьцааны арилжааны эргэлт		72

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Стратеги, бүтэц, өрсөлдөөн-Бизнесийн ерөнхий орчин	iii
Хавсралт 2. Стратеги, бүтэц, өрсөлдөөн-Капиталын хөдөлгөөн	iii
Хавсралт 3. Стратеги, бүтэц, өрсөлдөөн-Зах зээлд шинээр нэвтрэх	iii
Хавсралт 4. Стратеги, бүтэц, өрсөлдөөн-Хууль тогтоомжийн тэнцвэрт байдал	iv
Хавсралт 5. Стратеги, бүтэц, өрсөлдөөн-Хууль, эрх зүйн орчин	iv
Хавсралт 6. Стратеги, бүтэц, өрсөлдөөн-Дотоод өрсөлдөөн	v
Хавсралт 7. Хүчин зүйлсийн нөхцөл байдал-Хүний нөөц	v
Хавсралт 8. Хүчин зүйлсийн нөхцөл байдал-Эрх зүйн орчны дэд бүтэц	vi
Хавсралт 9. Хүчин зүйлсийн нөхцөл байдал-Мэдээлэл, харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэд бүтэц	vi
Хавсралт 10. Хүчин зүйлсийн нөхцөл байдал-Амьдралын чанар	vii
Хавсралт 11. Хүчин зүйлсийн нөхцөл байдал-Барилга байгууламж, нийтийн тээврийн дэд бүтэц.....	vii
Хавсралт 12. Хүчин зүйлсийн нөхцөл байдал-Газарзүйн байршлын давуу тал	vii
Хавсралт 13. Эрэлтийн нөхцөл байдал-Дотоод эдийн засгийн орчин	viii
Хавсралт 14. Эрэлтийн нөхцөл байдал-Капиталын эх үүсвэр	viii
Хавсралт 15. Эрэлтийн нөхцөл байдал-Дотоодын хэрэглэгч.....	ix
Хавсралт 16. Эрэлтийн нөхцөл байдал-Дотоод зах зээл болон оролцогчдын уян хатан байдал	ix
Хавсралт 17. Холбоотой болон дэмжих салбарууд-Дэлхийн зах зээлийн интеграцичлалын нөлөөний цар хүрээ	x
Хавсралт 18. Холбоотой болон дэмжих салбарууд-Дэмжигч салбарын өсөлт	x
Хавсралт 19. Холбоотой болон дэмжих салбарууд-Холбоотой салбарын чанар.....	xi

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АСЧБ	Астана санхүүгийн чөлөөт бүс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Улс
БОС	Бизнесийн орчны судалгаа
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЗГ	Засгийн газар
КҮБ	Казасктаны Үндэсний Банк
МБ	Монгол банк
МУ	Монгол улс
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
ОУТ	Олон улсын санхүүгийн төв
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СЧБ	Санхүүгийн чөлөөт бүс
УИХ	Улсын Их Хурал
ЧБ	Чөлөөт бүс
ЭЗТБ	Эдийн засгийн тусгай бүс
ЭЗЧБ	Эдийн засгийн чөлөөт бүс

УДИРТГАЛ

Судалгааны ажлын үндэслэл

Монгол улсын санхүүгийн зах зээлд гол үүрэг гүйцэтгэгч нь банкны салбар бөгөөд даатгал, үнэт цаас, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо зэрэг бусад оролцогчдын оруулж буй хувь нэмэр сулхан байгааг судлаачдын судалгааны бүтээлүүдээс тод харж болно. Тухайлбал, Монгол банкны 2020 оны “Санхүүгийн салбарын төлөв байдал, цаашид анхаарах асуудлууд” судалгаагаар нийт зах зээлийн 96 хувийг банкны салбар эзэлж байгаа бөгөөд санхүүгийн мөчлөг болон бизнесийн мөчлөгийн шууд хамааралтай байдал нь санхүүгийн салбарт чанаргүй зээл өсөх, хүндрэл үүсгэх гол хүчин зүйл болж байгааг тодорхой харуулсан байдаг. Уг судалгаа нь 2020 оноос хойш дахин хийгдээгүй тул нийт санхүүгийн салбарт эзлэх банкны салбарын төвлөрөл буурсан эсэхийг Монгол банк болон Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 1 дүгээр улирлын тайланд үндэслэн тооцож үзэхэд 91.2% буюу бага зэрэг буурсан боловч 90-ээс дээш хувийг эзэлсэн хэвээрээ байгааг Хүснэгт 1-ээс харна уу.


Хүснэгт 1. Санхүүгийн зах зээлийн төвлөрөл /2023 оны I улирлын байдлаар, тэрбум₮/

Үзүүлэлт	Банк	ББСБ	ХЗХ	Даатгал	Нийт
Нийт хөрөнгө	46,402.5	3,702.1	274.5	486.9	50,866
Эзлэх хувь	91.2%	7.3%	0.5%	1%	100%

Эх сурвалж: Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо 2023 оны I улирлын тайлан.

Түүнчлэн ковидын үеэс хойш хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа нилээд идэвхижсэн дүр зурагтай байгаа тул мөн тоон үзүүлэлтийг шинжилж үзэхэд 2017 оноос хойш хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 1.4 их наядаас 6.5 их наяд буюу 4.6 дахин өссөн боловч Зүүн Азийн хөгжиж буй орнуудтай харьцуулахад хөгжил нь сул хэвээр байгааг Зураг 1 болон Хүснэгт 2-оос тус тус харагдаж байна. Тодруулбал, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг хэмждэг гол 3 үзүүлэлтээр хөгжиж буй 10 улстай харьцуулахад Монгол улс хамгийн сүүлд буюу 10-т байна.

Зураг 1. Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 2. Хөгжиж буй орнуудын санхүүгийн зах зээлийн үзүүлэлт


№	Үзүүлэлт	ЗЗҮ/ДНБ	ЗЗҮ өндөр 10 компанийг оруулалгүйгээр тооцсон үнэлгээг нийт ЗЗҮ-нд харьцуулах нь	Хөрвөх чадвар
1	Малайз	125.9	65	30.2
2	Тайланд	99.2	65.5	74.6
3	Филиппин	81	57.6	14.7
4	Хятад	65.7	85.6	38.4
5	Индонези	43.5	51.9	21.2
6	Орос	34.8	38.9	28.8
7	Вьетнам	34.7		43.2
8	Казакстан	21.2	12.6	4.8
9	Турк	21	60.4	186.4
10	Монгол /2022/	14.3	25.8	2.4

Эх сурвалж: Дэлхийн санхүүгийн зах зээлийн хөгжлийн тайлан 2019/2020 (Дэлхийн банк)

Монгол банкны 2020 оны “Санхүүгийн салбарын төлөв байдал, цаашид анхаарах асуудлууд” судалгааны үр дүнд санхүүгийн салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хадгаламжийн төвлөрөл, чанаргүй зээл нь санхүүгийн зуучлалын тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлж байгаа тул эх үүсвэрийн төвлөрөлийг багасгах зохицуулалт хийх, санхүүгийн бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлж, шинээр нэвтрүүлэх, банкны салбарын хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг бууруулах зэрэг арга хэмжээ авах санал, зөвлөмжийг боловсруулжээ.

Түүнчлэн МҮХАҮТанхимын “Бизнесийн орчны судалгаа” сэдэвт 2020 оны судалгаанд жижиг дунд бизнес эрхлэгчид санхүүжилтийн орчинг муу, сайжруулах нэн шаардлагатай гэж үнэлсэн байна. Судалгаанд нийт 4015 аж ахуйн нэгж оролцсон бөгөөд санхүүжилтийн зардал өндөр, валютын ханш, төгрөгийн ханшны сулрал нь голлох асуудал хэмээн судалгааны оролцогчид хариулсан байна. Бизнесийн санхүүжилтийн хүүгийн түвшинг хөгжиж буй орнуудын хүүгийн түвшинтэй харьцуулж үзэхэд 3 дахин өндөр байгааг доор зурагнаас харагдаж байна. Энэхүү харьцуулалтыг Нью-Йоркийн Их Сургуулийн профессор Асвалт Дамодраны 2024 оны 1 сарын байдлаар хийсэн судалгааны тоон мэдээллээс зөвхөн хөгжиж буй зах зээлийн мэдээллийг сонгон авч Монгол банкны 2023 оны 3 дугаар улирлын “Банкуудын зээлийн төлөв” түүвэр судалгааны мэдээлэлтэй харьцуулан гаргасан (Зураг 2-оос үзнэ үү).

Зураг 2. Зээлийн дундаж хүүгийн харьцуулалт



Эх сурвалж: <https://pages.stern.nyu.edu/~adamodar/> (Aswath Damodaran)

Дээрх судалгаа болон тоон мэдээллүүдээс үзэхэд Монголын санхүүгийн салбарын хөгжил сул бөгөөд хөгжлийн хурд удаашралтай гэж дүгнэж байна. Өөрөөр хэлбэл, бид засаглалын бүхий л түвшинд санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага байгааг мэдэрч, үнэт цаас болон даатгалын салбарыг банкны салбартай эн тэнцүүлэн хөгжүүлэхийг сүүлийн 20 жил зорин, улмаар Алсын хараа 2050 хэмээх бодлогын баримт бичигт тусган тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа ч, дорвитой өөрчлөлт харагдахгүй байгаа нь энэхүү судалгааны бүтээлийг бичих гол үндэслэл болсон билээ. Улмаар санхүүгийн салбарыг хөгжүүлэх гарцыг тодорхойлохоор бусад улс орны санхүүгийн зах зээлийг сонирхон судлах явцад, санхүүгийн чөлөөт бүсийн тухай ойлголттой анх танилцсан бөгөөд сүүлийн үед эрчимтэй хөгжиж буй Дубай, Астана, Бусан зэрэг хотууд санхүүгийн чөлөөт бүсийг байгуулан, хөгжүүлж байгаа нь сонирхолтой санагдсан. Иймд, Монгол улсад санхүүгийн чөлөөт бүсэд тулгуурлан санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх боломж байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон.

Эцэст нь хэлэхэд, энэ салбарын хөгжлийн ач холбогдлыг Олон Улсын Санхүүгийн Төвүүдийн Дэлхийн Холбоо /World Alliance of International Financial Centers/-ны Ерөнхий захирал Томас Крантз “Олон Улсын Санхүүгийн Төвийг оркестрын удирдаач хэмээн тодорхойлоод, оркестрт хөгжим бүр өөрийн гэсэн үүрэг гүйцэтгэх хэдий ч, удирдаач удирдаж байж нэгэн бүхэл болж гайхалтай хөгжмийг бүтээдэгтэй адилтган зүйрлэсэн” байдаг. Өөрөөр хэлбэл, санхүүгийн зах зээл нь улс орны эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөгч хүч нь юм.

Судалгааны ажлын зорилго

Энэхүү судалгааны зорилго нь Санхүүгийн чөлөөт бүс нь санхүүгийн зах зээлийн хөгжлийн нэг гарц байх боломжтой эсэхийг тодорхойлоход оршино.

Судалгааны ажлын зорилтууд

Судалгааны ажлын зорилгын хүрээнд доорх зорилтуудыг дэвшүүлсэн:

- Санхүүгийн чөлөөт бүс, түүний бусад чөлөөт бүсээс ялгарах онцлогийг онолын түвшинд тодорхойлох;

Зорилт 1: Чөлөөт бүсийн тухай онол арга зүй, онолын загварууд болон хөгжлийн үе шатуудыг судлах,

Зорилт 2: Монголын санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, тулгамдаж буй асуудлын учир шалтгааныг нарийвчлан судлах,

- Олон улсын амжилттай болон амжилтгүй туршлагыг судлах;

Зорилт 3: Санхүүгийн чөлөөт бүс байгуулж, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх олон улсын туршлагыг судлах

- Амжилттай хэрэгжсэн туршлагыг Монголд нутагшуулах боломжийг тодорхойлох;

Зорилт 4: Монгол улсын бодлогын зорилттой уялдуулан санхүүгийн чөлөөт бүс байгуулж, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх боломжийг тодорхойлох,

- Амжилттай хэрэгжих боломжид саад болох хүчин зүйлийг тодорхойлох;

Зорилт 5: Санхүүгийн чөлөөт бүс байгуулж, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд үүсэж буй сул талыг тодорхойлж, санал зөвлөмж боловсруулах.

Судалгааны ажлын арга зүй

Тус судалгааны ажилд Монгол улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүд, гадаад улс орон болон дотоод санхүүгийн зах зээлийн орчинтой холбоотой хууль, журам, статистик тоо баримтуудыг ном сурах бичиг болон интернэт, вэб сайтуудаас цуглуулан гадаад болон дотоодын судлагдсан байдлын судалгаа буюу хоёрдогч өгөгдөл дээр тулгуурлан хүчин зүйлсийг 1-5 хүртэлх оноогоор үнэлж, өрсөлдөх чадвар бий эсэх болон сайжруулах шаардлагатай хүчин зүйлсийг тодорхойлох замаар хийж гүйцэтгэсэн.

Судалгааны ажлаас хүлээгдэж буй үр дүн

- Монгол улсын санхүүгийн зах зээлийг санхүүгийн чөлөөт бүс байгуулах замаар хөгжүүлэх боломжтой байна.
- Монгол улсын санхүүгийн чөлөөт бүсийн өрсөлдөх чадварыг сайжруулах шаардлагатай байна.

СУДЛАГДСАН БАЙДЛЫН СУДАЛГАА

Дотоодод судлагдсан байдал

Чөлөөт бүс:

Судлаач (О.Хишигмөнх Отгонтэнгэр Их Сургуулийн багш, докторант) “*Монгол улсын чөлөөт бүсийн хөгжилд тулгамдсан зарим асуудал*” сэдэвтэй эрдэм шинжилгээний бүтээлдээ “Монгол улс олон тулгуурт эдийн засгийг бий болгож, тогтвортой хөгжихийн тулд чөлөөт бүсийг хөгжүүлэх замаар орон нутгийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, экспортыг дэмжих шаардлагатай байна” гэж тодорхойлсон байна. Түүнчлэн сүүлийн 20 гаруй жил чөлөөт бүс байгуулахыг оролдсон ч амжилтгүй байгаа шалтгааныг олон талаас нь судлах шаардлагатай хэмээн үзээд энэхүү бүтээлдээ аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах орчин бүрдээгүй, хөрөнгө оруулагч оруулсан хөрөнгөө эрсдэлгүй өсгөх боломж хязгаарлагдмал байгаа нь нөлөөлж байна гэж дүгнэсэн. Мөн эрх

зүйн зохицуулалтын хувьд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон урамшууллыг тодорхой хэмжээнд шийдсэн боловч, тухайн бүсийг дагасан хотжилт, бүтээн байгуулалт орхигдсоноос үр ашиггүй байх нөхцөл үүссэнийг харгалзан үзэх шаардлагатай гэжээ. Эцэст нь Монгол Улс хөрш орнуудтайгаа эдийн засгийн хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр баталсан боловч улс төрийн тогтворгүй байдал нь цаг хугацаа ихээхэн алдахад хүргэж, эдийн засгийн үр ашигт сөргөөр нөлөөлж байгааг мөн дурдсан байна.

Судлаач (С.Батбуян СЭЗДС-ийн ахлах багш, докторант) “Монгол улсын чөлөөт бүсийн ирээдүй ба эрх зүйн орчин” сэдэвт эрдэм шинжилгээний бүтээлдээ “Дэлхийн эдийн засаг дахь олон улсын бараа эргэлт, эдийн засгийн интеграцийн идэвхижилт, эдийн засгийн хөгжлийн түвшинг хурдасгах гол үзүүлэлт нь эдийн засгийн чөлөөт бүс юм” хэмээн тодорхойлоод Монгол улсын чөлөөт бүсийн эрх зүйн орчинг БНСУ-ын чөлөөт бүсийн эрх зүйн орчинтой харьцуулан судалжээ. Чөлөөт бүсийг улсын төсвөөс бус өөрөө өөрийгөө санхүүжүүлээд зогсохгүй улсын төсөвт хөрөнгө төвлөрүүлдэг газар болгож өөрчлөх зарчмыг удирдлага болгох шаардлагатай байгаа бөгөөд ингэхийн тулд зөвхөн татварын хөнгөлөлт чөлөөлөлт бус, чөлөөт бүсийн хөгжил, хотжилт, бүтээн байгуулалт, санхүүжилт зэргийг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай гэж дүгнэжээ. Энэхүү дүгнэлтийн хүрээнд дараах санал зөвлөмжийг боловсруулсан байна.

- a. Чөлөөт бүсийг дагасан хотжилт, бүтээн байгуулалт, газар зохион байгуулалт, оршин суугчдын ажил эрхлэлт, амьдрах орчин, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, бүсийн өөрийгөө санхүүжүүлэх чадвар зэрэг асуудлыг шийдвэрлэх эрх зүйн болон бүтцийн тогтолцоог бий болгох;
- b. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулагчдад баталгаатай орчинг бүрдүүлэх;
- c. Чөлөөт бүсийн менежментийг хувийн хэвшилд шилжүүлэх.

Монгол улсын засгийн газар: “Хөшигтийн хөндийд эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тандалт судалгаа”-г хийж эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг судлан тогтоосон байна. Энэхүү судалгаанаас эдийн засагт үзүүлэх үр нөлөөг сонгон Хүснэгт 3-т харуулсан.

Хүснэгт 3. Чөлөөт бүсийн эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж	Тийм	Үгүй

	ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх		
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх,	Тийм	Үгүй

	дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй

Эх сурвалж: <https://www.parliament.mn> (МУ-ын ЗГ)

Энэхүү судалгаагаар чөлөөт бүс байгуулснаар өрсөлдөөнийг дэмжих, инфляцийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгох зэрэг олон эерэг үр нөлөөтэй хэмээн дүгнэсэн байна.

Судлаач (Ж.Эрдэнэбулган, МУИС-ын профессор, доктор, Х.Болормаа МУИС-ын багш, магистр, А.Солонго МУИС-ын багш, магистр, Т.Наранцогт МУИС-ын багш, магистр) “Чөлөөт бүсийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг боловсронгуй болгох зарим арга зам” эрдэм шинжилгээний бүтээлээрээ чөлөөт бүсийн хууль тогтоомжийг нарийвчлан судалжээ. Монгол улсад мөрдөгдөж буй чөлөөт бүсийн өнөөгийн хууль тогтоомж дэлхийн чиг хандлагатай ерөнхийдөө нийцэж байна гэж судлаач дүгнээд дараах санал зөвлөмжийг боловсруулсан байна.

- a. Чөлөөт бүс байгуулахад шаардлагатай дэд бүтэц, ус, эрчим хүчний хангамж, интернэт, харилцаа холбооны сүлжээг байгуулах, мэргэжилтэй ажилтан бэлтгэх нарийвчилсан төлөвлөгөө зэрэг бэлтгэл ажлыг сайтар хангах;
- b. Чөлөөт бүсэд ашиглах валютын зохицуулалт, төлбөр тооцооны хэлбэр зэргийг тодорхой болгож хуульчлах.

Судлаачид чөлөөт бүсийг эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих үр ашигтай арга зам гэдгийг хүлээн зөвшөөрсөн хэдий ч, Монгол Улсын хувьд цогцоор нь хөгжүүлэхгүй байгаа нь амжилтгүй байгаа гол шалтгаан нь гэж үзсэн байна. Мөн судлаач Ж.Эрдэнэбулган чөлөөт бүс дэх санхүүгийн зах зээлийн зохицуулалт тодорхой бус байгааг тодорхой болгох шаардлагатай гэдгийг онцлон дурджээ.

Санхүүгийн зах зээл:

Судлаач (Х.Базарсул Мастерын судалгааны ажил, 2016 он) “*Жижиг дунд бизнесийн санхүүжилтийг дэмжих арга замууд*” судалгааны бүтээлдээ ЖДҮ-ийн 70 орчим хувь нь санхүүгийн бэрхшээлтэй тулгардаг боловч одоогийн байдлаар хөрөнгийн зах зээлд бонд гаргах замаар санхүүжилтийн эх үүсвэр татах боломж хараахан бүрдээгүй байна гэж дүгнэжээ. Түүнчлэн хөгжингүй орнуудад үнэт цаас гаргах, хөрөнгө оруулалт татах замаар санхүүжилтийг бий болгохыг эрмэлздэг бөгөөд санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх нь ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааг өргөжүүлэх, үр ашигтай, тогтвортой хөгжлийг бий болгох хамгийн оновчтой арга зам гэж тодорхойлсон байна.

Монгол банк (Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэн, 2020 он) “*Монгол улсын эдийн засгийн 2019 оны гүйцэтгэлийн дүн шинжилгээ, 2020 оны төлөв байдал*” судалгаандаа Монголын Үндэсний статистикийн хорооноос гаргасан статистикаар нийт 170.2 мянган аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас 50.4% нь үйл ажиллагаа явуулж, 49.6% нь тодохой шалтгаануудаар үйл ажиллагаа явуулаагүй байна хэмээн дурдаад үүний шалтгаан нь Бизнесийн санхүүжилтийн хүртээмжтэй орчин, арга хэрэгслүүд сайн хөгжөөгүйтэй холбоотой хэмээн дүгнэжээ.

Монгол банк (Б.Баярдаваа, Н.Ургамалсувд, Б.Батмөнх, 2020 он) “*Санхүүгийн салбарын төлөв байдал, цаашид анхаарах асуудлууд*” сэдэвт судалгааны бүтээлдээ Монгол Улсын санхүүгийн салбарын төлөв байдалд дүн шинжилгээ хийж, санхүүгийн зах зээлийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийн шинжилгээг хийхдээ санхүүгийн мөчлөгийг бизнесийн мөчлөгтэй харьцуулах техник ашиглан тооцоолсон байна.

Санхүүгийн салбарын зуучлалын үүргийг голчлон банкны систем гүйцэтгэж байгаагаас гадна тус салбарын бизнес эрхлэгчид урт хугацааны тогтвортой хөгжил бус богино хугацааны ашигт төвлөрч байгааг тодорхойлсон. Энэ нь санхүүгийн салбарын эмзэг байдлыг нэмэгдүүлж байгаагийн улмаас эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих зорилт алдагдах эрсдэлийг нэмэгдүүлж байна гэж үзжээ. Энэхүү судалгаагаар дараах санал зөвлөмжийг боловсруулсан байна.

- a. Санхүүгийн системийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх;
- b. Эх үүсвэрийн төвлөрлийг багасгахад чиглэсэн зохицуулалт болон санхүүгийн бүтээгдэхүүн төрлийг нэмэгдүүлж, зах зээлд нэвтрүүлэх;
- c. Хадгаламжийн төвлөрлөөс үүдэлтэй сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор зохицуулалт хийх.

Санхүүгийн зохицуулах хорооноос хийдэг “Санхүүгийн салбарын тойм” 2023 оны III улирлын судалгаагаар үнэт цаасны зах зээлийн арилжаа өмнөх оны мөн үеэс 2 дахин, 2019 оны мөн үеэс 5.9 дахин өссөн бол биржийн бус зах зээлийн хувьд өмнөх оны мөн үеэс 64.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Даатгалын зах зээлийн өсөлт 29.6 хувь байгаа ч валютын ханшийн эрсдэл, гадаад улсуудад давхар даатгуулдаг байдал болон давхар даатгалын хураамжид төлж буй зардал даатгалын хураамжийн 34.5 хувийг эзэлж байгаа зэрэг нь тухайн салбарын тулгамдсан асуудал болоод байна гэж дүгнэжээ. Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 26.7 хувиар, 2019 оны мөн үеийнхээс 2.9 дахин өссөн байна. ХЗХ-ны зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар, 2019 оны мөн үеэс 36.4 хувиар нэмэгдсэн. Түүнчлэн, хөрөнгийн зах зээлийн арилжаа сүүлийн үед идэвхижиж байгаа ч, санхүүгийн сектор дахь банкны салбарын төвлөрөл байсаар байгааг мөн дурдсан байна.

Дотоод судлагдсан байдлын судалгаанаас үзэхэд, Монгол улс анхны чөлөөт бүс байгуулах хуулийг баталснаас хойш 30 орчим жил өнгөрсөн боловч чөлөөт бүс дорвитой хөгжөөгүй хэвээр байгаа бөгөөд үүний шалтгааныг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого бус харин тухайн бүс нутагт хүмүүс ажиллаж, амьдрах нөхцлийг бий болгоогүй, хөгжлийн шийдлийг цогцоор нь боловсруулаагүй гэж үзсэн байна.

Харин санхүүгийн зах зээлийн хувьд, санхүүгийн зах зээлийн салбарууд болох банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, даатгал, хөрөнгийн бирж гээд тус тусдаа өсөлттэй байгаа хэдий ч, энэхүү салбарт банкны төвлөрөл байсаар байгаагаас гадна, бусад салбарын хувьд ч төвлөрөл хэт өндөр байгааг судлаачид дурдаад төвлөрлийг бууруулах бодлого боловсруулах шаардлагтайг мөн онцолсон байна.

Гадаадад судлагдсан байдал

Чөлөөт бүс:

Судлаач (Meng Guangwen, Tianjin/People`s Republic of China) *The Theory and Practice of Free Economic Zones: Case Study of Tianjin, People`s Republic of China*. Чөлөөт бүсийн талаарх ихэнхи судалгааны бүтээлүүд чөлөөт бүсийн эдийн засагт үзүүлэх үүрэг, ач холбогдлыг судалсан байдаг. Харин чөлөөт бүс хөгжихгүй байгаа шалтгаан, хүчин зүйл болон улс төр, соёлын үзүүлэлтийг ялгаатай түвшинд буюу олон улсын, бүсийн, тухайн үндэстэний болон орон нутгийн түвшинд судалсан судалгааны бүтээл болон чөлөөт бүс ба тухайн бүс нутгийн хөгжлийн интерграцичилал хоорондын уялдаа холбоог судалсан

судалгааны бүтээл цөөхөн байгааг энэхүү судлаач онцолсон байна. Судлаач Тяньжин мужийг жишээ болгон авч, Хятадын чөлөөт бүсийн цаашдын хөгжлийн чиг хандлагыг орон нутаг болон бүс нутгийн түвшинд тодорхойлохыг зорьсон. БНХАУ-ын хувьд чөлөөт бүс байгуулах нь хамгийн оновчтой арга зам бөгөөд цаашид чөлөөт бүсийн зорилгыг шинэчлэх, шинэ шатанд гаргах шаардлагатай гэж дүгнэжээ.

Судлаач (UNCTAD) *World Investment Report 2019; Special Economic Zones*. Энэхүү судалгааны бүтээлд чөлөөт бүстэй хамааралтай бүхий л мэдээллийг дэлхийн өнцөг булан бүрээс цуглуулан дүн шинжилгээ хийсэн. Чөлөөт бүсийн төрөл, хөгжлийн үе шат, хууль, эрх зүйн орчин, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахад нөлөө үзүүлэгч хүчин зүйлс, чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага, засаглалын загвар, болон чөлөөт бүсийн тогтвортой хөгжлийг үнэлэх үзүүлэлт зэргийг задлан шинжилсэн. Түүнчлэн чөлөөт бүсийн амжилтад сөргөөр нөлөөлдөг 10 хүчин зүйлсийг тодорхойлсноос хамгийн их нөлөө үзүүлэгч нь өрсөлдөөн болон үр ашиггүй дэд бүтэц байна. Иймд чөлөөт бүсийг байгуулахдаа өрсөлдөх чадварыг зөв тодорхойлж, давуу талаа хэрхэн ашиглах стратегия зөв тодорхойлохоос гадна сул талаа сайжруулахад анхаарах шаардлагатай байдаг байна.

Судлаач (Sithong Phommachith, Phithagorn Thanitbenjasith, Chian Mai University, Thailand) *Competitiveness of Luang Prabang Special Economic Zone, Lao People's Democratic Republic: Diamond Model Analysis*. Энэхүү судалгааны ажлаар “Лаун Прабан” эдийн засгийн тусгай бүсийн өрсөлдөх чадварыг Майкл Портерын Даймонд загварыг ашиглан тодорхойлсон байна. Тус чөлөөт бүс нь Лаосын эдийн засгийн гол салбар болох худалдаа, аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалт татах зорилготой байгуулагдсан боловч амжилттай хэрэгжүүлж чадаагүй байна. Иймд Даймонд загварыг ашиглан тухайн чөлөөт бүсийн давуу болон сул талыг тодорхойлохыг зорьсон. Тус бүсийн хувьд аялал жуулчлал, орон нутгийн соёлын элементэд түшиглэсэн нь бусдаар ялгарах гол онцлог давуу тал нь болохоос гадна Вьетнам, Хятад, Камбож болон Тайландыг холбосон төмөр замын төсөл нь байршлын хувьд давуу талыг бий болгож байгааг онцолжээ. Баруун болон зүүн зүгт төмөр замыг тэлэх бодлого, хөрөнгө оруулалтын хуулийн шинэчлэлт, хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах гол суурь болж байгаа тул үүнд тулгуурласан стратеги, тактикийг боловсруулахыг зөвлөсөн байна.

Олон улсын түвшинд чөлөөт бүс бол хөгжлийн нэг гарц бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт татах, инноваци, шинэ технологийн дэвшил зэргийг өөрийн улс оронд нэвтрүүлэхэд хамгийн үр ашигтай арга хэмээн үздэг байна. Улмаар чөлөөт бүсийг амжилттай хэрэгжүүлэх стратегийг тодорхойлохдоо Майкл Портерын Даймонд загварыг судлаачид түгээмэл ашигладаг байна. Тодруулбал, чөлөөт бүсийг амжилттай байгуулж, тогтвортой хөгжүүлэхийн тулд түүний өрсөлдөх чадварыг Даймонд загварт тулгуурлан тодорхойлж, давуу талдаа дулдуйдсан стратегийг тодорхойлох аргыг ашигладаг байна.

Санхүүгийн зах зээл:

Book (Youssef Cassis, Cambridge University, 2006) *“Capitals of Capital: A History of International Financial Centres, 1780-2005”* Олон улсын санхүүгийн төв /International finance center/-ийн хөгжил нь санхүүгийн төв болж буй хотын хөгжилтэй нягт, уялдаа холбоотой байдаг. XVI-XVIII зууны үед боомт түшиглэсэн хотуудад худалдаа, арилжаа

түлхүү хөгжиж байсан нь тухайн улсуудын санхүүгийн зах зээлийг хөгжихөд түлхэц өгсөн. Харин глобал түвшинд хөгжихөд 1800-аад оны эхэн үеэс эхлэл нь тавигдаж, дунд үеэс эрчимтэй хөгжсөн төмөр замын сүлжээ чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Орон зай, цаг хугацааны хувьд давуу талыг бий болгож, хүмүүс хот хооронд болон улс хооронд саадгүй зорчих болсноор худалдаа, арилжаа улам тэлж, банкны салбарууд нэмэгдэж эхэлсэн. Улмаар Дэлхийн I болон II дайны дараа улс орнууд илүү нэгдэн нягтарч, худалдааны либералчлал явагдаж, ам.доллар ноёлох валютаар тодрон, төлбөр тооцоог нэг валютаар хийх болсон. Дэлхийн худалдаа эргэлтэд томоохон байр суурь эзэлж байсан хотуудын санхүүгийн салбар глобал түвшинд гарч ирэн өнөөгийн тэргүүлэх санхүүгийн төвүүд бий болсон бол тэдний араас бусад улс орон санхүүгийн чөлөөт бүс байгуулах замаар өрсөлдөж эхэлсэн.

Судлаач (Z/Yen Limited 2005) *The Competitive Position of London as a Global Financial Centre*. Z/Yen нь Лондон хотод байрлалтай бодлогын судалгааны хүрээлэн бөгөөд санхүүгийн зах зээлийн хөгжилд хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан хувь нэмрээ оруулах үндсэн зорилготой байгууллага юм. Тус байгууллага нь олон улсын санхүүгийн төвүүдийн өрсөлдөх чадавхийг үнэлэх замаар гол хүчин зүйлсийг тодорхойлох, улмаар Лондон хотын өрсөлдөх чадварыг хадгалах зорилготой байсан. Өрсөлдөх чадварыг тодорхойлох 14 хүчин зүйлс байна хэмээн тодорхойлж, уг хүчин зүйлсийг ач холбогдлоор нь эрэмбэлэхэд ур чадвартай хүний нөөцтэй байх нь хамгийн өндөрөөр үнэлэгдсэн бол, эсрэгээрээ хувь хүний орлогын албан татварын систем хамгийн багаар үнэлэгдсэн байна. Энэхүү судалгаа нь олон улсын санхүүгийн төвүүдийн өрсөлдөх чадварыг үнэлэх суурь үзүүлэлтүүдийг тодорхойлсон чухал ач холбогдолтой судалгааны бүтээл болсон.

Судлаач (Z/Yen Limited, 2023) *The Global Financial Centres; Index 34*. Тус байгууллагаас 2007 оны 3 сард анх удаа санхүүгийн төвүүдийг өрсөлдөх чадвараар нь үнэлж, эрэмбэлснээс хойш 2023 оны 9 сарын байдлаар 34 дэх үнэлгээгээ хийжээ. Бизнесийн орчин, хүний нөөц, дэд бүтэц, татвар, нэр хүнд гэсэн үндсэн таван хүчин зүйлийн хүрээнд 2 үе шаттайгаар үнэлдэг. Нэгдүгээр үе шатанд тус байгууллагын вэб сайтаар дамжуулан онлайн судалгааг бөглүүлэх бөгөөд хоёрдугаар шатанд онлайн судалгааны үр дүн болон 147 байгууллагаас гаргасан судалгааны үр дүнгийн өгөгдлийг хүчин зүйлсийг үнэлэх аргаар хиймэл оюун ухааныг ашиглан үнэлдэг. 34 дэх үнэлгээний тайланд нийт 121 санхүүгийн төвийг үнэлснээс нэгдүгээрт Нью-Йорк, хоёрдугаарт Лондон хот эрэмбэлэгдсэн байна. Түүнчлэн, сүүлийн үед БНХАУ нь чөлөөт бүс дэх өсөн нэмэгдэж буй санхүүгийн хэрэгцээ шаардлагыг соргоогоор мэдэрч, санхүүгийн чөлөөт бүсийн ач холбогдлыг өндрөөр үнэлэхийн зэрэгцээ санхүүгийн салбарт технологийн шинэчлэл хийж, хөрөнгө оруулагч нарт санхүүгийн чанартай үйлчилгээ санал болгох замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлого явуулж байна хэмээн онцгойлон дурджээ.

Судлаач (Josef Joachim L.Magpantay, University of Central Florida, 2011) *Anatomy of a financial center's global competitiveness in the context of Micheal Porter's model of national competitive advantage a theoretical analysis*. Судлаач олон улсын санхүүгийн төвийн өрсөлдөх чадварыг глобал түвшинд тодорхойлохдоо Майкл Портерын Даймонд загварыг ашигласан. Судалганы объектын хувьд Лондон, Нью-Йорк, Хонг Конг, Сингапур зэрэг өрсөлдөх чадвар өндөртэй хотуудыг сонгон авч нийт 4 бүлэг 19 хүчин зүйлсээр үнэлсэн.

Олон улсын санхүүгийн төвийг тогтвортой хөгжүүлэх хамгийн чухал зүйл нь өрсөлдөх чадвар хэмээн судлаачид үзэж, өрсөлдөх чадварын үндсэн хүчин зүйлсийг тодорхойлсон байна. Эдгээр хүчин зүйлсийг ерөнхийд нь бизнесийн орчин, хүний нөөцийн ур чадвар, нэр хүнд, дэд бүтэц, татвар гэсэн үндсэн 5 бүлэг хуваан авч үзсэнээс хүний нөөцийн ур чадварыг хамгийн чухал хүчин зүйл хэмээн үнэлсэн байна. Түүнчлэн тухайлсан зах зээлийг судлахдаа судалгааны арга зүйг илүү хялбаршуулан Майкл Портерын Үндэстний өрсөлдөх чадварын давуу талын онолыг түгээмэл ашигладаг байна.

Гадаад болон дотоод судлагдсан байдлын судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэвэл, Монгол Улсын дотоодын санхүүгийн салбарын хөгжил сул байх бөгөөд олон улсад аливаа зах зээлийг хөгжүүлэх нэг гарц нь чөлөөт бүс байгуулах арга зам байдаг байна. Монгол Улсын хувьд чөлөөт бүс байгуулсан туршлага байгаа ч амжилттай хэрэгжүүлж чадаагүй сул талтай байгаа тул амжилтгүй байгаа шалтгааныг тодруулах, амжилттай хэрэгжүүлэх стратегийг тодорхойлохын тулд өрсөлдөх чадварыг үнэлэх, түүнд тулгуурласан стратегийг боловсруулах шаардлагатай байна.

I БҮЛЭГ. ОНОЛЫН СУДАЛГАА

1.1 Чөлөөт бүсийн үүсэл, хөгжил

Чөлөөт бүс нь 13 дугаар зууны үед Францын Масай худалдааны боомтоос үүсэлтэй. 18 дугаар зууны үед Англи улсад орчин үеийн чөлөөт бүс анх бий болсон хэдий ч, 1960-аад оноос далайн боомт, агаарын тээвэр болон төмөр замын сүлжээнд түшиглэсэн чөлөөт бүсийг байгуулан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, эдийн засгийн урамшуулал олгох замаар олон улсын худалдааны эргэлт болон хэмжээг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж эхэлснээр бүрэн утгаараа үүсч, хөгжсөн гэж үздэг. 2019 оны байдлаар нийт 5,400 орчим чөлөөт бүс байгуулагдсан тухай НҮБ-ийн хөрөнгө оруулалтын судалгаанд дурджээ (Зураг 1.1-ээс үзнэ үү).

Зураг 1.1. Чөлөөт бүсийн тоон үзүүлэлт

Figure IV.1. | Historical trend in SEZs (Numbers of countries and SEZs)



Source: UNCTAD.

Note: The trend is indicative only. Historical estimates are based on ILO (2014) for 1975, 1986, 1995, 1997, 2002 and 2006; FIAS (2008) for 2008; *The Economist* (2015) for 2014; and UNCTAD for 2018. Scope and definitions of the various estimates across years may differ.

Эх сурвалж: World Investment Report 2019 (UNCTAD)

1975 онд 29 улсад нийтдээ 79 чөлөөт бүс байсан бол 2018 онд 147 улсад нийт 5,400 буюу 60 гаруй жилийн хугацаанд 68 дахин нэмэгдэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл нь худалдааны либералчлал, олон улсын санхүүгийн зах зээлийн эрчимтэй хөгжил болон аж үйлдвэрлэлийн интеграцилал юм. Үүнээс улбаатайгаар, чөлөөт бүсийг дийлэнх улсууд эдийн засгаа тэлэх, хөгжингүй эсхүл буурай хөгжилтэй улсууд хөгжих боломж гэж харах болсон. Хэдийгээр амжилтгүй кэйс олон байгаа ч, доор дурдсан шалтгааны улмаас чөлөөт бүс байгуулахыг эрмэлздэг байна. Үүнд:

➤ *Бизнесийн орчны шинэчлэлийг хийхэд харьцангуй хялбар*

Засаглал сул улсын хувьд улсын хэмжээнд шинэчлэлийн бодлого хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг учраас чөлөөт бүс байгуулах замаар гадаадын хөрөнгө оруулалтыг татахыг эрмэлздэг. Түүнчлэн, чөлөөт бүсийн байгуулсан үндсэн зорилго биелээгүй ч, энэ нь тухайн улсын өрсөлдөх чадвар болон гадаадын хөрөнгө оруулалт татах бодлогын сул талыг тодорхойлоход чухал хүчин зүйл болдог. Тодруулбал, тодорхой бүс нутгийн хэмжээнд аливаа бодлогын арга хэмжээг туршихад үр дүн нь богино хугацаанд гарч, илэрсэн алдааг засах, сайжруулахад хялбар байдаг давуу талтай байдаг байна.

➤ *Чөлөөт бүс байгуулах зардал бага*

Тодорхой нэг бүс нутагт дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх нь бүх л улсын хэмжээнд хийснээс бага зардалтай байхаас гадна хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ихэнхи хэсгийг шийдвэрлэдэг тул улсын төсвөөс гарах санхүүжилт бага байдаг.

➤ *Өсөн нэмэгдэж буй өрсөлдөөний эрчим*

Уул уурхайн салбараас бусад салбарт хөрөнгө оруулалт татах өрсөлдөөний эрчим улам л нэмэгдэж байна. Учир нь ихэнхи улс чөлөөт бүс байгуулах замаар хөрөнгө оруулагч нарт таатай нөхцөлийг бий болгосон багц үйлчилгээ санал болгохын зэрэгцээ урамшууллын системийг давхар нэвтрүүлэн өрсөлдөж байна. Энэхүү ширүүн өрсөлдөөн дунд хөрөнгө оруулагчдыг татахуйц бодлого боловсруулах хүнд сорилттой бодлого боловсруулагч нар тулгарч байгаа нь чөлөөт бүс байгуулах бас нэг шалтгаан болж байна.

Олон тоогоор эрчимтэй байгуулагдаж байгаа чөлөөт бүсийг худалдааны чөлөөт бүс, эдийн засгийн чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүс, аж үйлдвэрийн тусгай бүс, шинжлэх ухаан, технологийн парк, мэдээлэл, технологийн парк, инновацийн хааб, шинжлэх ухааны цогцолбор бүс, үйлчилгээнд суурилсан чөлөөт бүс гэх мэтээр янз бүрээр нэрлэж байна. Санхүүгийн чөлөөт бүсийг санхүүгийн хааб /hub/, эсхүл санхүүгийн төв /financial center/ хэмээн гурван янзаар нэрлэж байгаа ч цаашид Z/yeu бодлогын судалгааны байгууллага, Олон улсын валютын сан болон Олон улсын санхүүгийн төвүүдийн дэлхий холбоо зэрэг голлох байгууллагын нэршлээр буюу санхүүгийн төв хэмээх нэршлийг энэхүү судалгаанд ашиглана.


Харин чөлөөт бүс хэмээх ерөнхий нэршлийн хувьд судлаач Грюбэл Хэрбер, Нэгдсэн Үндэстэн Үндэстэн Дамнасан Корпорациудын Төв-ийн судлаач Fan Sujie, Xiangming Chen, Хятадын судлаач Meng Guangwen болон НҮБ-ийн судлаачидын тодорхойлсон эдийн засгийн чөлөөт бүс хэмээх тодорхойлолтыг ашиглана. Учир нь эдгээр судлаачид ЭЗЧБ хэмээх нэршил нь чөлөөт бүсийн бүхий л төрөл, агуулгыг хамааруулж байна гэж үзээд “ЭЗЧБ гэдэг нь эдийн засаг болон улс төрийн зорилгыг эдийн засаг болон захиргааны эрх чөлөөт байдалд тулгуурлан бодит болгох хэрэгсэл юм.” гэж

тодорхойлсон байх бөгөөд үүнийгээ дараах байдлаар тайлбарлажээ (Meng Guangwen, 2003). Үүнд:

- ЭЗЧБ нь ажлын байр бий болгох, валют арилжааг дэмжих зэрэг микро эдийн засгийн зорилт болон эдийн засгийн хөгжлийн стратеги, шинэчлэлийн бодлого гэх мэт макро эдийн засаг, улс төрийн зорилтыг бодит болгох арга, хэрэгсэл болдог.
- ЧБ буюу тусгайлан тогтоосон газар нутагт санхүүгийн урамшуулалт бодлого, эдийн засгийн болон бусад хэлбэрийн тусгай хөнгөлөлт, чөлөөлөлт санал болгож буй нь эрх чөлөөт байдал юм. Өөрөөр хэлбэл, тус бүс нутагт бизнес эрхлэгч нар нь дотоодын зах зээлд ижил төрлийн бизнес эрлэгч нараас давуу эрхтэйгээр татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон бусад бодлогын хязгаарлалтуудаас ангид байх боломжтой байдаг.
- ЧБ-д хэрэгжүүлж буй тусгай бодлого нь зөвхөн тухайн нутаг дэвсгэрт л үйлчилдэг. Мөн нутаг дэвсгэрийн хэмжээ жижиг, том ямар ч хэмжээтэй байж болохоос гадна байршлын хувьд тухайн улсын нутагт дэвсгэрт, эсхүл хөрш, залгаа улс хоорондын хилийн зурваст байрлаж болдог. Энэ нь дотоодын зах зээлийг хамгаалах, дэлхийн эдийн засгийн хямралын нөлөөллийг бууруулах, хянах зэрэг зорилгыг давхар агуулдаг.
- ЧБ-д зөвхөн эдийн засгийн идэвхитэй үйл ажиллагаа явагддаг. Өөрөөр хэлбэл, улс төрийн аливаа маргаан, үзэл бодлоос ангид оршдог. Түүнчлэн чөлөөт бүс нь зөвхөн гадаад худалдааг дэмжих зорилгоор байгуулагддаггүй. Жишээлбэл: худалдаа, аж үйлдвэр, экспорт, казино, аялал жуулчлал, санхүү, даатгал, технологи, эсвэл бүгдийг нь агуулсан цогц хэлбэрийн чөлөөт бүс ч байх боломжтой байдаг.

Эдийн засгийн чөлөөт бүсийн хэлбэрийн БНХАУ-ын эрдэмтэн Минг Гуангвен дараах нутаг дэвсгэрийн дэглэмийн хувьд дараах байдлаар ангилсан байна (Хүснэгт 1.1-ээс үзнэ үү).

Хүснэгт 1.1. Эдийн засгийн чөлөөт бүсийн хэлбэр



Эх сурвалж: “The Theory and Practice of Free Economic Zones: Case Study of Tianjin, People’s Republic of China” докторын судалгааны бүтээл (Meng Guangwen, 2003)

Чөлөөт бүсийн анхны хэлбэр нь тогтоосон нутаг дэвсгэрийн хүрээгээр хязгаарлагддаг хаалттай хэлбэр байсан бөгөөд тус бүсэд бизнес эрхлэгч нь зөвхөн тухайн нутаг дэвсгэр дотор бизнес эрхлэх ба дотоодын зах зээлтэй холбоотой бизнесийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглодог. Харин нээлттэй хэлбэр нь хөгжлийн явцад үүссэн. Нутаг дэвсгэрийн хязгаарыг хатуу баримталдаггүй, харьцангуй уян хатан бөгөөд дотоодын зах зээлтэй харилцан хамааралтай байж болдог. Дэглэмийн хэлбэрийг чөлөөт бүсийн онцгой хэлбэр гэж үздэг.

Судлаач Минг Гуангвен нь өөрийн докторын бүтээлдээ ЧБ-ийг анх үүссэн цагаас нь хойш өнөөдрийг хүртэл хөгжлийнх нь хувьд 6 үе шатад ангилан авч үзжээ (Хүснэгт 1.2-оос харна уу).

Хүснэгт 1.2. ЭЗЧБ-ийн хөгжлийн үе

Худалдаанд суурилсан ЭЗЧБ /1-р үе буюу 16-р зуунаас 1940 он хүртэл /	Үйлдвэрлэлд суурилсан ЭЗЧБ /2-р үе буюу 1940-1960 он /	Үйлчилгээнд суурилсан ЭЗЧБ /3-р үе буюу 1960-1970 он /	Шинжлэх ухаанд суурилсан ЭЗЧБ /4-р үе буюу 1970-1980 он /	Цогц ЭЗЧБ /5-р үе буюу 1980-1990 он /	Хил дамнансан ЭЗЧБ /6-р үе буюу 1990 оноос хойш /
Чөлөөт боомт	Экспортыг дэмжих бүс	Банкны чөлөөт бүс	Судалгааны парк	Эдийн засгийн тусгай бүс	Хил дамнансан улс хоорондын бүс
Чөлөөт хот	Үйлдвэрийн чөлөөт бүс	Даатгалын чөлөөт бүс	Технологийн парк		
Гаалийн чөлөөт бүс	Хөдөө аж ахуйн экспортыг дэмжих бүс	Казиногийн чөлөөт бүс	Шинжлэх ухаан, технологийн парк	Эдийн засгийн цогцолбор чөлөөт бүс	Бүс нутгийн эдийн засгийн бүс
Татваргүй худалдааны бүс	Хөдөө аж ахуйн чөлөөт бүс	Эрүүл мэндийн чөлөөт бүс	Технологийн хөгжлийн парк		
Чөлөөт худалдааны бүс		Аялал жуулчлалын чөлөөт бүс	Силикон Вали		
		Санхүүгийн чөлөөт бүс			

Эх сурвалж: “The Theory and Practice of Free Economic Zones: Case Study of Tianjin, People`s Republic of China” докторын судалгааны бүтээл (Meng Guangwen, 2003)

Далайн эргийн боомт дагуу худалдааны чөлөөт бүс, хотжилтыг дагаж үйлчилгээнд суурилсан чөлөөт бүс түлхүү үүсэж хөгжсөн. Хөгжлийн эхэн үед худалдааг дагаж чөлөөт боомт, чөлөөт худалдааны бүс үүссэн. Улмаар худалдаа тэлж, өргөжихийн хирээр үйлдвэрлэлд суурилсан чөлөөт бүс үүссэн. Өөрөөр хэлбэл, илүү хямд үнээр үйлдвэрлэхийн тулд үндсэн түүхий эддээ ойр байрлах, эсхүл хямд ажиллах хүчинтэй улс орон уруу үйлдвэрээ нүүлгэх зэрэг үйл явц өрнөснөөр үйлдвэрлэлийн шилжилт явагдаж эхэлсэн. Энэхүү үйл явц нь үйлдвэрлэлд суурилсан чөлөөт бүс эрчимтэй байгуулагдах үндэс суурь нь болсон байна. Цаашилбал улс орны хил хязгаар илүү нээлттэй болж, хүмүүс чөлөөтэй зорчих нь нэмэгдсэнээр үйлчилгээнд суурилсан чөлөөт бүс байгуулагдах болжээ. Харин техник, технологи хөгжихийн хирээр улс орнууд шинжлэх ухааны судалгаанд илүү их анхаарч эхэлсэн бөгөөд үүнтэй уялдан шинжлэх ухаанд суурилсан чөлөөт бүс олноор байгуулагдах болсон. 1980-аад оноос хойш нэг төрлийн чөлөөт бүс байгуулахаас илүү цогцолбор, эсхүл цогц шинжтэй чөлөөт бүс байгуулагдах

болсон. Тухайлбал, АНЭУ нь Дубай хотыг 50 гаруй ЧБ-ийг нэг дор байгуулсан. Улмаар, хил дамнасан чөлөөт бүс буюу бүс нутгийн шинжтэй чөлөөт бүс байгуулагдах болсны тод жишээ нь БНХАУ-ын хэрэгжүүлж буй “Бүс ба Зам” бодлого юм.

НҮБ-ын судлаачид Дэлхийн хөрөнгө оруулалтын тайлан 2019-т улс орны чөлөөт бүс байгуулж буй зорилгыг орлогын түвшинтэй нь уялдуулан дараах байдлаар ангилсан байна (Хүснэгт 1.3-аас харна уу).

Хүснэгт 1.3. ЧБ байгуулах зорилго

Орлогын ангилал	Зорилго
Өндөр орлоготой	<ul style="list-style-type: none"> ▪ Хил дамнасан нийлүүлэлтийн сүлжээний үр ашгийг дээшлүүлэх ▪ Зах зээлийн гажуудлаас сэргийлэх /Economic distortion/
Дунджаас дээгүүр орлоготой	<ul style="list-style-type: none"> ▪ Эдийн засгийг үйлчилгээрүү шилжүүлэх ▪ Шинэ техник, технологийг нэвтрүүлэх ▪ Инновацийг дэмжих, сайжруулах
Дундаж орлоготой	<ul style="list-style-type: none"> ▪ Аж үйлдвэрийг дэмжих ▪ Глабал интеграцийг дэмжих ▪ Технологи нэвтрүүлэхэд анхаарах
Бага орлоготой	<ul style="list-style-type: none"> ▪ Аж үйлдвэрийн хөгжил, диверсификацийг дэмжих ▪ Хөрөнгө оруулалтын орсны сул талыг багасгах ▪ Бизнесийн шинэчлэлийн бодлого хэрэгжүүлэх ▪ Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг татах ▪ Ажлын байр болон экспортыг нэмэгдүүлэх

Эх сурвалж: World Investment Report (UNCTAD 2019)

Чөлөөт бүсийг амжилтад хүргэдэг хүчин зүйлсийг дараах байдлаар тодорхойлсон.

Үүнд:

- Стратегиа зөв тодорхойлох,
- Хууль, эрх зүйн орчныг зөв бүрдүүлэх,
- Хөрөнгө оруулагчдад санал болгох үнэ цэнийг өрсөлдөхүйц тодорхойлох.

Чөлөөт бүсэд тулгарч буй сорилтыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Тогтвортой хөгжүүлэх,
- Технологийн хурдацтай хөгжил болон дижитал эдийн засагт зохицох,

- Үйлдвэрлэлийн салбарын өөрчлөлтөд зохицох /биет хөрөнгөөс биет бус хөрөнгөрүү хийгдэж буй шилжилт хөдөлгөөн/.

Чөлөөт бус байгуулахдаа дараах харилцааг заавал зохицуулсан байх шаардлагатай. Үүнд:

- Чөлөөт бус байгуулж буй салбарын хууль, дүрэм, журмыг тодорхойлох /Худалдааны бүсэд гааль, худалдааны нөхцөлийг хөнгөлөх дүрэм, журмыг боловсруулах г.м/,
- Хөрөнгө оруулагчдын үйл ажиллагааг хөнгөвчлөх журам /нэг цэгийн үйлчилгээ, хөрөнгө оруулагчдыг хамгаалах системийг боловсруулах, улс төрийн тогтворгүй байдлаас ангид байлгах г.м/,
- Үл хөдлөх хөрөнгө, газрын хууль, тогтоомжийг тодорхой болгох /газар эзэмших, ашиглах эрхийг урт хугацаанд олгох, үл хөдлөх хөрөнгө, газрын татвараас чөлөөлөл г.м/,
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг бий болгох,
- Хөдөлмөрийн харилцаа болон амьдрах орчны хууль, тогтоомжийг боловсруулж, тодорхой болгосон байх зэрэг болно.

Чөлөөт бүсийн оролцогч талууд:

- Засгийн газар-Бодлого, дүрэм, журмыг боловсруулах, түүний хэрэгжилтийг хянах,
- Эрх бүхий байгууллагууд-Стратеги төлөвлөгөө болон түүний үнэлгээг хийх, үйл ажиллагаа явуулах лиценз, тусгай зөвшөөрлийг олгох,
- Бүсийн хөгжүүлэгч-Дэд бүтэц, газар эзэмшигч, ашиглагч /хамгийн чухал оролцогч/
- Бүсийн оператор-Бүсийн хөгжүүлэгч нараас тусдаа байгууллага байж болох бөгөөд дэд бүтцээр хангах, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах,
- Бүсийн хэрэглэгч-Үүсгэн байгуулсан зорилгын дагуу хөрөнгө оруулалт хийж, тухайн бүсэд бизнес эрхэлж байгаа хуулийн этгээд, хувь хүн.

Чөлөөт бүсийн бүтэц, зохион байгуулалт:

Чөлөөт бүсийн бүтэц, зохион байгуулалтын хувьд төрийн, хувийн болон төр, хувийн хэвшлийн хосолмол гэсэн үндсэн 3 загвар байдаг (Зураг 1.2-оос харна уу).

Зураг 1.2. ЧБ-ийн бүтэц, зохион байгуулалтын хэлбэр



Эх сурвалж: World Investment Report (UNCTAD 2019)

Төрийн загварын хувьд системийн бүхий л үйл ажиллагааг төрийн эрх бүхий байгууллага зохион байгуулах бөгөөд зөвхөн бүсийн хэрэглэгчид хувийн хэвшил байдаг. Засгийн газар хууль, дүрэм журам боловсруулах, чөлөөт бүсийг үүсгэн байгуулах үүрэгтэй бол төрийн эрх бүхий байгууллагууд хяналтын үүргийг гүйцэтгэдэг. Төрийн эрх бүхий байгууллагаас байгуулсан бүс хөгжүүлэгч байгууллага нь зөвшөөрөл, лицензийг олгох үүргийг гүйцэтгэдэг.

Хувийн хэвшилд тулгуурласан загварын хувьд Засгийн газар чөлөөт бүсийг үүсгэн байгуулж, хууль, тогтоомж, дүрэм, журмыг боловсруулах үүрэгтэй байхаас гадна бүс хөгжүүлэгч хувийн хэвшлийн байгууллагуудыг сонгон шалгаруулдаг. Бүс хөгжүүлэгч байгууллагууд нь төрийн эрх бүхий байгууллагуудад тайлагнах үүрэгтэй байх ба бүсийн хэрэглэгч нартай гэрээ байгуулсны үндсэн дээр хамтран ажилладаг.

Хосолмол хэлбэрийн хувьд Засгийн газар зөвхөн бүсийг үүсгэн байгуулж, хууль, тогтоомж, дүрэм, журмыг боловсруулах ба төрийн эрх бүхий байгууллагууд бүс хөгжүүлэгчийг сонгон шалгаруулж, бүсийн хэрэглэгчдэд лиценз олгодог. Харин бүс хөгжүүлэгчид төрийн болон хувийн хэвшлийн аль аль нь оролцсон хосолмол хэлбэртэй байх бөгөөд бүсийн хэрэглэгчидтэй гэрээ байгуулсны үндсэн дээр хамтран ажиллана.

Ерөнхийдөө чөлөөт бүсийг амжилттай байгуулахын тулд дараах гол асуудлуудыг анхаарах шаардлагатай байдаг байна. Үүнд:

- Чөлөөт бүсийн хөгжлийн стратегийг эрч хүчтэй, томоор тодорхойлох,
- Өрсөлдөөний давуу талыг бий болгох,
- Хөрөнгө оруулалтын орчин болон засаглалын бүтцийг онцгойлон анхаарах,
- Өөрийгөө санхүүжүүлэх хэлбэрээр зохион байгуулах,
- Дэд бүтэц, чадварлаг хүний нөөц болон бизнесийг дэмжих суурийг бий болгох,
- Хэмжигдэхүйц, тодорхой эдийн засгийн зорилго тавих,
- Үр ашигтай хяналт болон үнэлгээний систем бий болгох,
- Засгийн газар болон институциудын уялдаа холбоог хамгийн дээд түвшинд хангах зэрэг болно.

Чөлөөт бүс нь анх үүсгэн байгуулагдсанаасаа хош худалдааны, үйлдвэрлэлийн, үйлчилгээний, шинжлэх ухаанд суурилсан, эдийн засгийн цогцолбор бүс, хил дамнасан чөлөөт бүс болтлоо хувьсан хөгжиж, эдүгээ улс орнуудын хөгжлийн нэг гарц хэмээн тодорхойлогдох болсон шалтгаан нь өсөн нэмэгдэж буй өрсөлдөөний эрчим байхаас гадна аливаа бодлогын хэрэгжилтийг турших, засаж сайжруулах боломж олгодог давуу талтайн зэрэгцээ зардал багатай байдаг байна.

Чөлөөт бүсийг амжилттай байгуулахын тулд өрсөлдөөний давуу талаа тодорхойлж, түүнд тулгуурласан стратегийг сонгох ба тухайн бүсийн хууль, тогтоомж, дүрэм, журмыг цогцоор нь боловсруулж, хөрөнгө оруулагч нарт аюулгүй орчинг бүрдүүлж өгөх нь чухал байдаг байна. Түүнчлэн тухайн бүсэд ажиллах хүний нөөцийн ур чалвар чухал ач холбогдолтой байдаг тул чадварлаг хүний нөөцийг татах, тогтоон барих цогц бодлого шаардлагатай байдаг байна.

1.2 Санхүүгийн системийн интеграцилал

Дэлхийн 2 дугаар дайнаас хойш дэлхийн эдийн засаг гэх ойлголт бий болж глобалчлал явагдаж эхэлсэн бөгөөд үүнд чөлөөт бүс голлох үүрэгтэй байсан гэж

судлаачид (Meng Guangwen, 2003) үздэг. Дэлхийн эдийн засгийн интеграцичлал дараах 3 үндсэн чиглэлд явагдсан гэж болно. Үүнд:

➤ *Худалдааны либералчлал*

Улс хооронд хийгдэх худалдааны хэмжээ нэмэгдэж, цар хүрээ нь тэлж эхэлсэн нь дэлхийн эдийн засгийн суурь болсон. Худалдаачид худалдааныхаа цар хүрээг нэмэгдүүлэхийн тулд тээвэр, ложистикийн асуудлыг алхам алхамаар шийдвэрлэж, далайн тээврээр хязгаарлагдаж байсан тээврийн асуудлыг төмөр замын сүлжээ байгуулах замаар шийдвэрлэсэн. Улмаар авто машин зохион бүтээснээр авто замын тээвэр үүсэж, агаарын тээвэр ч бий болж, энэ салбар эрчтэй хөгжиж эхэлсэн. Мөн улс хоорондын худалдаа нэмэгдэхийн хирээр худалдааны олон саад бэрхшээлийг шийдвэрлэх шаардлага, хэрэгцээ урган гарч олон улсын институциуд байгуулагдаж эхэлсэн. Өөрөөр хэлбэл нэг улс, эсхүл худалдаачдын түвшинд худалдааны саад, барьерыг арилгах боломжгүй байсан. Иймд Австралийн хамтын нөхөрлөл, Бельгийн Вант Улс, Бүгд Найрамдах Чехословак Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Энэтхэг Улс, Ливан, Люксембургийн Вант Улс, Нидерландын Вант Улс, Шинэ Зеланд тэргүүтэй нийт 24 улс тариф болон худалдааны саад тотгорыг багасгах, түүнчлэн олон улсын худалдаан дахь алагчлах явдлыг арилгахад чиглэсэн адил тэгш нөхцөл бүхий харилцах ашигтай тохиролцоонд хүрэх замаар Тариф, Худалдааны Ерөнхий Хэлэлцээрийг 1947 онд хийсэн бол, 1995 онд Дэлхийн Худалдааны Байгууллага байгуулагдсан. Энэ бүхэн нь худалдааны либералчлал явагдахад нөлөөлсөн байна.

➤ *Аж үйлдвэрийн интеграци*

Худалдааны либералчлал явагдаж худалдааны эргэлт, хэмжээ хурдацтай нэмэгдэж эхэлсэн нь аж үйлдвэрийг хөгжихөд түлхэц болсон. Мөн төмөр замын сүлжээ байгуулагдсан нь хүмүүсийг хол зайнд, богино хугацаанд чөлөөтэй зорчих боломжийг нээж өгсөн. Өрсөлдөөн нэмэгдэхийн хирээр хямд үйлдвэрлэх шаардлага үүсч, зардлаа багасгахын тулд үйлдвэрүүд хямд ажиллах хүчинтэй улсруу нүүж эхэлснээр аж үйлдвэрийн интерграци явагдаж эхэлсэн. Улмаар аж үйлдвэрийн чөлөөт бүсүүд байгуулагдсан.

➤ *Олон улсын санхүүгийн системийн хөгжил*

Худалдааны либералчлалыг дагаад улс хооронд капитал чөлөөтэй урсах саад тотгорыг арилгах шаардлага бий болж, олон улсын санхүүгийн систем үүсч хөгжсөн. Олон улсын валютын систем нь Алтан стандартын валютын системийн үе /1870-1914/, Дэлхийн 1 болон 2-р дайны дараах эмх замбараагүй үе /1915-1943/, Бреттон Вүүдийн валютын системийн үе /1944-1971/, Ямайкын валютын системийн үе /1978 онд үүссэн/ гэсэн түүхэн цаг үеүдэд хуваагддаг. Бреттон Вүүдийн валютын системийн үед АНУ-ын мөнгөн дэвсгэрт болох доллар ноёлох валют болсон бөгөөд одоо ч энэ байр сууриа алдаагүй хэвээр байна. Түүнчлэн 1950 онд Европын улс гүрнүүд нэгдэн нэг зах зээлийг үүсгэж, евро мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргасан. Олон улсын мөнгөний зах зээлд 1989 онд өдөрт дунджаар 590 тэрбум ам.долларын гадаад валютын гүйлгээ хийгдэж байсан бол 1998 онд 1.5 их наяд болж өссөн. Харин хөрөнгийн зах зээлийн гүйлгээ 1992 онд 150 тэрбум ам.доллар байсан бол 1997 онд 3.5 их наяд болж өссөн байна. Мэдээж глобал түвшний институциуд байгуулагдаж эхэлснээс Олон улсын валютын сан, Дэлхийн банк болон Олон улсын гүйлгээний банк нь голлох үүрэгтэй институци юм.

➤ *Санхүүгийн чөлөөт бүс*

Олон улсын санхүүгийн системийн үүсэл, хөгжлийн төвд тухайн үеийн худалдааны эргэлтэд томоохон байр суурийг эзэлж байсан хотууд байршин, өнөөдрийг хүртэл тэргүүлэгчийн байр сууриа хадгалан түүчээлэгч нь болсоор байна. Дээр дурдсанчлан чөлөөт бүсийн хөгжилд тээвэр, ложистик чухал ач холбогдолтой юм. Эхэн үед боомт түшиглэсэн худалдаа цэцэглэн хөгжиж байсан бол 1800-аад оны дунд үеэс төмөр замын бүтээн байгуулалт өрнөж, зөвхөн далайн эргийн боомтоор хязгаарлагдахгүйгээр эх газарт ч худалдаа, наймаа хийх өргөж боломж нээгдсэн. Хамгийн анхны төмөр зам 1825 онд Английн хойд хэсэгт Стоктон болон Дарлингтон хотын хооронд тавигдсан бол 1830 онд нилээд хэдэн төмөр зам шинээр ашиглалтад орсон. 1875 он гэхэд Их Британы төмөр замын сүлжээний 70 хувь нь бүрэн ашиглалтад орсон байна. Харин Франц, Герман, Америк зэрэг улсууд 1840-өөд оны дунд үеэс төмөр замын бүтээн байгуулалтыг хийж эхэлсэн. Нэг талаас төмөр зам нь хол замыг богино хугацаанд туулах боломжтой болгосноор хүмүүст хот хооронд, улс хооронд чөлөөтэй зорчих боломжийг нээж өгсөн бол, нөгөө талаас хөрөнгийн зах зээлд өмнө нь байгаагүй асар өндөр үнийн дүнтэй төмөр замын хөрөнгө оруулалтын үнэт цааснууд гүйлгээнд гарсан. Энэ бүхнийг тойроод Лондон, Парис, Берлин, Амстердам, Нью-Йорк, Швейцарь зэрэг олон улсын санхүүгийн системд нөлөө бүхий хотууд бий болсон. Өөрөөр хэлбэл түүхэн цаг үе эдгээр хотуудыг дэлхийн хэмжээний санхүүгийн төв болгож өгсөн. Харин ийм түүхэн боломж тохиогоогүй бусад орны хувьд санхүүгийн чөлөөт бүс байгуулах замаар дотоодын санхүүгийн салбарыг хөгжүүлэхээс гадна бүс нутгийн болон олон улсын хэмжээний санхүүгийн төв болох зорилгыг урдаа тавин өрсөлдөж байна.

Ази тивд 1960-аад оны сүүл үеэс санхүүгийн чөлөөт бүс байгуулагдаж эхэлсэн ба тэдгээрийн нэг нь Сингапур юм. Сингапур улс нь 1968 онд гадаадын банк өөрсдийн оффшор салбарыг байгуулахыг зөвшөөрөх замаар олон улсын санхүүгийн төв болох эхлэлээ тавьсан. 1978 онд Хонг Конг, 1986 онд Токиод Японы оффшор зах зээлийг үүсгэн байгуулснаар олон улсын санхүүгийн төв байгуулах эхлэл тавигдсан. Эдгээрийн араас Тайпэй, Бангкок, Лабуан зэрэг хотууд мөн адил олон улсын санхүүгийн төвийг байгуулсан.

Санхүүгийн төв гэдэг нь санхүүгийн системийн зуучлагчид болох банк, хөрөнгийн менежмент, даатгал, хөрөнгийн зах зээл болон тэдгээрийг дэмжигч болох хууль, нягтлан бодох бүртгэл гэх мэт бусад дагавар үйлчилгээнүүдийг цогцоор нь нэг газарт шийдэж санхүүгийн бүхий л үйлчилгээг өргөн цар хүрээтэй үзүүлэгч газарзүйн байршил буюу хот, улсыг хэлнэ. Түүнчлэн санхүүгийн төв нь үйлчилгээнд суурилсан чөлөөт бүс бөгөөд хэлбэрийн хувьд нээлттэй байж болдог.

Олон улсын валютын сан санхүүгийн төвүүдийг дараах 3 ангилалд хуваасан байдаг. Тухайн санхүүгийн төвийн онцлогоос шалтгаалаад энэхүү ангиллын аль алинд нь багтах тохиолдол байж болдог. Жишээлбэл: Хонг Конг нь бүс нутгийн санхүүгийн төв боловч оффшор санхүүгийн төв ангилалд мөн ордог байна.

- *Олон улсын санхүүгийн төв*-Олон улсын түвшинд цогц үйлчилгээ үзүүлдэг, хөрвөх чадвар сайтай, хууль, эрх зүйн системийн хүрээнд талуудын тэгш эрхийг адил, тэнцүү хангасан байхаас гадна ерөнхийдөө оршин суугч бус этгээдээс богино хугацаатай зээллэг авч, оршин суугч бус этгээдэд урт хугацаанд зээлэх үйл

ажиллагаа эрхэлдэг. Лондон, Нью-Йорк, Токио хотууд энэ төрлийн санхүүгийн төвд багтдаг.

- *Бус нутгийн санхүүгийн төв*-Олон улсын санхүүгийн төвтэй адил санхүүгийн зах зээл, дэд бүтэц, дундын зуучлагч нарыг нэг дор цуглуулсан боловч түүнтэй харьцуулахад зах зээлийн эргэлт, хэмжээ харьцангуй бага байдаг. Жишээлбэл: Хонг Конг, Сингапур, Люксембург.
- *Оффшор санхүүгийн төв*-Харьцангуй жижиг зах зээл бөгөөд нэг чиглэлд тусгайлан үйлчилгээ үзүүлдэг. Гэсэн хэдий ч ур чадвартай хүний нөөц, санхүүгийн системийн зуучлагч нарыг нэг дор цуглуулсан байхаас гадна онцгойлон татварын таатай орчинг бүрдүүлсэн байдаг. Оффшор бүсийн хамгийн гол ялгаа нь оршин суугч бус этгээдэд үйлчилдэг бөгөөд тухайн бүсэд бизнес эрхлэгчдийн мэдээлэл нууц байдаг.

Санхүүгийн төвүүдийг 2007 оноос эхлэн хагас жил тутам Лондонд байрлах Z/Yen бодлогын судалгааны хүрээлэн Шинженд байрлах Хятадын хөгжлийн институты бодлогын судалгааны хүрээлэнтэй хамтран үнэлдэг болсон. Хамгийн сүүлд 2023 оны 9 сард Дэлхийн санхүүгийн төвийн 34 дэх индекс хэвлэгдэн гарсан ба нийт 121 санхүүгийн төвийг өрсөлдөх чадвараар нь үнэлж, эрэмбэлсэн байна (Хүснэгт 1.4, 1.5-аас харна уу).

Хүснэгт 1.4. Дэлхийн Топ 10 ОУСТ

Нэр	Ранг	
Нью Йорк	1	Топ 10 санхүүгийн төвийн 5 нь АНУ-д байрлаж байгаа бол Хятадын тэргүүлэх төвүүд байраа тогтвортой хадгалсан дүр зурагтай байна.
Лондон	2	
Сингапур	3	
Хонг Конг	4	
Сан Франциско	5	
Лос Анжелес	6	
Шанхай	7	
Вашингтон ДС	8	
Чикаго	9	
Женев	10	

Эх сурвалж: Global International Financial Center Index 34, Z/Yen

Хүснэгт 1.5. Ази-Номхон далайн бүс нутгийн Топ 15 ОУСТ

Нэр	Ранг	
Сингапур	3	Ирэх 2-3 жилд ач холбогдол нь өсөх санхүүгийн төвийг санал асуулгаар тодруулахад 15-аас 7 нь Ази номхон далайн бүс нутагт байрлаж байна.
Хонг Конг	4	
Шанхай	7	
Сөүл	11	
Шинжен	12	
Бээжин	13	
Токио	20	
Сидней	22	
Гуанжоу	29	
Чиндао	32	
Бусан	33	
Мелбурн	39	
Осака	43	
Чэндү	44	
Веллингтон	56	

Эх сурвалж: Global International Financial Center Index 34, Z/Yen

Энэхүү үнэлгээ нь 2 үе шаттай хийгддэг. Эхний үе шатанд өөрсдийн вэб сайтаар дамжуулан цахимаар санал асуулга авч, 0-10 хүртэл үнэлгээгээр үнэлүүлэх бөгөөд 2 дахь шатанд нийт 147 байгууллагын судалгааны үр дүнд суурилан 5 бүлэг хүчин зүйлсийг хүчин зүйлсийг үнэлэх моделийн арга /factor assessment model/ -ыг ашиглан, хиймэл оюун ухаанаар үнэлдэг (Хүснэгт 1.6-аас харна уу).

Хүснэгт 1.6. Үнэлгээний хүчин зүйлс



Эх сурвалж: Global Finance Center Index 34 (Z/Yen, 2023)

Өрсөлдөх чадварыг үнэлэх цахим санал асуулгад оролцогсад өрсөлдөх чадварыг үнэлэхэд хамгийн чухал хүчин зүйлсэд дараах байдлаар хариулжээ (Z/yen, 2023):

Бизнесийн орчин	Авилгаас ангид байдал. Бизнес эрхлэх зардал. Тогтвортой, уян хатан хууль, эрх зүйн систем бизнес эрхлэх итгэлийг өсгөдөг. Шүүхийн систем мөн чухал хүчин зүйл.
Хүний нөөц	Шаардлагатай ур чадварыг эзэмшсэн хүний нөөцтэй байх. Байнга хөгжих боломжтой байх.
Дэд бүтэц	Дижитал дэд бүтцийн ач холбогдол хурдацтай өсөж байна. Байр орон сууц, чөлөөт цаг өнгөрүүлэх газар, тээвэр бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, агаарын тээвэртэй байх чухал
Татвар	Татвар нь мөнгөний үнэ цэнэтэй харьцуулахад бага ач холбогдолтой байна. Тодорхой, ил тод бизнесийн зардлаа тооцоход ойлгомжтой татварын системтэй байх нь чухал.
Нэр хүнд	Санхүүгийн тогтвортой байдал, эрх зүйн систем, улс төрийн тогтвортой байдал, уламжлалт болон уян хатан системтэй байх нь нэр хүндийг бүрдүүлж буй гол хүчин зүйл.
Санхүүгийн секторын хөгжил	Инноваци, чадварлаг хүний нөөцийг татах гол хүчин зүйл нь санхүүгийн үйлчилгээний цогц байдал юм. Хэрэглэгчдийн итгэлийг өсгөхийн тулд санхүүгийн секторыг тогтвортой хөгжүүлэх чухал.


Олон улсын худалдаа, дэлхийн интеграцилал нь олон улсын санхүүгийн зах зээлийн үүсэл хөгжилд чухал нөлөө үзүүлж, улмаар олон улсын санхүүгийн төв болон санхүүгийн чөлөөт бүсийг үүсгэсэн байна. Олон улсын санхүүгийн төвүүдийг үнэлэхдээ өрсөлдөх чадварын хувьд эрэмбэлэх ба бизнесийн орчин, хүний нөөцийн ур чадвар, нэр хүнд, татвар, санхүүгийн сектор гэсэн таван бүлэг үзүүлэлтээр үнэлдэг байна.

1.3 Үндэстний өрсөлдөх давуу талын онол буюу Майкл Портерын Даймонд загвар

Судлаачид аливаа зах зээлийн хөгжлийн гарцыг тодорхойлохдоо Даймонд загварыг ашиглан өрсөлдөх чадавхийг тогтоож, түүнд сурилсан хөгжлийн стратегийг боловсруулдаг аргыг түгээмэл ашигладаг нь судлагдсан байдлын судалгаа болон онолын судалгаа хийж байх явцад ажиглагдсан билээ. Тухайлбал, Флоридагийн Их Сургуулийн судлаач оюутан Магпантэй Жосеф “Майкл Портерын Даймонд загварт суурилсан Санхүүгийн төвийн өрсөлдөх чадварын онолын шинжилгээ”, Тайландын Чан Май Их сургуулийн Бизнес удирдлагын тэнхимийн багш, судлаач Ситонг Поммачит болон Пидагон Танитбенжасит нар нь “Луан Прабанк эдийн засгийн тусгай бүсийн өрсөлдөх чадварыг Даймонд загвараар шинжлэх нь” судалгааны бүтээлдээ тус тус үндэстний өрсөлдөх чадварын давуу талын онол арга зүйг ашиглан Даймонд загвараар чөлөөт бүсийн өрсөлдөх чадварыг үнэлсэн байна. Монгол улсын хувьд “Ноолуурын салбарын кластерыг хөгжүүлж олон улсын зах зээлд нэвтрэх нь” сэдвээр МУИС-ын багш, судлаач Ц.Цолмон, Ч.Батбаатар нар Даймонд загварыг ашиглан судалгаа хийсэн байна. Энэхүү загвар нь нийт 4 бүлэг, 19 хүчин зүйлсийг шинжлэн судалж, тухайн улс үндэстний, эсхүл зах зээлийн, салбарын өрсөлдөх чадварын давуу тал болон сул талыг тодорхойлдог. Ингэснээр тухайн судалгааны зүйлийн давуу талд тулгуурлан хөгжлийн стратегийг боловсруулах боломжтой болдог байна.

Судлаач миний хувьд эдгээр хүчин зүйлсийг хоёрдогч өгөгдөлд тулгуурлан шинжлэн судалж, Монгол Улсын санхүүгийн секторын өрсөлдөх чадварын давуу болон сул талыг тодорхойлох замаар санхүүгийн төв байгуулах боломжтой эсэхийг тогтоохыг зорьж байгаа болно.

Зураг 1.3. Үндэстний өрсөлдөх давуу талын онол буюу Даймонд загвар



Эх сурвалж: М.Портер, 1990

Эх сурвалж: Банк, санхүүгийн үндэс, Г.Балж 2016

Даймонд загварын дагуу үнэлэх хүчин зүйлс:

А. Стратеги, бүтэц, өрсөлдөөн

1. Ерөнхий бизнесийн орчин /4 хүчин зүйл/

- Эдийн засгийн орчин
- Бизнесийн зардал
- Татварын тогтолцоо

- Бизнесийн орчны хууль, тогтоомж
2. Капиталын хөдөлгөөн /3 хүчин зүйл/
 - Капиталын хөдөлгөөн дэх хяналт бага эсэх
 - Валютын хөрвөх чадамж байгаа эсэх
 - Мөнгөний ханш тогтвортой эсэх
 3. Зах зээлд шинээр нэвтрэх /3 хүчин зүйл/
 - Гадаадын банк, фирм, банк бус санхүүгийн байгууллага зах зээлд шинээр нэвтрэхэд саад байгаа эсэх
 - Ирээдүйд зах зээлд шинээр нэвтрэхэд саад үүсэх эсэх
 - Чадварлаг мэргэжлийн хүчний нөөц ирж ажиллахад саад бий эсэх
 4. Хууль тогтоомжийн тэнцвэрт байдал /3 хүчин зүйл/
 - Хяналтын тогтолцоо нь талуудын тэнцвэрийг хангасан эсэх
 - Хууль тогтоогч нар асуудлыг шийдвэрлэдэг эсэх
 - Хялбар, уялдаа холбоотой хууль, эрх зүйн бүтцийг бий болгосон эсэх
 5. Хууль, эрх зүйн орчин /3 хүчин зүйл/
 - Нийтийн эрх зүйн системтэй эсэх
 - Олон улсын гэрээ конвенцид нэгдсэн эсэх
 - Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны тухай хуулийн уян хатан өөрчлөлт, шинэчлэлт хийгддэг эсэх
 6. Дотоодын өрсөлдөөн /2 хүчин зүйл/
 - Нэгдэж, нийлэх эрх олгогдсон эсэх
 - Үр ашигтай өрсөлдөөний эсрэг бодлого, хууль тогтоомжтой эсэх

В. Хүчин зүйлсийн нөхцөл байдал

1. Хүний нөөц /3 хүчин зүйл/
 - Санхүүгийн секторын өндөр ур чадвартай хүний нөөц байгаа эсэх
 - Санхүүгийн секторын ажилтануудыг дэмжих судалгаа, шинжилгээ, технологийн чадварлаг баг байгаа эсэх
 - Төслийн удирдлага, координаторын чиглэлийн ур чадвартай хүний нөөц байгаа эсэх
2. Хууль, эрх зүйн орчны дэд бүтэц /3 хүчин зүйл/
 - Бизнесийн орчинд засгийн газрын оролцооны түвшин бага эсэх
 - Эдийн засгийн тогтвортой өсөлттэй эсэх
 - Засгийн газар болон эрх зүйн процесс ил тод, шилэн эсэх
3. Мэдээлэл, харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэд бүтэц /3 хүчин зүйл/
 - Найдвартай харилцаа холбооны систем байгаа эсэх
 - Өндөр хурдны интернэт байгаа эсэх
 - Дэлхийд өрсөлдөхүйц мэдээллийн технологийн хэрэглээний мэдлэгтэй эсэх
4. Амьдралын чанар /3 хүчин зүйл/
 - Олон улсын хэлний хэрэглээтэй эсэх
 - Нийгэм, соёлын арга хэмжээ, чөлөөт цаг өнгөрүүлэх олон төрлийн үйл ажиллагаа явагддаг эсэх
 - Улс төр болон нийгмийн байдал тогтвортой эсэх
5. Барилга байгууламж, нийтийн тээврийн дэд бүтэц /3 хүчин зүйл/

- Үнэтэйгээ дүйцэхүйц чанартай оффис болон амьдран суух зориулалтай үл хөдлөх байдаг эсэх
 - Чанартай авто зам болон нийтийн тээврийн системтэй эсэх
 - Олон улсын болон бүс хоорондын тээвэр, ложистикийн системтэй эсэх
6. Газарзүйн байршлын давуу тал /2 хүчин зүйл/
- Түүхэндээ худалдааны төв болж байсан эсэх
 - Дэлхийн зах зээлийн ажлын өдрүүдтэй давхацдаг эсэх

С. Эрэлтийн нөхцөл байдал

1. Дотоод эдийн засгийн орчин /3 хүчин зүйл/
 - Эдийн засгийн өсөлттэй бүсэд байдаг эсэх
 - ДНБ тогтвортой өсдөг эсэх
 - Инфляцийн түвшин бага эсэх
2. Капиталын эх үүсвэр /2 хүчин зүйл/
 - Үнэт цаас болон хадгаламжийн зуучлалын хэрэгцээ өсч байгаа эсэх
 - Хөрөнгө оруулалтад зарцуулах илүүдэл нөөц байгаа эсэх
3. Дотоодын хэрэглэгч /3 хүчин зүйл/
 - Нэг хүнд ногдох орлогын түвшин өндөр эсэх
 - Бичиг үсэг тайлагдсан байдал өндөр эсэх
 - Эдийн засаг болон санхүүгийн мэдээллийн урсгал чөлөөтэй эсэх
4. Дотоод зах зээл болон оролцогчдын уян хатан байдал /2 хүчин зүйл/
 - Санхүүгийн бус үндэстэн дамнасан корпорациуд байдаг эсэх
 - Цагаан захтнуудад зориулсан ажлын байр элбэг эсэх

Д. Холбоотой болон дэмжих салбарууд

1. Дэлхийн зах зээлийн интеграцичлалын нөлөөний цар хүрээ /3 хүчин зүйл/
 - Дотоодын хөрөнгө оруулагчид дэлхийн хөрөнгийн зах зээлд оролцдог эсэх
 - Олон улсын хөрөнгө оруулагчид дотоодын хөрөнгийн зах зээлд оролцдог эсэх
 - Олон улсын стандарт болон сайн туршлагыг нэвтрүүлсэн эсэх
2. Дэмжигч секторуудын өсөлт /3 хүчин зүйл/
 - Олон улсын хууль болон нягтлан бодлох бүртгэлийн үйлчилгээний төв байдаг эсэх
 - Инноваци, мэдээллийн технологийн сектор байгаа эсэх
 - Хамгийн сүүлийн үеийн харилцаа холбооны хүчин чадалтай эсэх
3. Хамааралтай секторуудын чанар /4 хүчин зүйл/
 - Мэдлэг болон боловсролын өндөр чанартай институцитай эсэх
 - Олон улсын санхүүгийн байгууллагууд байдаг эсэх
 - Эрүүл мэнд, аялал жуулчлал, аялал зугаалгын сектор хөгжсөн эсэх
 - Тогтвортой тээвэр, ложистикийн сектор байгаа эсэх

Улс орон болгон эдийн засгаа тэлэхийн тулд янз бүрийн арга ашигладаг бөгөөд тэдгээрийн нэг нь чөлөөт бүс юм. ЧБ тухайн улсад өөрийн давуу талдаа суурилсан эрчимтэй эдийн засгийн бодлого, тэлэлтийг хэрэгжүүлэх боломжийг, бодлогын арга хэрэгслийг бага зардлаар, бага эрсдэл хүлээн турших, сайжруулах боломжийг олгодог.

Мөн тухайн бодлогыг улс орны түвшинд хэрэгжүүлэх боломжгүй ч, тодорхой хязгаарлагдсан нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэгжүүлэх замаар бүс нутгийн болон дэлхийн зах зээлтэй интеграцид орох, дотоодын эдийн засгийг хамгаалах боломжийг олгодог нь түүний гол давуу тал юм.

Бүлгийн дүгнэлт

Тэртээ 15 дугаар зууны эхэн үеэс үүсэлтэй энэхүү аргыг улс орнууд өргөнөөр ашиглах болсныг 2014 оноос хойш 1000 гаруй чөлөөт бүс шинээр байгуулагдснаас харахад тодорхой байна. Ийнхүү түгээмэл ашиглах болсон нь шинэ тутам үүсч буй чөлөөт бүсийг амжилттай байгуулах, тогтвортой хөгжүүлэхэд сорилт болж байгаа юм. Тийм ч учраас чөлөөт бүс байгуулах арга замыг сонгох шийдвэрийг гаргахдаа тухайн чөлөөт бүсийн өрсөлдөх чадварыг тодорхойлох, давуу тал дээрээ тулгуурласан бодлого, зорилго, зорилтыг дэвшүүлэх шаардлага зайлшгүй үүсдэг.

Хөгжлийн стратегийг тодорхойлохдоо түгээмэл ашигладаг нэг арга нь Майкл Портерын Даймонд загвар байх бөгөөд уг загварын хүрээнд 4 бүлэг 19 хүчин зүйлсийг үнэлж тухайн судалгааны зүйлийн давуу болон сул талыг тодорхойлдог байна. Өөрөөр хэлбэл, уг загвар нь өрсөлдөөнд давуу тал олгох гол хүчин зүйлсийг тодорхойлж өгдөг байна.

Анх далайн тээвэрт түшиглэн худалдаа, арилжаа хийгдэх болсноор боомт хотууд үүсч, улмаар тухайн боомт хотууд зөвхөн худалдаачдад зориулж худалдааг хөнгөвчлөх бодлогыг хэрэглэж эхэлснээр худалдааны чөлөөт бүс үүссэн бөгөөд өнөөдөр улс орнууд энэхүү чөлөөт бүсийг худалдааны, үйлдвэрлэлийн, бүс нутгийн гээд олон төрөл янзаар үүсгэн байгуулж, хөгжүүлэн өөрсдийн эдийн засаг, хөгжлийн нэг арга хэлбэр болгон өргөн ашиглах болсон байна. Монгол Улсын хувьд энэхүү аргыг хэрэглэн чөлөөт бүс байгуулахыг эрмэлзээд даруй 30 орчим жилийг үдээд байгаа ч, амжилт төдийлөн харагдахгүй байгаа нь тухайн бүс нутгийн хэмжээнд тодорхой тоон зорилт дэвшүүлээгүй, чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах салбарын бодлогыг цогцоор нь шийдвэрлээгүй, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлээгүй, дэд бүтэц хангалттай байхгүй зэрэг шалтгаантай байгааг судлаачид өөрсдийн судалгааны бүтээлээрээ тодорхойлсон байна.

Нөгөө талаас, олон улсын худалдааны либерчлалаас үүдэлтэй олон улсын санхүүгийн салбарын интеграцид улс орнуудын хувьд зөвхөн дотоодын санхүүгийн салбарыг хөгжүүлэх бус, бүс нутаг болон дэлхийн түвшинд санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлэгч болох хүсэл эрмэлзлийг бий болгосон. Олон улсын санхүүгийн зах зээлийн эхэн үед худалдааны эргэлт, эдийн засгийн хүчин чадлын хувьд нөлөө бүхий байсан улс орнуудын томоохон хотуудад дэлхийн санхүүгийн төв болох боломж тохиосон бол, бусад улс орны хувьд санхүүгийн чөлөөт бүс байгуулах замаар олон улсын санхүүгийн зуучлагч болон хөрөнгө оруулагч нарыг татах таатай нөхцөлийг бүрдүүлж, бүс нутгийн хэмжээний санхүүгийн зуучлагч болох, цаашилбал глобал түвшинд хүрэх амбицтай бодлого боловсруулан, зарим нь уг зорилгодоо хүрсэн байгааг Сингапур, Хонг Конг, Токиогийн жишээнээс харж болохоор байна.


II БҮЛЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

2.1 Монгол улсын санхүүгийн салбарын өнөөгийн байдал

Өмнөх бүлгийн хүрээнд чөлөөт бүсийн тухай ойлголт болон түүний арга хэлбэрийг дэлгэрэнгүй тайбарласан. Харин энэ бүлгийн хүрээнд МУ-ын санхүүгийн зах зээлийн нөхцөл байдлыг судална.

Санхүүгийн системийг ерөнхийд нь санхүүгийн бодит харилцаа, үйл явцыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцлийг бий болгогч санхүүгийн нөөцийг бүрдүүлэх эх үүсвэрийн хуваарилалт, санхүүгийн арга хэрэгслүүд, тэдгээрийг чиглэсэн зорилготойгоор санхүүгийн харилцаа болон үйл явцад оролцогч нарын харилцан шүтэлцээ холбоо бүхий субъектүүдийг цогц гэж ойлгож болно (Г.Балж, 2016). Товчхондоо, санхүүгийн систем нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй хэсгээс мөнгөн хөрөнгийн дутагдалтай хэсэг рүү санхүүжилт хийгдэх үйл ажиллагааг явуулдаг. Санхүүгийн систем нь дараах бүтэцтэй (Зураг 2.1-ээс харна уу).

Зураг 2.1. Санхүүгийн системийн бүтэц



Эх сурвалж: Г.Балж, Санхүүгийн системийн үндэс, 2016

Санхүүгийн салбарыг хөгжүүлнэ гэдэг нь уг системийн оролцогч нарын тэнцвэрийг ханган цогцоор нь хөгжүүлэх тухай ойлголт юм. Монгол улсын санхүүгийн систем нь банкны салбарт төвлөрсөн бүтэцтэй бөгөөд 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар санхүүгийн системд нийт 12 банк, 514 банк бус санхүүгийн байгууллага, 191 хадгаламж зээлийн хоршоо, 18 даатгалын компани, 64 даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч 25 компани үйл ажиллагаа явуулж байна. Банкнаас бусад санхүүгийн салбарын үйл ажиллагааны цар хүрээ жилээс жилд нэмэгдэж буй боловч санхүүгийн системд банкны салбартай харьцуулахад харьцангуй бага хувийг эзэлсэн хэвээр байгаа юм. Тодруулбал, 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар санхүүгийн системийн нийт хөрөнгийн 8.8 хувийг банкнаас бусад санхүүгийн салбарын хөрөнгө бүрдүүлж байна (Хүснэгт 2.1-ээс харна уу).

Хүснэгт 2.1. Санхүүгийн салбарын голлох үзүүлэлт /2023 оны Гуулингийн байдлаар/

Үзүүлэлтүүд	Банк	ББСБ	ХЗХ	Даатгал
Нийт хөрөнгө	46,402.5	3,702.1	274.5	486.9
Өр төлбөр	41,373.8	1,385.7	215.2	271.7
Эзэмшигчдийн өмч	5,028.7	2,316.4	59.3	215.2
Зээлийн өрийн үлдэгдэл	21,162.4	2,864.0	212.5	
Чанаргүй зээл	2,218.5	228.0	7.5	
Тайлант үеийн ашиг	281.5	99.6	1.7	3.7
Даатгалын хураамжийн орлого				76.2
Даатгалын нөхөн төлбөр				26.9

Эх сурвалж: Монгол банк, СЗХ, 2024 оны мөнгөний бодлогын үндсэн чиглэл

Цаашид санхүүгийн салбарын бусад зуучлагч нар болох тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын банкуудыг нэмэгдүүлэх, банкны салбарын төвлөрлийг бууруулах, санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн зах зээлийг хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тулгараад удаж байна. Санхүүгийн системийн салбар тус бүрийн нөхцөл байдлыг товч дурдвал:

Банкны салбар:

Монгол улс өөрийн гэсэн үндэсний банк байгуулахад тусламж үзүүлэх талаар хүсэлтийг хаант Оросын засгийн газарт тавьж, тохиролцоонд хүрсний үндсэн дээр “Монголын үндэсний банк” гэдэг нэрээр Сибирийн худалдааны банкны салбарыг нийслэл хотод 1914 онд байгуулсан. Тус банк нь 1915-1917 онд нилээд эрчимтэй үйл ажиллагаа явуулж байсан боловч 1919 онд хаагдсан. Улмаар 1924 онд Монгол-Зөвлөлтийн хамтарсан “Монголын худалдаа аж, үйлдвэрийн банк”-ыг байгуулснаас үзэхэд, Монгол улсын банк, санхүүгийн салбарын үүслийг 1924 оноос эхлэн тооцож болохоор байна.

1990 он хүртэл Монгол улсад нэг шатлалт, монополь банкны систем үйлчилж байсан бөгөөд ардчилсан засаглалд шилжсэнээр “Аж ахуйн банк байгуулах болон түүний үйл ажиллагааны нийтлэг дүрэм”, “Банкны тухай хууль” батлагдан, 2 шатлалт банкны систем рүү шилжсэн түүхтэй. Банкны салбарын хувьд санхүүгийн секторын дийлэнх буюу 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар системийн нийт хөрөнгийн 91.2 хувийг дангаараа бүрдүүлж байна. Банкны салбарт нийт 12 банк идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа ба 2023 оны 2 дугаар улирлын байдлаар зээлийн багцын чанар аажмаар сайжирч, нийт зээлийн 9 хувь нь чанаргүй зээл эзэлж байна (Зураг 2.2-оос харна уу).

Зураг 2.2. Зээлийн багцын чанарын үзүүлэлт



Эх сурвалж: Банкны салбарын тойм (Банк, санхүүгийн академи, 2023)


Мөн системийн нийт актив өмнөх оны мөн үеэс 11 хувь өсөж, нийт эх үүсвэр 3.2 их наядаар нэмэгдэн, өөрийн хөрөнгийн өгөөж дунджаар 10 хувьтай байна.

Банк бус санхүүгийн байгууллагын салбар

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар СЗХ-ны тусгай зөвшөрөл бүхий 514 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа ба үүнээс 39 нь финтек зээлийн үйл ажиллагаа явуулж байна. Салбарын голлох үзүүлэлтүүдийг авч үзвэл нийт хөрөнгийн хэмжээ 3.7 их наяд төгрөг, зээлийн хэмжээ 2.9 их наяд төгрөг, өр төлбөр 1.4 их наяд төгрөг, эздийн өмч 2.3 их наяд төгрөг, тайлант үеийн ашиг 99.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс харгалзан 24.5 хувь, 24.9 хувь, 25 хувь, 24.2 хувь болон 26.6 хувиар тус тус нэмэгджээ (Зураг 2.3, 2.4-өөс харна уу).

Зураг 2.3. ББСБ-нийт хөрөнгө, зээлийн дүн, эздийн өмчийн дүн /тэрбум₮/ ба өсөлт

Зураг 2.4. ББСБ-ын өр төлбөр /тэрбум₮/ ба өсөлт



Эх сурвалж: Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл, МБ

ББСБ-ын нийт зээлийн үлдэгдлийн 87.9 хувийг буюу 2.5 их наяд төгрөгийн хэвийн зээл, 4.4 хувийг буюу 125.9 тэрбум төгрөгийн анхаарал хандуулах зээл, 8 хувийг буюу 228 тэрбум төгрөгийн чанаргүй зээлийн үлдэгдэл тус тус бүрдүүлж байна. 2023 оны эхний улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ харгалзан 0.5 нэгж хувиар буурсан бол анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 0.5 нэгж хувь болон 0.4 нэгж хувиар өссөн дүнтэй байна. Түүнчлэн ББСБ-ын нийт харилцагчдын 94.1 хувь буюу 3,633 мянган хүн, нийт зээлдэгчдийн 84.6 хувь буюу 1,097 мянган хүн финтек буюу онлайн зээлийн үйлчилгээ үзүүлж буй ББСБ-уудын харилцагчид эзэлж байна. СЗХ-ноос финтек зээлийн хэт өсөлтийг хязгаарлах, иргэд, өрхүүдийн өрийн дарамтыг бууруулах зорилгоор ББСБ-ын финтек зээлийн бүтээгдэхүүнд өр, орлогын харьцаа тогтоосон бөгөөд тус зохицуулалт нь 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлээд байна.

Хөрөнгийн зах зээл

1991 оны 1 дүгээр сарын 18-нд Монгол Улсын Засгийн газар Монголын хөрөнгийн бирж байгуулах шийдвэрийг гаргасан бөгөөд энэ үеэс эхлэн хөрөнгийн зах зээлийн түүхийг бичиж эхэлсэн. Энэхүү тогтоолоор өмч хувьчлалыг эхлүүлж, цаашид хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх эхлэлийг тавьсан. Түүнчлэн тус онд Улсын Бага Хурлаас “Аж ахуйн нэгжийн тухай”, “Өмч хувьчлах тухай” хуулийг тус тус баталсан. 1994 онд “Үнэт цаасны тухай” хууль батлагдаж, Үнэт цаасны хороо байгуулагдсан бол 2002 онд “Үнэт цаасны зах зээлийн тухай” хууль шинэчлэгдэн батлагдаж, үнэт цаасны арилжаа болон хуулиар хориглогдоогүй бусад ажил үйлчилгээ эрхлэх чиг үүрэг бүхий ТӨХК болгон МХБ-ийг, “Төлбөр тооцоо, хадгаламжийн алба”-ыг харилцагчдын мөнгөн хөрөнгийн гүйлгээ, үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх чиг үүрэг бүхий “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” төрийн өмчийн ХХК болгон шинэчлэн зохион байгуулсан (Хүснэгт 2.2-оос харна уу).

Хүснэгт 2.2. МУ-ын Хөрөнгийн зах зээлд болсон үйл явдлын он цагийн дараалал

№	Огноо	Үйл явдал
1	1991.01.18	МУ-ын ЗГ-ын 22 тогтоол: “МХБ”-ийг байгуулав.
2	1991.05.22	Өмч хувьчлалын тухай хуулийг батлав.
3	1992.02.07	Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа хийгдэв.
4	1994.09.26	Үнэт цаасны тухай хуулийг батлав.
5	1994.11.14	МУ-ын Үнэт цаасны хороо байгуулагдав.
6	1995.07.01	Үнэт цаасны компаниудын хувьчлал эхлэв.
7	1995.07.31	Монгол Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо байгуулагдав.
8	1995.08.28	Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн анхны арилжаа хийгдэв.
9	1996.10.25	ЗГ-ын хямдруулсан бондын анхны арилжаа хийгдэв.

10	1998.10.01	МХБ Евро Азийн хөрөнгийн биржүүдийн холбоонд элсэв.
11	1999.07.02	Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлав.
12	1999.11.01	Нэгдсэн индексийг тооцож эхлэв.
13	2001.06.08	Компанийн бондын анхны арилжаа хийгдэв.
14	2002.12.03	МХБ Тайванийн хөрөнгийн биржтэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав.
15	2002.12.12	“Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг батлав.
16	2003.03.26	МУ-ын ЗГ-ын 72 тоот тогтоолоор МХБ-ийг ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулав.
17	2004.10.29	Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг анхны компанид олгов.
18	2005.03.30	МХБ-ийн мэдээллийн төв байгуулагдав.
19	2005.05.25	Анхны IPO хөрөнгийн зах зээлд гарав.
20	2005.10.31	МХБ-ийн сургалтын төв байгуулагдав.
21	2005.11.02	“Хувьцаа эзэмшигч” үзлэгийг зохион байгуулж эхлэв.
22	2005.11.17	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг батлав.
23	2006.01.25	МУ-ын СЗХ байгуулагдав.
24	2006.03.30	Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах өдөр бий болгон жил бүр уламжлал болгон тэмдэглэж эхлэв.
25	2006.06.15	МХБ Солонгос улсын хөрөнгийн биржтэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав.
26	2006.07.19	МХБ Станбулын хөрөнгийн биржтэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав.
27	2006.12.26	СЗХ-оос 2007 оны Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн жил болгон зарлав.
28	2008.03.05	“Блүүмберг” агентлагтай мэдээлэл дамжуулах гэрээ байгуулав.
29	2008.04.10	МХБ Ази, далайн орнуудын хөрөнгийн биржүүдийн холбоонд гишүүнээр элсэв.

30	2008.04.10	МБХ Сингапурын хөрөнгийн биржтэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав.
31	2008.05.15	МХБ Токиогийн хөрөнгийн биржтэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав.
32	2009.03.17	МХБ Москвагийн банк хоорондын валютын биржтэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав.
33	2010.01.15	МХБ Улаанбаатар хоттой хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурав.
34	2010.08.31	Зах зээлийн үнэлгээ 1 их наяд төгрөгөөс давав.
35	2011.04.07	Лондонгийн хөрөнгийн биржтэй “Ажлын мастер гэрээ”-нд гарын үсэг зурав.
36	2011.10.06	Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлав.
37	2012.07.02	“Миллениум Ай Ти” Арилжаа, төлбөр тооцоо, хяналт, хадгаламжийн цогц системийг зах зээлд нэвтрүүлэв.
38	2013 он	МУ-ын Хөрөнгийн зах зээлийг FTSE-ийн “Хөгжиж буй” за зээлийн зэрэглэлд оруулахаар “Ажиглалтын жагсаалт”-д оруулав.
39	2013.05.24	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлав.
40	2014.07.28	MSE ALL индекс тооцож эхлэв.
41	2015.12.02	МХБ өөрийгөө зохицуулах хороо болж өөрчлөн зохион байгуулагдав.
42	2015.12.31	Түүхэн дээд арилжааг хийв.
43	2016.01.05	Төрийн өмчлөлийн хувьчлалыг хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй явуулж эхлэв.
44	2017.06.29	Хөрөнгийн зах зээлд хамгийн өндөр үнийн дүн бүхий компанийн өрийн хэрэгсэл гарч, амжилттай арилжаалагдав.
45	2017.12.31	859.2 тэрбум төгрөг буюу түүхэн дээд арилжааг хийв.
46	2018.01.02	MSE A болон MSE B индексүүдийг тооцож эхлэв.
47	2018.03.13	Хамгийн их захиалга авсан IPO хийгдэв.
48	2018.04.04	Хамгийн анхны гадаадын үнэт цаасыг давхар бүртгэв.
49	2018.05-06 сар	Монголын даатгалын салбарын анхны компани үнэт цаасаа бүртгүүлэв.

50	2018.12.31	Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа 210тэрбум төгрөг буюу түүхэн дээд хэмжээнд хүрэв.
51	2019.02-05 сар	Монголын томоохон ББСБ-ууд үнэт цаасаа бүртгүүлэв.
52	2019.06.28	Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмыг батлав.
53	2019.12.31	Орон нутагт үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөг зохион байгуулав.
54	2019.12.31	Анхдагч зах зээлийн арилжаа өмнөх оноос 35.1 хувиар өсөв.
55	2020.03.31	Төлбөр тооцооны T+2 горимд шилжлээ.
56	2020.08.24	Анхны хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх бүртгэгдлээ.
57	2020.11.12	Анхны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэгдлээ.
58	2021.01.19	Хөрөнгийн зах зээлийн түүхэн үзвэрийн танхимтай болов.
59	2021.06.30	Шанхайн хөрөнгийн биржтэй хамтран Монголын хөрөнгийн зах зээлийг сурталчлах арга хэмжээг амжилттай зохион байгуулав.
60	2022.09.29	Монгол улсын хөрөнгийн зах зээлийг FTSE RUSSEL-ийн Frontier Market ангилалд оруулахыг зөвшөөрөв.
61	2022.12.26	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК нэмэлт хувьцаагаа олон нийтэд асанал болгов.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, <https://mse.mn/mn/aboutus>

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хөрөнгийн зах зээлийг дэмжих, зах зээлд оролцогч иргэд, аж ахуйн нэгжүүдийг эрсдэлээс хамгаалах зорилгоор авч хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалтын арга хэмжээний үр дүнд шинэ бүтээгдэхүүний тоо нэмэгдэхийн зэрэгцээ зарим томоохон арилжааны банкууд хөрөнгийн зах зээл дээр хувьцаагаа арилжиж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноор хөрөнгийн зах зээлийн идэвхижил нэмэгдсэн байна. 2023 оны эхний улирлын байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үеэс 21.4 хувиар өсөж 6.5 их наяд төгрөгт хүрсэн нь ДНБ-ий 12.1 хувьтай тэнцэж байна. Харин хөрөнгийн бирж дээр хийгдсэн үнэт цаасны гүйлгээний дүн 2023 оны эхний улиралд 74.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 38.1 нэгж хувиар буурлаа. Түүнчлэн, Монгол Улсын хөрөнгийн биржийн ТОП-20 индексийн утга 2023 оны 1 дүгээр улиралд дунджаар 38,107.7 нэгжид хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.5 хувиар буурсан дүнтэй байна (Зураг 2.5-аас харна уу).

Зураг 2.5. Зах зээлийн үнэлгээ, ТОП-20 индексийн өөрчлөлт




Эх сурвалж: Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл, МБ

Даатгалын салбар

2023 оны эхний улирлын байдлаар СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй 18 даатгалын компани, 64 даатгалын зуучлагч, 23,756 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа эрхлэн явуулж байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгө 486.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 16.4 хувиар өссөн бол нөөц сангийн нийт дүн 219.5 тэрбум төгрөгт хүрэв. Зураг 63 Даатгалын нийт хураамж 76.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 48.5 хувиар өссөн бөгөөд нийт даатгалын хураамжийн 96.5 хувийг ердийн даатгал, 1.6 хувийг урт хугацааны даатгал, 1.9 хувийг давхар даатгалын хураамж тус тус бүрдүүлжээ.

Харин даатгалын нийт нөхөн төлбөр 26.8 тэрбум төгрөгт хүчр өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар өсөв. 2023 оны эхний улиралд хохирлын харьцаа (нөхөн төлбөрийн зардал, орлогод тооцсон хураамжийн харьцаа) ердийн даатгалын компаниудын хууд 53 хувь, урт хугацааны даатгалын компаниудын хууд 40.3 хувь байгаа бол хосолсон харьцаа ердийн болон урт хугацааны даатгалын хууд харгалзан 90.1 хувь, 78.7 хувьтай байна. Энэ нь даатгалын компаниудын удирдлага, үйл ажиллагааны зардал харьцангуй өндөр байгааг харуулж байна. Салбарын нийт цэвэр ашиг 2023 оны эхний улиралд 3.7 тэрбум төгрөг хүрч өмнөх оноос 9.9 хувиар өссөн боловч ердийн даатгалын компаниудын цэвэр ашиг 8.5 хувиар буурсан дүнтэй байна (Зураг 2.6-аас харна уу).

Зураг 2.6. Даатгалын салбарын нийт хөрөнгө, нөөц сан /тэрбум₮/ ба өсөлт



Эх сурвалж: Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл, МБ

Монгол Улсын санхүүгийн сектор салбар тус бүртээ өсөлттэй байгаа хэдий ч банкны салбарын төвлөрөл буурахгүй хэвээр байна. Банкны салбарын хувьд чанаргүй зээлийн хэмжээ буурч, сайжирсан дүр зурагтай байгаа ч хадгаламжийн төвлөрөл өндөр байгаа бол хөрөнгийн зах зээлийн хувьд зах зээлийн нийт үнэлгээний дийлэнх хувь 10 орчим компанид төвлөрч байна. Мөн арилжааны дүн болон тоо өссөн хэдий ч банкуудын IPO гаргалттай холбоотой байгаа тул бусад хөрөнгийн зах зээлийг тэлж, өргөжиж, идэвхижиж байна гэж дүгнэхэд учир дутагдалтай байна. Даатгалын зах зээлийн хувьд хураамжийн дийлэнхи нь давхар даатгалын хураамжаар гадаад зах зээлрүү шилжиж байгаа нь салбарын хувьд тулгарч буй хамгийн том асуудал байна.

Эцэст нь дүгнэхэд салбар тус бүрийн төвлөрлийг бууруулах, чадамжийг дээшлүүлэх, жижиг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн цар хүрээ, тоо болон шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, техник технологи, инновацийг нэмэгдүүлэх шаардлага зайлшгүй тулгарч байна.

2.2 Монгол улсын чөлөөт бүсийн өнөөгийн байдал

Өмнөх дэд бүлэг МУ-ын санхүүгийн өнөөгийн нөхцөл байдлыг судалсан бөгөөд энэ дэд бүлэг чөлөөт бүсийн өнөөгийн нөхцөл байдлыг судлана.

Монгол Улсын Их Хурлаас 1995 онд “Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай үзэл баримтлал, 2002 онд “Чөлөөт бүсийн тухай хууль”, “Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль”, 2003 онд “Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай”, “Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай” хуулиудыг тус тус баталсан.

Замын-Үүд чөлөөт бүс

Замын-Үүд чөлөөт бүс нь 2004 онд байгуулагдсан хэдий ч 18 гаруй жилийн хугацаанд зогсонги байдалтай байж байгаад 2021 оны 8 дугаар сарын 14-ний өдрөөс байнгын үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Тус бүсэд нийт 88 аж ахуйн нэгж газар эзэмших эрх авснаас 41 хувь нь үйлдвэрлэл, 34 хувь нь тээвэр, ложистик, үлдсэн хувь нь аялал жуулчлал, худалдааны чиглэлийн бизнес эрхлэгчид байна.

2023 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр тус бүсийг хөгжүүлэх төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Тус төслийн хүрээнд Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, өмнө хийгдсэн авто зам, инженерийн дэд бүтцийн зурагт үндэслэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зурагт өөрчлөлт оруулах ажил хийгдэж байна.

Алтанбулаг чөлөөт бүс

2002 онд Алтанбулаг чөлөөт бүсийг байгуулахаар УИХ-аас тогтоол гаргасан. Тус бүсийг эрх зүй, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлснээр экспорт, импортыг дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, транзит тээвэр, ложистикийг нэмэгдүүлэх, тэргүүний техник, технологийг нутагшуулах, худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх үндсэн зорилготойгоор байгуулсан. 2014 онд уг бүс нь байнгын үйл ажиллагааны дэглэмд шилжсэн боловч одоогийн байдлаар тус бүсэд бүртгэлтэй 136 аж ахуйн нэгжээс 19 нь идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг бана. Тус бүсийн гол давуу тал нь БНХАУ-ын “Бүс ба Зам”

санаачлагын Ази-Европыг холбосон 6 чиглэлийн маршрутын нэг бөгөөд стратегийн ач холбогдол бүхий АН-3 замын зангилаа хэсэгт оршдог (Зураг 2.7, 2.8-аас харна уу).

Зураг 2.7. Ази-Европыг холбосон замын маршрут



Эх сурвалж: Алтанбулаг чөлөөт бүс, <https://altanbulag.gov.mn/>


Зураг 2.8. Ази-Европыг холбосон замын маршрут дагуух хүн амын тоо



Эх сурвалж: Алтанбулаг чөлөөт бүс, <https://altanbulag.gov.mn/>


Хэдийгээр Алтанбулаг чөлөөт бүс нь газарзүйн байршлын хувьд тохиромжтой газар байрлаж байгаа хэдий ч 2014 оноос хойш 10 гаруй жил үйл ажиллагаа явуулахдаа Монгол Улсын нийт гадаад худалдааны эргэлтийн 1 хувьд ч хүрэхгүй байгаа нь чөлөөт бүс байгуулсан зорилгодоо хүрээгүй, амжилтгүй байгаа гэж үзэж болохоор байна (Зураг 2.9, 2.10-аас харна уу). Дэлхийн хөрөнгө оруулалтын тайлан 2019-ийн зарим тоон мэдээллүүдээс жишээ болгон дурдахад Коста рика болон Доминиканы Нэгдсэн Улс 50%, Мексик 31%, Колумбиа 13%, Филиппин 60%, Энэтхэг 10%, Бангладеш нийт гадаад худалдааны эргэлтийн 20 хувьтай тэнцэх хэмжээний экспорт, импортыг чөлөөт бүсээрээ дамжуулан хийсэн байна.

Зураг 2.9. МУ-ын гадаад худалдааны эргэлт /сая\$/



Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо

Зураг 2.10. Алтанбулаг ЧБ-ийн гадаад худалдааны эргэлт /сая\$/



Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо,

Тус чөлөөт бүсэд улсын төсвөөс 26.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бол хувийн хэвшлээс нийт 12.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдээд байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6,300 м.куб цэвэр усаар хангах инженерийн байгууламж, хоногт 5,700 м.куб бохир усыг Сүхбаатар сумын цэвэрлэх байгууламжид нийлүүлэх хүчин чадалтай бохир усны насос станц, 9.4 км урттай үерийн ус зайлуулах

байгууламж, 3.6 км сайжруулсан шороон авто зам болон 6кВ-ын цахилгаан түр хангамжийн шугамыг барьж ашиглалтад оруулсан. Чөлөөт бүсийн үйл ажиллагаанаас 2.1 тэрбум төгрөгийн газрын төлбөр, хураамж, 3.4 тэрбум төгрөгийн орлогын албан татвар, 337.4 сая төгрөгийн тэмдэгтийн хураамж, 578 сая төгрөгийн дуудлага худалдааны үнэ буюу нийт 6.4 тэрбум төгрөгийн орлогыг хуримтлуулсан.

Тус бүсэд тулгамдаж байгаа асуудлыг 3 бүлэгт хуваан дараах байдлаар тодорхойлсон байна (Алтанбулаг ЧБ-ийн Захирагчийн ажлын алба, 2024).

I. Эрх зүйн орчин

- a. Чөлөөт бүсэд төрөөс баримтлах бодлого, чиглэлийг боловсруулах,
- b. Чөлөөт бүсийн үйл ажиллагаанд мөрдөгдөх нийтлэг журмыг баталж мөрдүүлэх,
- c. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн зохицуулалтыг сайжруулах.

II. Дэд бүтэц

- a. Цахилгаан хангамжийн өргөтгөлийн ажил,
- b. Хатуу хучилттай авто зам барих /бүс доторх 13.8км, хүзүүвчний 0.81км,/
- c. Чөлөөт бүс, боомт, сумыг хамарсан нэгдсэн дулаан хангамжтай болгох,
- d. Цэвэр, бохир усны шугам хоолойн барилга байгууламжуудын ашиглалтыг мэргэжлийн байгууллагуудад шилжүүлэх,
- e. Шилэн кабель /гаалийн нэгдсэн системд холбогдох/

III. Хэлэлцэн шийдвэрлэх асуудал

- a. Монгол, Оросын Засгийн газар хоорондын хуралдаануудын протоколд тусгуулж, хэрэгжүүлэх саналууд:
 - Чөлөөт бүсийн шууд гарцын асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх,
 - Хамтын ажиллагааны бүс болгон хөгжүүлэх.

Цаашид уг бүсийг олон улсын жишигт нийцсэн чөлөөт бүсийг бий болгон хөгжүүлэх зорилгыг дэвшүүлсэн бөгөөд “Ази-Европын ачаа тээврийн урсгалын зангилаа төв, Логистикт чиглэсэн экспортын боловсруулах бүс болгохыг зорьж байна. Үүний тулд нийгэм, эдийн засагт үр өгөөжтэй, байгальд ээлтэй өндөр техник, технологийг нутагшуулах, бараа, бүтээгдэхүүнийг төвлөрүүлэх, үйлдвэрлэх, хадгалах, ангилах, түгээх нэгдсэн сүлжээг бий болгоно хэмээн зорилтоо тодорхойлжээ (Алтанбулаг ЧБ Захирагчийн ажлын алба, 2023).


Алтанбулаг чөлөөт бүс нь Замын-Үүд болон Цагааннуур чөлөөт бүсүүдийг бодвол үйл ажиллагаагаа тодорхой хэмжээнд идэвхижүүлэн ажиллаж байгаа цорын ганц бүс бөгөөд тухайн бүсэд бизнесийн үйл ажилагаа эрхлэх орчин нөхцөл хангалттай бүрдээгүй байгааг дээр дурдсан тулгамдаж буй асуудлуудаас тодорхой харагдаж байна.

Дагуул хот, Эдийн засгийн тусгай бүс

Дэвшилтэт технологи шингээсэн экспортын бүтээгдэхүүний төрлийг нэмж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг кластераар хөгжүүлэн, Улаанбаатар хотын хөгжлийг шинэ шатанд гарган эдийн засгийн өсөлтийн хурдасгуур бий болох боломж бүрдүүлэх зорилготой бөгөөд хөрөнгө оруулалт татах эрх зүйн таатай орчин бий болж, гадаад дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэж, улмаар жилд 1500 гаруй ажлын байр шинээр бий болж, тэр хэмжээгээр ДНБ нэмэгдүүлэхийг зорьж байна.


“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн ачаа тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ” гэж тусгасан байдаг. Энэ дагуу нийслэл Улаанбаатар хотыг 15 дагуул хот, тосгодтой байхаар төлөвлөсөн бөгөөд эхний ээлжид дэд бүтэц, суурьшил, үйлдвэржилт зэргийг харгалзан одоогийн байдлаар Нийслэлийн дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газар байгуулан суурь судалгааг хийж, гүйцэтгэж байна (Зураг 2.11, 2.12-оос харна уу).

Зураг 2.11. УБ хотын дагуул хот, ЭЗТБ-ийн ерөнхий төлөвлөгөө



Эх сурвалж: Алсын хараа 2050, <https://nda.gov.mn/backend/files>

Зураг 2.12. УБ хоотын ойролцох ЭЗЧБ-ийн ерөнхий төлөвлөгөө



Эх сурвалж: Алсын хараа 2050, <https://nda.gov.mn/backend/files>

МУ-ын УИХ-аас 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталснаас хойш даруй 4 дэх жилдээ явж байна. Гэвч өнөөдрийн байдлаар дагуул хот, эдийн засгийн тусгай бүс байгуулах ажил судалгаа түвшинд явж байхаас гадна зорилгоо хэмжиж, дүгнэн тайлагнасан зүйл байхгүй байна.

МУ сүүлийн 30 орчим жил чөлөөт бүс байгуулахыг оролдож байгаа ч одоогийн байдлаар амжилттай хэрэгжсэн кэйс байхгүй. Гэхдээ Алтанбулаг чөлөөт бүсийн хувьд үйл ажиллагаа нь бага багаар сайжирч байгаа дүр зурагтай байна.

Чөлөөт бүсийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал зэргээс товч дүгнэхэд, бид бодлогын баримт бичиг, хууль, тогтоомжийн хүрээнд чөлөөт бүс байгуулахаар зориод, тодорхой хэмжээний улсын төсөв зарцуулсан байгаа хэдий ч үйл ажиллагаа нь жигдэрсэн зүйлгүй, тухайн бүсэд гадны хөрөнгө оруулалт бараг хийгдээгүй, бүртгэлтэй бизнес эрхлэгчид нь бизнес идэвхитэй эрхэлдэггүй, дэд бүтэц болон бизнесийн орчин бүрдээгүй, бүсэд хийгдэх төлбөр тооцооны валют нь тодорхой бус байдалтай байна

Бүлгийн дүгнэлт

МУ-ын санхүүгийн систем банкны салбарт төвлөрсөн хэвээр байх бөгөөд ББСБ, ХЗХ гэх мэт бусад санхүүгийн байгууллагуудын үзүүлэлт өссөн хэдий ч банкны салбарын төвлөрөлтэй харьцуулахад жижиг хэвээр байна. Даатгалын салбарын хувьд өсөлттэй боловч гадаадын даатгалы компанид давхар даатгуулдаг хэвээр байна. Харин хөрөнгийн зах зээлийн хувьд зах зээлийн үнэлгээ ДНБ-ийн 12 хувийг эзлэхээс гадна ТОП-10 компанид төвлөрсөн байдалтай, хөрвөх чадвар сул байна. Бусад хөгжиж буй улстай харьцуулахад хөрөнгийн зах зээлийн голлох үзүүлэлтээрээ хамгийн сүүлд байна.

ЧБ-ийн хувьд анхны хууль, тогтоомж батлагдан зарим ЧБ байнгын үйл ажиллагаанд шилжээд 10 орчим жил болсон ч тус бүсэд хийгдэж буй гадаад худалдааны нийт эргэлт, МУ-ын нийт гадаад худалдааны эргэлтийн 1 хувьд ч хүрэхгүй байна. ЧБ амжилттай байгуулсан улсуудын тухайн бүс дэх худалдааны эргэлт хамгийн багадаа 13 хувь, хамгийн ихдээ 50 гаруй хувь байгаатай харьцуулахад бид ЧБ-ийг амжилтгүй байгуулсан туршлагыг нэмсэн үр дүнтэй байна. Цаашид одоогийн ЧБ-ийг байгуулах, хөгжүүлэх явцад алдааг давтахгүйн тулд тусгай бүсийг үүсгэн байгуулахдаа тухайн чөлөөт бүсийн онол арга зүйд дурдсан хууль эрх зүйн орчин, дэд бүтэц, хөдөлмөрлөх, амьдрах орчныг цогцоор нь шийдвэрлэхэд анхаарч байх нь зүйтэй байна.

Ш БҮЛЭГ. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГАА

МУ-ын санхүүгийн зах зээл, чөлөөт бүсийн нөхцөл байдлын судалгаа өмнөх бүлгийн хүрээнд хийсэн. Энэхүү бүлгээр олон улсын түвшинд санхүүгийн чөлөөт бүс байгуулсан туршлагыг судлах, МУ-ын санхүүгийн зах зээлийн өрсөлдөх чадварыг үнэлнэ. Тодруулбал, санхүүгийн чөлөөт бүс байгуулсан тохиолдолд, бид ОУСТ-үүдтэй өрсөлдөх тул өрсөлдөх чадварыг үнэлэх нь СЧБ-ийг амжилттай байгуулахад чухал ач холбогдолтой гэж судлаачийн зүгээс үзэж байна.

3.1 Амжилттай кэйс туршлага-Астана санхүүгийн чөлөөт бүс

Дэлхийн хэмжээнд 2023 оны 9 сарын байдлаар 121 ОУСТ байгаагаас Ази тивд үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн төвүүдийн үнэлгээ 3.7 хувиар өссөн байна. Санхүүгийн чөлөөт бүс болоход хамгийн чухал хүчин зүйл нь ур чадвартай хүний нөөц

хэвээрээ байгаа боловч ногоон санхүүжилт болон финтек салбарын хөгжлөөс шалтгаалан ур чадвараа ахиулах, хөгжих шаардлага тулгараад байна.

Эдгээрээс Казакстан улсын Астана санхүүгийн чөлөөт бүсийг сонгон судлах болсон шалтгаан нь:

- Далайд гарцгүй;
- Газарзүйн байршлын хувьд БНХАУ болон ОХУ-ыг холбосон буюу МУ-тай шууд өрсөлдөх байршилд байрладаг (Зураг 3.1-ээс харна уу);
- 2018 онд байгуулагдсан;
- Зорилтот бүсэд Монгол улс багтсан зэрэг болно.

Зураг 3.1. Казакстан улс болон МУ-ын газарзүйн байршил



Эх сурвалж: https://en.m.wikipedia.org/wiki/File:Kazakhstan_Mongolia_Locator.png

Төв Ази, Кавказ, Хятадын баруун хэсэг, Зүүн Европ болон Евроазийн бүс нутгийн эдийн засгийг холбосон бизнес, санхүүгийн гол төв болох зорилгоор Астана санхүүгийн чөлөөт бүсийг байгуулсан. 2018 онд байгуулагдсанаасаа хойш эрчимтэй үйл ажиллагаагаа явуулж 2023 оны 9 сарын байдлаар 121 санхүүгийн төвөөс 66-д эрэмбэлэгдсэн байна. Дэлхийн ТОП 30 санхүүгийн нэг болох урт хугацааны зорилготой. 2022 оны байдлаар 25 улсын 80 гаруй санхүүгийн чиглэлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Астана чөлөөт бүсийн албан ёсны хэл нь Англи хэл бөгөөд эрх зүйн системийн хувьд Английн нийтийн эрх зүйн систем үйлчилдэг.


Банк, даатгал, хөрөнгө оруулалт гээд санхүүгийн секторын нийт хөрөнгийн хэмжээ 884 сая ам.доллар, нийт 5 жилийн хугацаанд 50 тэрбум тэнгэгийн шууд татвар төлөгдсөнөөс 25 тэрбум нь 2022 онд төлөгдсөн амжилттай байна. Түүнчлэн 6,500 орчим ажлын байрыг шинээр бий болгохоос гадна 16,500 мэргэжилтнийг олон улсын сайн туршлага, дижитал зах зээл, олон улсын сертификатын сургалтад хамруулж олон улсын зэрэгтэй дотоодын хүний нөөцийг бүрдүүлснээс гадна санхүүгийн зах зээлд оролцогчдын тоо жил бүр эрчимтэй нэмэгдэж байна (Хүснэгт 3.1, Зураг 3.2-оос харна уу).

Хүснэгт 3.1. АСЧБ санхүүгийн зах зээлд оролцогчдын тоо

Үйл ажиллагааны төрөл	2017	2018	2019	2020	2021	2022	2023	Нийт
Тусгай зөвшөөрөлтэй	4	39	84	57	53	34	112	383
Санхүүгийн		9	12	14	24	22	59	140
Дэмжих салбарын		24	59	35	19	7	16	160
Зах зээлийн	1	1		1			1	4
Финтек	3	5	13	7	10	5	36	79
Санхүүгийн бус	2	39	165	233	497	531	835	2,302
Нийт	6	78	249	290	550	565	947	2,685
Өссөн дүнгээр	6	84	333	623	1,173	1,738	2,685	

Эх сурвалж: Астана чөлөөт бүс, <https://aifc.kz/en>


Зураг 3.2. Биржид бүртгэлтэй компани болон арилжааны хэмжээ, данс эзэмшигчдийн тоо



Эх сурвалж: Annual Report of the Astana International Finance Center 2022, <https://aifc.kz/en/annual-report>

Астана санхүүгийн чөлөөт бүсийн бүтэц зохион байгуулалтыг Зураг 3.3-аас харна уу.

Зураг 3.3. АСЧБ-ийн бүтэц, зохион байгуулалт



Эх сурвалж: Астана чөлөөт бүс, <https://aifc.kz/en>


AIFC Authority-Чөлөөт бүсийн хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулах, санхүүгийн хууль тогтоомж, дүрэм, журам дахь зохицуулалт дахь хамааралгүй асуудлыг тодорхойлох, боловсруулах олон бусад олон улсын санхүүгийн төвүүдтэй харилцан уялдаа холбоотой ажиллах, хамтын ажиллагаа үүсгэх гэх мэт асуудлыг хариуцан ажилладаг.

AFSA Astana Financial Services Authority-Санхүүгийн салбарын бүхий л үйл ажиллагааг зохицуулахаас гадна Астана санхүүгийн чөлөөт бүсэд оролцогчдын бүртгэлийг хийдэг. Уг байгууллагын гол зорилго нь Астана санхүүгийн чөлөөт бүс дэх санхүүгийн бүхий л үйл ажиллагааны ил тод, шударга байдлыг хангах явдал юм. Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хороотой төстэй.

AIFC Court-Астана санхүүгийн чөлөөт бүс дэх бизнесийн маргааныг шийдвэрлэх зорилготой тусгай шүүх юм. Нийтийн эрх зүйн системээр мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий 9 шүүгчтэй. Эрүүгийн болон захиргааны маргаан шийдвэрлэдэггүй. Монгол Улсад байгуулсан чөлөөт бүсийн алинд ч тусгай шүүх байгуулагдаагүй.

IAC International Arbitration Center-Олон Улсын Арбитрын Төв нь 41 өндөр ур чадвар бүхий арбитртай. Шүүхийн бус журмаар бизнесийн маргааныг шийдвэрлэдэг. Нийт 1644 маргааныг 4 жилийн хугацаанд шийдвэрлэснээс 59 нь шүүхээр, 1585 нь арбитрын журмаар шийдвэрлэгдсэн байна.


Зураг 3.4. Шүүх болон Арбитрын журмаар шийдвэрлэсэн маргааны статистик үзүүлэлт



Эх сурвалж: Annual Report of the Astana International Finance Center 2022

Монголын Олон Улсын Арбитр нь 1960 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нийт 77 арбитрч бүртгэлтэйгээс монгол арбитрч 52, олон улсын арбитрч 25 байна. 2020 оноос хойш шийдвэрлэсэн хэрэг маргааны тоо 679 байна. ОУ-ын шинжтэй маргааны нийт маргаан эзлэх хувь дунджаар 8 байна (Зураг 3.5-аас харна уу).

Зураг 3.5. МУ-д арбитрын журмаар шийдвэрлэгдсэн маргааны статистик үзүүлэлт



Эх сурвалж: МУ-ын ОУАТ, 2024

AIX Astana International Exchange-Гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдын татахын тулд ойлгомжтой бөгөөд сонирхлыг нь татахуйц нөхцлийг санал болгох замаар Төв Ази болон Казакстаныг хамарсан хөрөнгийн зах зээлийг бий болгох үндсэн зорилготой. Бизнесийн байгууллагуудад санхүүжилт олгох зорилгоор хөрөнгө оруулалтын платформ бий болгосон.

GFC Green Finance Center-Нийтийн болон хувийн секторт ногоон болон тогтвортой санхүүжилтийн хэрэгслүүд болон стратеги, бизнесийн зөвлөх үйлчилгээг үзүүлэх замаар Төв Азийн бүс нутаг болон Казакстаны тогтвортой эдийн засгийг дэмжих хөрөнгө оруулалтыг татах үндсэн зорилготой.

AIFC Tech Hub-хамгийн сүүлийн үеийн технологийг санхүүгийн зах зээлд нэвтрүүлж, финтек экосистемийг бүрдүүлэх замаар бүс нутагтаа шинэ технологийг санаачлагч болох зорилготой.

BCPD Bureau for Continuing Professional Development-Астана санхүүгийн чөлөөт бүсийн хүний нөөцийн хөгжлийг дэмжих зорилготой бөгөөд дижитал боловсролын платформоор тасралтгүй хөгжил, мэргэжлийн коммюнитийг дэмжинэ.

Татварын системийн хувьд дараах хөнгөлөлт, урамшууллыг тооцдог.

I. Чөлөөт бүс дэх санхүүгийн үйлчилгээнээс олсон орлогод ААНОАТ, НӨАТ тооцохгүй.

- Исламын банкны үйлчилгээ
- Давхар даатгал, даатгалын брокерын үйлчилгээ
- Хөрөнгө оруулалтын сангийн менежментийн үйлчилгээ, болон түүний нягтлан бодох бүртгэл, системийн хадгалалт, даатгал
- Брокер, дилер, андрейтингийн үйлчилгээ

- II. Чөлөөт бүс дэх оролцогчдод үзүүлсэн хууль, аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээнээс олсон орлогод ААНОАТ тооцохгүй.
- III. Чөлөөт бүсэд байрлан санхүүгийн болон дэмжигч үйлчилгээ үзүүлэгч бизнес эрхлэгч нарыг үл хөдлөх хөрөнгө болон газрын албан татвараас чөлөөлнө.
- IV. Чөлөөт бүсийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжид ажиллаж байгаа гадаадын иргэдийг хувь хүний орлогын албан татвараас чөлөөлнө.

Хөрөнгийн зах зээлийн хувьд анхдагч болон хоёрдогч зах зээл дээрх хувьцааны арилжаа, корпорацийн болон засгийн газрын бонд, евро бонд, юаний бонд, хадгаламжийн бичиг, өрийн бичиг гэх мэт бүх л төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгодог. Биржийн программ хангамжийн хувьд NASDAQ-ийн программ хангамжийг ашигладаг. Мэдээллийн аюулгүй байдлыг онцгойлон анхаарч ISO 27001, 27032, 27018, 27017-г нэвтрүүлж сертификат авсан. Хөрөнгийн биржийн хувьцаа эзэмшигчид нь Астана ОУСТ, Шанхайн хөрөнгийн бирж, Торгоны зам сан, Насдак зэрэг болно. Нийт 30 гаруй брокер, диллер компанийн бүртгэлтэй байдгаас Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг, Хятад, Европ, Казакстан зэрэг улсуудын брокерын компаниуд дийлэнх хувийг нь эзэлдэг. Биржийн дүрэм, журмыг Дубай болон Лондонгийн санхүүгийн төвийн дүрэм, журмыг жишиг болгон сонгон авч боловсруулсан. 2023 оны байдлаар 140 гаруй компани бүртгэлтэй байна. Биржийн арилжааг ам.доллар болон тэнгэгээр хийдэг. Биржийг хөгжүүлэх суурь нөхцлийг БНХАУ-ын “Бүс ба Зам” санаачлагад нэгдсэнтэй холбон тайлбарладаг ба энэ ч утгаараа БНХАУ-ын Хилийн чанад дахь хөгжлийн нийгэмлэг, Chengxin олон улсын зээлжих зэрэглэлийн агентлаг, Deheng хуулийн фирм, Хятадын Барилгын банк болон Хөрөнгө оруулалтын банк, CITIC securities зэрэг компаниуд зах зээлийн гол тоглогчид байдаг байна.

Астана санхүүгийн чөлөөт бүс нь 2018 онд байгуулагдсан боловч 5 жилийн дотор дэлхийн 121 санхүүгийн төвөөс 66-д эрэмбэлэгдсэн амжилттай туршлагын тод жишээ юм. Чөлөөт бүсийн гол стратеги нь БНХАУ-ын “Бүс ба Зам” санаачлагад нэгдэн орохоос гадна Английн эрх зүйн системийг чөлөөт бүсэд хэрэгжүүлснээр хөрөнгө оруулагчид аюулгүй, тогтвортой, найдвартай хууль, эрх зүйн системтэй хэмээн үнэлэх болсон байна. Түүнчлэн хөрөнгийн зах зээлийн систем дэх мэдээллийн технологийн аюулгүй байдалд онцгойлон анхаарч, ОУ-ын стандартыг нэвтрүүлсэн байна.

3.2. Санхүүгийн системийн өрсөлдөх чадвар /Даймонд модель/


МУ-тай түүх соёл, эдийн засгийн нөхцөл байдал зэрэг бүхий л талаараа ижил, төстэй Казакстан улс АСЧБ-ийг амжилттай байгуулан, гадаадын хөрөнгө оруулалтыг татаж чадсан амжилттай кэйс туршлагыг өмнөх дэд бүлгээр судалсан. Энэ дэд бүлгийн хүрээд МУ-ын санхүүгийн зах зээл АСЧБ-тэй өрсөлдөхөд давуу тал байгаа эсэхийг тодруулах, түүнчлэн МУ-д СЧБ байгуулах боломж бий эсэхийг өрсөлдөх чадварыг үнэлэх замаар тодорхойлохыг зорьсон.

Даймонд загвараар өрсөлдөх чадварыг үнэлэхийн тулд нийт 4 бүлэг 19 хүчин зүйлсийг хоёрдогч өгөгдөлд тулгуурлан 1-5 оноогоор үнэлж, дүн шинжилгээ хийсэн. Шинжилгээний үр дүнг бүлэг бүлгээр нь дэлгэрэнгүй тайлбарлавал:

А. Стратеги, бүтэц, өрсөлдөөн

Энэхүү бүлгийг бизнесийн ерөнхий орчин, капиталын хөдөлгөөн, зах зээлд шинээр нэвтрэх, хууль, тогтоомжийн тэнцвэрт байдал, хууль, эрх зүйн орчин, дотоодын өрсөлдөөн гэсэн нийт 6 хүчин зүйлсийг үнэлж, дундаж үнэлгээгээр нь тооцон гаргахад дунд гэсэн үнэлгээтэй байна (Зураг 3.6-аас харна уу).

Зураг 3.6. Стратеги, бүтэц, өрсөлдөөн бүлгийн шинжилгээний үр дүн



Эх сурвалж: Хавсралтад хоёрдогч өгөгдлийн эх сурвалжийг дэлгэрэнгүй дурдсан.

- Бизнесийн ерөнхий орчинг дотор нь эдийн засгийн орчин, бизнес эрхлэх зардал, татварын орчин, бизнесийн хууль, эрх зүйн орчин гэсэн 4 дэд үзүүлэлтээр үнэлсэн. Эдгээрээс бизнес хийх зардал өндөр буюу муу үнэлгээтэй байсан бөгөөд бусад үзүүлэлтүүд дунд буюу сайжруулах шаардлагатай гэсэн үнэлгээтэй байна.
- Капиталын хөдөлгөөн муу үнэлгээтэй буюу шаардлага хангахгүй, бизнес эрхлэхэд хүндрэл учруулж байгаа хүчин зүйл гэж үнэлжээ. Капиталын хөдөлгөөнд тавих хяналт дунд боловч валютын ханшийн нөлөө, төгрөгийн тогтворгүй байдал нь бизнес эрхлэхэд хамгийн хүндрэлтэй хүчин зүйл байдгийг судалгаагаар онцолсон байна.
- Зах зээлд шинээр нэвтрэх гэсэн хүчин зүйлийг нийт 3 дэд үзүүлэлтээр үнэлээд хангалтгүй буюу муу гэсэн үнэлгээг өгсөн байна. Гадаадын банк, санхүүгийн байгууллагууд дотоодын зах зээлд нэвтрэхэд саадтай байдаг хэдий ч 2024 оны мөнгийн бодлогын үндсэн чиглэлд энэ саадыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр тусгасан. Энэ нь ирээдүйд энэ салбарт нэвтрэх саадыг бууруулна гэсэн хүлээлттэй байна. Чадварлаг хүний нөөцийг Монголд урьж ажиллуулахад ажлын байрны төлбөр өндөр байхаас гадна мэргэжилтнүүдийн тоог Засгийн газраас хязгаарладаг байдал нь хангалтгүй гэсэн үнэлгээг өгөхөд хүргэсэн. Чөлөөт бүс байгуулахад хамгийн чухал үзүүлэлт нь чадварлаг хүний нөөц хангалттай байх гэсэн судалгааны үр дүн гарсан байдаг.
- Хууль тогтоомжийн хүрээнд талуудын эрх тэгш байдлыг хангасан эсэхэд хангалтгүй гэж үнэлсэн. Уг үнэлгээнд хяналтын тогтолцоо үр ашигтай биш, талуудын эрхийг тэгш хангаагүй, төрийн албан тушаалтнууд асуудлыг

шийдвэрлэхдээ хойрго, хууль, тогтоомж, эрх зүйн актын хоорондын уялдаа холбоо сул байгаа нь нөлөөлсөн байна.

- Бизнесийн хууль эрх зүйн орчин бүрдүүлсэн байдлын хувьд олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орж, салбарын хууль тогтоомжийг байнга шинэчлэн сайжруулдаг боловч иргэнлэг эрх зүйн системтэй нь сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл болж байна.
- Дотоод өрсөлдөөний хувьд компанийн тухай хуулиар нэгдэж, нийлэх процессыг чөлөөтэй зөвшөөрсөн, монополь болон давамгайллагч аж ахуйн нэгжийн өрсөлдөөнийг хязгаарлахаас сэргийлсэн эрх зүйн зохицуулалттай тул сайн гэж үнэлсэн байна.

В. Хүчин зүйлсийн нөхцөл байдал

Энэ бүлгийг хүний нөөц, хууль, эрх зүйн орчны дэд бүтэц, мэдээллийн технологи, харилцаа холбоо, амьдралын чанар, барилга байгууламж, дэд бүтэц, газарзүйн байршил гэсэн нийт 6 хүчин зүйлсээр үнэлэхэд дундаж үнэлгээ дунд байна. Эдгээрээс хамийн муу үнэлгээ нь амьдралын чанар байсан бөгөөд олон улсын хэлний хэрэглээ байхгүй, улс төр, нийгмийн байдал тогтворгүй тул муу хэмээн үнэлсэн бол мэдээлэл, холбоо, технологийн хүчин зүйлс сайн гэж үнэлсэн (Зураг 3.7-оос харна уу).

Зураг 3.7. Хүчин зүйлсийн нөхцөл байдлын бүлгийн шинжилгээний үр дүн



Эх сурвалж: Хавсралтад хоёрдогч өгөгдлийн эх сурвалжийг дэлгэрэнгүй дурдсан.

- Хүний нөөцийн хувьд судалгаанд оролцогчид дунд гэж үнэлсэн. Ерөнхийдөө дээд боловсролтой хүмүүсийн ажил эрхлэлтийн түвшин өндөр, тэр дундаа санхүү болон мэдээлэл, технологи, менежерийн түвшиний ажлын байрны захиалга бага, тогтвортой ажил эрхлэлттэй гэсэн судалгааны үр дүн гарсан байсан нь энэ хүчин зүйлийг дунд гэж үнэлэхэд нөлөөлсөн.
- Хууль, эрх зүйн орчны дэд бүтцийн хувьд Бизнесийн орчинд засгийн газрын оролцооны сөрөг нөлөөг дунд, засгийн газрын дэмжлэг бусад субъектүүдээс арай их гэж үнэлсэн бол төрийн захиргааны байгууллагын шилэн, ил тод байдлыг дунд гэж үнэлсэн. Харин эдийн засгийн өсөлт ковидын үеийг эс тооцвол жигд өсөх трендтэй байгаа тул сайн гэж үнэлсэн.

- Мэдээлэл, мэдээллийн технологи, харилцаа холбооны хувьд бүх хүчин зүйлсээс хамгийн сайн буюу жигд сайн үнэлгээтэй ганц хүчин зүйл байна. Найдвартай харилцаа холбооны системтэй, өндөр хурдны интернэттэй, мэдээллийн технологийн хэрэглээ, мэдлэг дэлхийд өрсөлдөхүйц, орчин үе түвшинд байгаа гэж үнэлэн сайн оноо өгсөн байна.
- Амьдралын чанарын хувьд нийгэм соёлын арга хэмжээ, чөлөөт цаг өнгөрүүлэх олон төрлийн спорт, урлагийн дугуйлан харьцангуй түгээмэл байдаг бол эсрэгээрээ олон улсын хэлний хэрэглээ болон улс төр, нийгмийн байдал тогтворгүй буюу муу гэж үнэлсэн нь энэ хэсгийн үзүүлэлтийг хангалтгүй үнэлгээ авахад нөлөөлсөн байна.
- Барилга байгууламж, дэд бүтцийн хувьд жигдхэн дунд үнэлгээтэй байна. Амьдран суух болон ажиллахад таатай оффис, орон сууцны барилга байгууламж олдоцтой ба хот дотор, хот хооронд, болон олон улсын чанартай авто зам, төмөр зам, агаарын тээврийн үйлчилгээ дунд түвшинд хөгжсөн гэж үнэлсэн байна.
- Газарзүйн байршлын давуу тал бий эсэх хүчин зүйлсийг үнэлэхэд Монголын эзэнт гүрний үед торгоны замыг үүсгэн бий болгосон хэдий ч одоогийн Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр тухайн зам нь дайран өнгөрч байгаагүй тул үнэлгээ буурахад нөлөөлсөн. Гэхдээ хөрөнгийн зах зээлийн ажлын цагийн хуваарь Хонг Конг, Хятад, Солонгос, Япон улсуудын хөрөнгийн зах зээлийн ажлын цагийн хуваарьтай нэг бүсчлэлд байдаг нь эерэг нөлөө үзүүлж ерөнхий үнэлгээ дунд байна.

С. Эрэлтийн нөхцөл байдал

Энэ бүлгийг нийт дотоод эдийн засгийн орчин, капиталын эх үүсвэр, дотоодын хэрэглэгч, дотоод зах зээл болон оролцогчдын уян хатан байдал гэсэн нийт 4 хүчин зүйлсийн дунджаар үнэлж дунд гэсэн үнэлгээг өгсөн байна (Зураг 3.8-аас харна уу).

Зураг 3.8. Эрэлтийн нөхцөл байдал бүлгийн шинжилгээний үр дүн



Эх сурвалж: Хавсралтад хоёрдогч өгөгдлийн эх сурвалжийг дэлгэрэнгүй дурдсан.

- Дэлхийн хамгийн том зах зээл буюу Хятад улстай хөрш зэргэлдээ оршдог учраас эдийн засгийн өсөлттэй бүсэд байрладаг бөгөөд ДНБ тогтвортой өсөж байгаа тул


сайн гэсэн үнэлсэн. Төгрөгийн ханшны сул байдлаас шалтгаалан дотоод эдийн засгийн орчны ерөнхий үнэлгээ дунд гарсан байна.

- Үнэт цаасны арилжаа 2018 онтой харьцуулахад 2022 онд 2.4 дахин, бондын арилжаа 79 дахин, хувьцааны арилжаа 63 хувиар өссөн үр дүнтэй байгаа учраас үнэт цаасний зах зээл болон хадгаламжийн зуучлалын эрэлт хэрэгцээ өсч байна хэмээн үзэж сайн гэж үнэлсэн. Хөрөнгө оруулалтад зарцуулах илүүдэл нөөц байгаа эсэх гэсэн хүчин зүйлийг үнэлэхдээ ДНБ-ийг нийт хуримтлалын дүнтэй харьцуулах замаар үнэлсэн. Энэхүү харьцуулсан үзүүлэлт 18 хувь байгаа дунд байна. Нийт үнэлгээний дунджаар капиталын эх үүсвэр дунд үнэлгээтэй байна.
- Дотоод хэрэглэгчид хэмээх хүчин зүйлсийн хувьд сайн үнэлгээ авахад нөлөөлсөн зүйл нь бичиг үсэг тайлагдсан байдал 99 хувь буюу маш сайн, эдийн засгийн болон санхүүгийн мэдээллийн урсгал чөлөөтэй буюу сайн байгаагийн үр дүн боловч нэг хүнд ноогдох үндэсний нийт орлогын түвшин 3,730 ам.доллар буюу дундаас доогуур байгаа нь сөргөөр нөлөөлж, дундаж үнэлгээг бага зэрэг бууруулсан байна.
- Дотоод зах зээл болон оролцогчдын уян хатан байдал хүчин зүйлс дунд үнэлгээтэй байна. Энэхүү үзүүлэлтийг санхүүгийн бус үндэстэн дамнасан корпораци байдаг эсэх болон дээд боловсролтой хүмүүст ажлын байр хангалттай эсэх үзүүлэлтийн дунджаар үнэлсэн. Энэ хоёр үзүүлэлт хоёулаа дунд үнэлгээтэй байна. Дотоодын үндэстэн дамнасан корпораци байхгүй ч гадаадын үндэстэн дамнасан корпораци дотоодын зах зээл дээр үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг бөгөөд Монгол Улсад бизнес эрхэлж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны цар хүрээ тэлэх тусам гадаадын хөрөнгө оруулалттай компанитай өрсөлдөх шаардлагатай болдог байна. Дээд боловсролтой иргэдийн хувьд ажлын байр хангалттай биш ч, хомсдолтой гэж үзэхүйц хэмжээнд биш байгаа нь ажиллах хүчний судалгаанаас харагдаж байна. Тодруулбал, ажлын байрны захиалгыг ажил идэвхитэй хайж байгаа иргэдийн тоотой харьцуулахад тэнцвэртэй буюу зах зээлд илүү болон хомсдол үүсээгүй байна.

D. Холбоотой болон дэмжих салбарууд

Энэ хэсгийг дэлхийн зах зээлийн интеграцичлалын нөлөөний цар хүрээ, дэмжигч секторуудын өсөлт, хамааралтай секторуудын чанар гэсэн үндсэн гурван хүчин зүйлийн дундаж үнэлгээгээр үнэлсэн (Зураг 3.9-өөс харна уу).

Зураг 3.9. Хамааралтай болон дэмжих салбар бүлгийн шинжилгээний үр дүн




Эх сурвалж: Хавсралтад хоёрдогч өгөгдлийн эх сурвалжийг дэлгэрэнгүй дурдсан.

- Дэлхийн зах зээлийн интеграцичлалын нөлөөний цар хүрээг маш муу гэж үнэлэхэд дотоодын хөрөнгө оруулагчдын дэлхийн хөрөнгийн зах зээл дэх оролцоо болон олон улсын хөрөнгө оруулагчдын дотоодын хөрөнгийн зах зээл дэх оролцоо гэсэн хоёр хүчин зүйл голлох нөлөөг үзүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, олон улсын хөрөнгө оруулагчдын дотоодын хөрөнгийн зах зээл дэх оролцооны хувь 3 байгаа бол, дотоодын хөрөнгө оруулагчдын дэлхийн хөрөнгийн зах зээл дэх оролцооны хувь тодорхойгүй байсан. Олон улсын стандарт болон сайн туршлагыг нэвтрүүлсэн эсэх үзүүлэлтийн тухайд нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар үйл ажиллагааны цар хүрээнээс хамаарч ОУНББС-ын дагуу нягтлан бодох бүртгэлээ хөтлөхийг хуульчлан тогтоосныг стандарт нэвтрүүлсэн гэж үзэн дунд үнэлгээ өгсөн. Харин ISO гэх мэт бусад стандарт нэвтрүүлж байгаа хэдий ч хичнээн компанийн нэвтрүүлсэн талаарх статистик байхгүй тул үнэлгээнд оруулж тооцоогүй.
- Дэмжигч секторуудын хувьд жигдхэн сайн үнэлгээтэй байна. Олон улсын нягтлан бодох бүртгэл, аудитын байгууллага байдаг эсэх үзүүлэлтийг дэлхийн ТОП 4 компани үйл ажиллагаа явуулж байгаа тул сайн гэж үнэлсэн. Инноваци, мэдээллийн технологийн сектор болон харилцаа холбооны хүчин чадлыг сайн хэмээн үнэлсэн байна.
- Хамааралтай секторуудын чанарын үзүүлэлт дунд үнэлгээтэй байна. Хэдийгээр хүн амын 33 хувь нь дээд боловсролтой боловч олон улсад хүлээн зөвшөөрөгдөөгүй тул боловсролын чанарын хувьд хангалтгүй үнэлгээ авсан байна. Харин олон улсын санхүүгийн байгууллагууд буюу ДБ, АХБ, ЕСБХБ, ОУВС-ын салбар байдаг нь хамааралтай секторын үнэлгээнд эерэгээр нөлөөлсөн. Эрүүл мэнд, аялал жуулчлал, зугаа цэнгэлийн салбар харьцангуй хөгжсөн гэж үзсэн боловч тогтвортой тээвэр, логистикийн үйлчилгээ байхгүй бизнес эрхлэхэд тээвэр хамгийн хүндрэлтэй асуудал байгаа нь маш муу буюу хамгийн хангалтгүй үнэлгээг авч нийт үнэлгээний дунджид сөргөөр нөлөөлсөн байна.

Санхүүгийн секторын нийт үнэлгээ ерөнхийдөө жигд дунд байна. Салбарт хамгийн сөрөг нөлөөтэй хүчин зүйлс нь төгрөгийн ханшны тогтворгүй байдал, өндөр инфляци, хөрөнгийн зах зээлийн сул байдал байхад хамгийн эерэг нөлөөтэй хүчин зүйлс нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн хөгжил, ДБ, ОУВС, АХБ зэрэг олон улсын санхүүгийн институцийн салбар идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг, газарзүйн хувьд эдийн засгийн өсөлттэй бүсэд байрладаг зэрэг байна (Зураг 3.10-аас харна уу).

Зураг 3.10. Санхүүгийн зах зээлийн нийт үнэлгээ



Эх сурвалж: Хавсралтад хоёрдогч өгөгдлийн эх сурвалжийг дэлгэрэнгүй дурдсан.

Судлаачийн зүгээс нийт үнэлгээ дунд байгааг Монгол Улсад санхүүгийн чөлөөт бүс байгуулах боломж байна гэж үзсэн. Учир нь муу үнэлгээтэй нилээд хэдэн хүчин зүйлс нь макро эдийн засгийн үзүүлэлтүүд бөгөөд эдийн засаг хөгжихийн хирээр аяндаа сайжрах үзүүлэлт байна. Түүнчлэн санхүүгийн чөлөөт бүсийг амжилттай байгуулахад эдгээр үзүүлэлтүүд дагаад сайжрах бүрэн боломжтой юм. Мөн өрсөлдөөний 4 хүчин зүйлсээс муу үнэлгээтэй хүчин зүйлс байхгүй байгаа нь санхүүгийн салбарын суурь хангалттай сайн тавигдсан бөгөөд тухайн зах зээлийг цаашид хөгжүүлэх бодлого, гарцыг зөв тодорхойлох шаардлагатай гэж үзэж байна. Нөгөө талаас, өрсөлдөөний 4 хүчин зүйлсэд сайн үнэлгээтэй хүчин зүйлс байхгүй байгаа нь өрсөлдөөнд давуу тал байхгүй буюу чөлөөт бүсийг амжилттай байгуулахад нилээдгүй сорилттой тулгарч байгааг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй юм.

Бүлгийн дүгнэлт

Казакстан улсын Астана санхүүгийн чөлөөт бүсийг амжилттай байгуулсан туршлага болон өрсөлдөх чадварын шинжилгээний үр дүнгээс үзэхэд Монгол Улсын санхүүгийн чөлөөт бүс байгуулах, түүнийг хөгжүүлэх боломж байгаа хэдий ч өрсөлдөөний давуу тал байхгүй байгаа нь тухайн бүсийг байгуулахад шаардагдах нөөц бололцоогоо зохих ёсоор үнэлж, стратегиа зөв тодорхойлох шаардлагатайг харуулж байна. Тодруулбал, Казакстан улс нь далайд гарцгүй орны нэг бөгөөд БНХАУ болон ОХУ-ыг холбосон газарзүйн байршилтай, социалист нийгмийн байгууллаас ардчилсан нийгэмд шилсэнээс гадна нүүдэлчин соёл иргэншилтэй зэрэг маш олон талаараа Монгол Улстай ижил төстэй юм. Тэр ч утгаараа БНХАУ, эсхүл ОХУ-ын санхүүгийн чөлөөт бүс бус Астана санхүүгийн чөлөөт бүс нь бидний өрсөлдөгч байж болохоор байна.

Гэхдээ уг чөлөөт бүсийг байгуулсан туршлага, аргыг нарийвчлан судалж МУ-д СЧБ амжилттай байгуулах боломжийг олгож байна.

IV БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ

Өмнөх бүлэгт АСЧБ-ийг амжилттай туршлагыг судлахын зэрэгцээ МУ-ын санхүүгийн зах зээлийн өрсөлдөх чадварыг Даймонд аргаар үнэлсэн. Үнэлгээний үр дүнд МУ-д СЧБ байгуулах боломж байна гэж судлаачийн зүгээс үзсэн бөгөөд амжилттай байгуулахын тулд АСЧБ-ийн туршлагыг нарийвчлан судлах шаардлагатай гэж дүгнэсэн.

4.1. Астана санхүүгийн чөлөөт бүсийн хөгжлийн стратеги

Өмнөх бүлэгт АСЧБ-ийн туршлагыг нарийвчлан судлах шаардлагатай байна хэмээн дүгнэсэн. Иймд Астана санхүүгийн чөлөөт бүсийг байгуулах болсон шалтгаан зорилго, хөгжлийн стратегийг энэхүү дэд бүлэгт судлана.

АСЧБ-ийг байгуулах шалтгаан

Казакстан улс нь ЗСБНОХУ задран унаснаар тусгаар тогтнолоо зарласан. Эдийн засгийн голлох салбар нь газрын тосны экспорт бөгөөд 2000-2010 оны хооронд газрын тосны үнийн өсөлтөөс шалтгаалан экспортын хэмжээ эрчтэй өсч, эдийн засаг, санхүү, төсвийн хувьд чадавхижсан. 2009 оноос сэргээхдэх эрчим хүчний салбарт голлох анхаарлаа хандуулан ураны экспортын хэмжээ нэмэгдэж эхэлсэн.

Санхүүгийн салбарын хувьд социалист орнуудтай адил банкны салбар голлох үүргийг гүйцэтгэж байсан бөгөөд 1993 онд анхны хөрөнгийн бирж KASE-г үүсгэн байгуулсан. Гэвч банкны зээлийн тэлэлт болон хөрөнгийн зах зээлийн хөгжил сул хэвээр

байсан. Үүнд голлон нөлөөлж байсан хүчин зүйлс нь иргэдийн санхүүгийн мэдлэг, санхүүгийн бүтээгдэхүүний хэрэглээ хангалтгүй байдал болон шилжилтийн үеийн нөлөөлөл болох эдийн засгийн мөчлөг, олон улсын зээлийн тогтвортой бус хэрэглээ, ханшийн тогтворгүй байдал, санхүүгийн тайлангийн ил тод бус байдал зэрэг байсан (АХБ, 2018).

Хэдийгээр санхүүгийн зах зээлд төрийн өмчийн 1, гадаадын хөрөнгө руулалттай 15, нийт 33 банк үйл ажиллагаа явуулж, нийт хөрөнгийн хэмжээ 77 тэрбум буюу ДНБ-ийн 58 хувийг эзэлж байсан ч банкны үйлчилгээний хүртээмжтэй байдал бүс болгонд ялгаатай байсан. Тодруулбал Астана ба Алматы хотоос бусад хотод банкны салбар хангалттай бус байсан. Мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр банкнаас олгох хэрэглээний зээл буурч, эрэлт уг бичил санхүүгийн байгуулагууд уруу шилжиж, 1 жилийн дотор зээл олголт 50 хувиар өсч 2016 онд 0.3 тэрбум ам.доллар, 2017 оны эхний 6 сарын байдлаар 30 хувиар өсч 0.4 тэрбум ам.долларт хүрч нийт 160 бичил санхүүгийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байсан. Даатгалын салбарын хувьд нийт 32 компани бүртгэлтэй байснаас 22 нь төрийн өмчийн даатгалын сангийн гишүүн байсан ба нийт хөрөнгө харьцангуй бага буюу ДНБ-ийн 2 хувийг эзэлж байсан.

KASE хөрөнгийн биржийн тухайд тэтгэврийн сангийн шинэчлэл хийж, хувийн тэтгэврийн сан байгуулагдснаас хойш хөрөнгийн биржийн арилжааны тоо хурдацтай өссөн. Гэвч 2013 онд ЗГ-ын шийдвэрээр хувийн тэтгэврийн санг төрийн өмчит тэтгэврийн санд нэгтгэсэнээр 2010 онд 354 компани хөрөнгийн биржид бүртгэлтэй байсан бол, 2017 он гэхэд 142 болтлоо огцом буурсан. Нийт гүйлгээний 52 хувийг гадаад валютын арилжаа, 46 хувийг репо хэлцэл, үлдсэн 1 хувийг хувьцааны арилжаа эзэлж байсан бөгөөд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 47 тэрбум ам.доллар байсан. Казакстаны ихэнхи компаниуд гадаадын хөрөнгийн зах зээл дээрээс санхүүжилт босгодог байснаас гадна уул уурхайд суурилсан эдийн засагтай учраас 2010 оноос хойш экспортын голлох бүтээгдэхүүний үнийн унаж эхэлсэн нь тус улсын эдийн засагт хүндээр тусч байсан. Иймд бодлогын зайлшгүй өөрчлөлт хийх, ялангуяа эдийн засгийг төрөлжүүлэх зайлшгүй шаардлагатай болсон. Энэ нь эргээд санхүүгийн салбарыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг бий болгосон.

Казакстан улсын Ерөнхийлөгч Назарбаевын санаачилгаар 2012 оны 12 сард “Казакстаны урт хугацааны хөгжлийн стратеги 2050”-ийг баталсан. Улмаар 2015 оны 5 сард “Бодит 100 алхам” буюу Хөгжлийн стратеги 2050-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авахаа зарласан ба энэхүү арга хэмжээний хүрээнд шинэчлэлийн 5 бодлого хэрэгжүүлэхээ зарласан. Энэхүү шинэчлэлийн бодлогын нэг нь санхүүгийн салбарыг хөгжүүлэх байсан. Санхүүгийн салбарыг хөгжүүлэх шинэчлэлийн бодлогын гол стратеги нь Астана санхүүгийн чөлөөт бүс байгуулах байсан.

АСЧБ байгуулах үндсэн зорилгыг дараах байдлаар тодорхойлсон:

Гадаад зах зээлийн сөрөг нөлөө, геополитикийн тогтворгүй байдлын улмаас дотоодын бизнесийн мөчлөг удааширч байгаа тул санхүүгийн салбарыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг бий болгож буйг дурдаад санхүүгийн чөлөөт бүс байгуулах нь үүний эсрэг авч болох хамгийн оновчтой арга хэмжээ юм гэж тодорхойлсон байна. Санхүүгийн чөлөөт бүсийг Астана хотод байгуулах бөгөөд Казакстан улсын санхүүгийн

салбар, тэр дундаа банкны бус санхүүгийн салбарыг хөгжүүлэх нь АСЧБ байгуулах үндсэн зорилго байна хэмээн томъёолжээ.

Астана санхүүгийн чөлөөт бүсийг амжилттай байгуулах б хүчин зүйлсийг дараах байдлаар тодорхойлсон.

1. Дэлхийн хамгийн шилдэг туршлагад тулгуурласан ил тод, ойлгомжтой эрх зүйн системийг үүсгэх нь чөлөөт бүсийг сонирхогч болон оролцогчдын итгэлийг баталгаажуулах хамгийн чухал зүйл юм.

Энэхүү системийг бий болгохын тулд Казакстан улсын үндсэн эрх зүйн системээс тусдаа Английн нийтийн эрх зүйн системд суурилсан эрх зүйн системийг бий болгох шаардлагатай гэж тодорхойлсон. Мөн тусдаа шүүх байгуулах бөгөөд Английн эрх зүйн системээр мэргэшсэн, өндөр ур чадвар шүүгч нарыг бэлтгэнэ. Үүнээс гадна, Арбитрын маргааныг шийдвэрлэх тусдаа институци байгуулна.

2. Хөрөнгө оруулагч болон санхүүгийн үйлчилгээний хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах болон системийн эрсдлийг хамгийн бага түвшинд байлгахын тулд санхүүгийн зах зээлийн үр ашигтай, ил тод, шудрага байдлыг хангасан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу хууль, тогтоомж, дүрэм, журмыг боловсруулна.

Бүсийн хууль, тогтоомж, дүрэм, журмыг батлагч этгээд нь тодорхой бөгөөд маргаангүй байхаас гадна Астана санхүүгийн чөлөөт бүсийг хөгжүүлэхэд бүхий л үйл ажиллагаа, стратегийг чиглүүлж, өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй, бүсийн захирагчид ажлаа тайлагнана. Мөн хууль, тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих, шалгах онцгой эрхтэй этгээд байна.

3. Астана санхүүгийн чөлөөт бүсийн хөрөнгийн бирж нь дотоодын санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхийн тулд дэлхийн хамгийн шилдэг туршлагыг нэвтрүүлнэ.

Астана хөрөнгийн бирж нь хувьцаат компанийг бүртгэх, арилжаа хийх, үнэт цаасны бүртгэл хийх, төлбөр тооцоог хийж гүйцэтгэх бүхий л орчинг бүрдүүлнэ. Түүнчлэн хөрөнгийн зах зээлийн ил тод байдлыг хангана.

4. Дотоодын болон гадаадын хөрөнгийн урсгалыг татах хөрөнгө оруулалтын менежмент хийхийн тулд мэргэжлийн, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн менежерүүдийг ажиллуулах нөхцөл бололцоо, орчинг бий болгоно.

Гадаадын хөрөнгийн менежментийн компанийг нутагшуулах нь дотоодын хөрөнгийн менежмент болон хөрөнгийн зах зээлийн хөгжилд өндөр үр ашигтай байна.

5. Тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих, ногоон санхүүжилтийг хөгжүүлэхэд түлхүү анхаарах шаардлагатай байна.


Уул уурхай ба уламжлалт эрчим хүчний эх үүсвэрт суурилсан эдийн засагтай Казакстан улсын хувьд хүрээлэн буй орчин болон нийгмийн хүчин зүйлсийг анхаарч үзэх нь чухал ач холбогдолтой юм. Сэргээгдэх эрчим хүчний технологи болон хүрээлэн буй орчны төсөлд хөрөнгө оруулалт татахад онцгой анхаарна. Иймд чөлөөт бүс нь ногоон санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжүүлэх, тэр дундаа ногоон бонд гаргана.

6. Дэлхийн хамгийн шилдэг экспертүүдийг цуглуулах орчин, нөхцлийг бүрдүүлэх замаар Казакстаны хүний нөөцийг хөгжүүлэх гол орон зай, дотоодын экспертүүдийн төв болно.

Чөлөөт бүсийг үүсгэн байгуулахад дотоодын санхүүгийн зах зээлийн төлөөлөгчид болон гадаадын экспертүүдийн оролцоо, хамтын ажиллагааг бий болгоход тулгарах саадыг бууруулна. Эхний 5 жилд татвараас чөлөөлөх, визийг хялбаршуулсан горимоор олгох, Астана уруу дэлхийн гол санхүүгийн төвүүдээс шууд нислэгтэй болгоно. Сургалт, хөгжлийн хөтөлбөр, олон улсын сертификат болон судалгааны ажилд онцгой анхаарал хандуулах нь чөлөөт бүсийн хөгжлийг дэмжихэд чухал ач холбогдолтой гэж тодорхойлжээ.

Түүнчлэн АСЧБ-ийг байгуулахад Москва, Франкфурт, Лондон, Вьенна, Парис, Бангкок, Бээжин, Сөүл, Истанбул болон Абу Даби, Дубай зэрэг хотуудаас шууд нислэг үйлддэг болсон байсан. Төв Азийн бүсээс Ташкент, Бишкек, Душанби, Баку зэрэг олон газраас мөн шууд нислэг үйлдэж байсан. 2023 он гэхэд Ром, Хонг Конг, Сингапур, Цурих, Нью-Йорк, Шанхай зэрэг хотуудаас шууд нислэг үйлддэг болохоор төлөвлөсөн (Зураг 4.1-ээс харна уу). Өнөөдрийн байдлаар дээрх хотуудаас Астана хот уруу хямд нислэг үйлддэг болсон байна.

Зураг 4.1. Астана хот уруу шууд нислэг үйлддэг хотуудын газрын зураг



Эх сурвалж: АСЧБ-ийн тайлан, 2019

Астана чөлөөт бүсийн дэд бүтэц, барилга байгууламжийн төлөвлөлт:

Амжилттай хөгжсөн дэлхийн санхүүгийн төвүүдийн жишгийг дагаж, АСЧБ-ийн 1,632 га газарт орчин үеийн шаардлагад нийцсэн дэд бүтэц, барилга байгууламж, өндөр түвшний технологийн инженерчлэл, институциудыг бий болгоно. АСЧБ-д орчин үеийн хотын төлөвлөлт, тээвэр, инженерийн бүхий л шийдлийг бий болгосноор 18,000 үйлчилгээний салбарын ажлын байр бий болно. Тодруулбал, өндөр чанартай орон сууц, нийгмийн болон соёлын төвүүд, эрүүл мэнд, боловсролын систем, чөлөөт цагаа өнгөрүүлэх, амарч зугаалах төвүүдийг байгуулна (Зураг 4.2-оос харна уу).

Зураг 4.2. АСЧБ-ийн нутаг дэвсгэр



Эх сурвалж: AIFC presentation in Tokyo, 2018

Мэдээлэл, харилцаа холбооны хамгийн сүүлийн үеийн технологийг нэвтрүүлнэ. Санхүүгийн гүйлгээ хийхэд шаардлагатай бүртгэл, мэдээлэл, хадгалалтын цогц систем болон мэдээллийн аюулгүй байдлыг маш сайн хангасан байна. Хамгийн чухал нь хөрөнгө оруулалтын банк, давхар даатгалын компани, бүхий л төрлийн сан, зөвлөх үйлчилгээний компаниуд нь гадаадын болон дотоодын компаниуд байх нөхцөл бололцоогоор хангана.

Ахисан түвшний сургалтын институци, техникийн лаборатори, санхүүгийн үйлчилгээний хөгжлийн төв нь шинэ санаа, санаачлалыг дэвшүүлж хөгжүүлж байх гол эх үүсвэр болно. Өөрөөр хэлбэл, эдгээр нь санхүүгийн үйлчилгээг үзүүлэх мэргэжлийн ур чадвар, боловсролын чанарыг сайжруулах гол хүчин зүйл болно. Олон улсын санхүүгийн төв бий болсноор 2,000-аас дээш тооны ажлын байрыг санхүүгийн салбарт бий болгоно. Иймд энэ ажлын байрт хүрэлцэхүйц хүний нөөцийг бэлдэхийн тулд Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгийн хөтөлбөрийг зарлана.

Астана санхүүгийн чөлөөт бүс нь дараах 5 тулгуур баганыг бий болгоно. Үүнд:

❖ Хөрөнгийн зах зээл

Казакстаны хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулснаар гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлнэ. Хөрөнгийн зах зээлийн хөгжил нь банкны системийн төвлөрлийг бууруулж, хөрөнгө оруулалтын бусад сонголтыг бий болгох ба улсын болон бүс нутгийн түвшинд санхүүгийн эх үүсвэрийг чөлөөтэй урсах боломжтой болгосноор зах зээлд тоглогчдын сонирхол, үндэсний эдийн засгийн хэрэгцээ хоёрын огтлолцлыг бий болгоно.

❖ Хөрөнгийн менежмент

Дотоодын зах зээлийн хөгжил ба хөрөнгийн менежментийн чадварлаг мэргэжилтэн, дэлхийн тэргүүлэгч хөрөнгийн менежментийн компанийг АСЧБ-д татсанаар Казакстаны хөрөнгийн зах зээлийн хөгжлийн суурь болно.

❖ Санхүүгийн технологи

Технологийн өндөр шийдэл бүхий платформоор санхүүгийн үйлчилгээний хөгжлийг шинэ шатанд гаргаснаар уламжлалт санхүүгийн үйлчилгээний өртгийг бууруулж, дэлхийн хөрөнгийн зах зээлтэй интеграцид орох боломжтой болох ба дотоодын санхүүгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлнэ.

❖ Исламын санхүү

Исламын банк болон банк бус санхүүгийн үйлчилгээ болон Исламын хөрөнгийн зах зээлийн хэрэгслийг хөгжүүлнэ. Исламын санхүүгийн зарчимд суурилсан онцлог шинж чанартай хууль, тогтоомжийг боловсруулахыг шаардлагатай болно.

❖ Хувийн банкны цогц үйлчилгээ

Хөрш улсын чинээлэг иргэд болон санхүүгийн өндөр чадамж бүхий хүмүүст чиглэсэн хөрөнгийн менежмент болон хувийн банкны үйлчилгээг хөгжүүлнэ.

АСЧБ-ийг үүсгэн байгуулсан нь:

2015 онд Үндэсний төлөвлөгөө “Бодит 100 алхам”-ын хүрээнд АСЧБ байгуулах шийдвэрийг гаргасан. Энэхүү шийдвэрийн хүрээнд Казакстаны үндсэн хуульд өөрчлөлт оруулж эрх зүйн үндсийг нь тавьж өгсөн.

2016 онд АСЧБ-ийн Менежмент консулаас бүтэц, зохион байгуулалт болон хөгжлийн стратегийг тодорхойлж өгсөн.

2017 онд өндөр ур чадвар бүхий мэргэжилтнийг татах таатай орчныг бүрдүүлэхийн тулд Экспат төвийг байгуулсан. Шанхайн хөрөнгийн бирж болон Насдак корпорацитай хөрөнгийн бирж байгуулах хэлцэлд гарын үсэг зурсан. Шүүх болон арбитрыг үүсгэн байгуулсан.

2018 оны 1 дүгээр сарын 1-нд хууль, тогтоомж, эрх зүйн актууд батлагдан, хүчин төгөлдөр болсон.

АСЧБ-ийн эрх зүйн системийг бий болгосон нь:

Казакстаны үндсэн хууль нь тус улсын эрх зүйн системийн хамгийн дээд хүчин чадал бүхий хууль юм. Үндсэн хуулийн 2 дугаар зүйлд АСЧБ-ийн нутаг дэвсгэр дотор санхүүгийн салбарт үйлчлэх онцгой эрх зүйн дэглэм үүсгэж болно гэж заасан.

Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлд Казакстаны үндсэн хуульд үндэслэсэн АСЧБ-ийн хууль, дүрэм, журам нь дараах хэсгээс бүрдэнэ гэж заасан. Үүнд:

- i. Үндсэн хууль,
- ii. Үндсэн хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд АСЧБ-ийн захиргааны байгууллагаас нийцүүлэн гаргасан Англи болон Уэльсийн эрх зүйн системийн преседент, дэлхийн тэргүүлэгч санхүүгийн төвүүдийн стандартад суурилсан АСЧБ-ийн эрх зүйн хэм хэмжээний акт,
- iii. АСЧБ-ийн эрх зүйн хэм хэмжээний акт болон Үндсэн хуульд заагаагүй аливаа асуудалд үйлчлэх Казакстаны хууль тогтоомж.

Газрын тос болон ураны экспорт эдийн засгийнх нь дийлэнхи хувийг эзлэх Казакстан улсын хувьд 2010 оноос хойшхи уул уурхайн бүтээгдэхүүний үнийн уналт нь

эдийн засгийн шинэчлэл хийж, уул уурхайгаас бусад салбарыг хөгжүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлагатай тулгарсан. Энэ нь тус улсыг урт хугацаанд хөгжлийн бодлого, стратегиа тодорхойлох, түүнд хүрэх бодит алхамуудыг хэрэгжүүлэхэд нөлөөлж, өнөөдрийн Астана санхүүгийн чөлөөт бүсийг амжилттай байгуулахад хүргэжээ. Тус санхүүгийн чөлөөт бүсийг үүсгэн байгуулахаар 2015 онд үндсэн хуулиндаа өөрчлөлт оруулж, эрх зүйн үндсийг нь тавьж өгсөн бөгөөд улмаар 2018 он хүртэл бэлтгэл ажлаа хангажээ. Судлагдсан байдлын судалгааны хүрээнд МУ-д ЧБ амжилттай хэрэгжиж чадахгүй байгаа шалтгааныг МУ-ын судлаачид чөлөөт бүсийн хууль, эрх зүй, дэд бүтэц, амьдрах орчин, эрүүл мэнд, боловсролын систем зэрэг тухайн бүсэд бизнес эрхлэхэд шаардлагатай орчиныг цогцоор нь шийдвэрлээгүй байна хэмээн дүгнэсэн. Харин Казакстан улс нь тус СЧБ-ийг байгуулахдаа бүх асуудлыг цогцоор нь шийдвэрлэсэн байгаа нь амжилтад хүрэхэд нөлөөлжээ.


Түүнчлэн иргэний эрх зүйн системтэй Казакстан улс нь нийтийн эрх зүйн систем болох Английн эрх зүйн системийг онцгойлон зааж чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлсэн байна. ОУСТ-ийг өрсөлдөх чадвараар үнэлэхэд нийтийн эрх зүйн системтэй эсэх гэх хүчин зүйлс байсан бөгөөд санхүүгийн салбарт Английн эрх зүйн системийг бий болгох нь амжилтад хүрэх нэг түлхүүр байх боломжтой байна. Иймд эрх зүйн системүүдийн хоорондын ялгаа болон санхүүгийн салбарын хэрэглэгчид, хөрөнгө оруулагчид нийтийн эрх зүйн системд итгэх итгэл өндөр байгаагийн учир шалтгааныг, МУ СЧБ байгуулахдаа уг системийг авч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг нарийвчлан судлах шаардлагатай байна. Мөн АСЧБ байгуулснаар Казакстан улсын санхүүгийн зах зээл хэрхэн хөгжсөнийг цаашид судлах нь зүйтэй байна.

4.2. Казакстан улсын санхүүгийн зах зээлийн хөгжил


АСЧБ байгуулсан гол зорилго нь дотоодын санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх байсан тул чөлөөт бүс байгуулснаас хойшхи 5 жилийн хугацаанд дотоодын санхүүгийн зах зээлийн үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдсөнийг судлан шинжлэх, харьцуулах аргаар үр дүнг үнэлэхийг энэхүү дэд бүлэгт зорилоо.

KASE хөрөнгийн бирж нь 1993 онд үүсгэн байгуулагдсан. 2018 оны 12 сарын байдлаар нийт 52 хувьцаа эзэмшигчтэй байснаас 50.4 хувийг КУБ эзэмшиж байсан бол 2023 оны 12 сарын байдлаар нийт 68 хувьцаа эзэмшигчтэй болж КУБ-ын эзэмшил хувь 47 болж бууран, жижиг хувьцаа эзэмшигчид 6 хувийг эзэмших болсон байна.

Зураг 4.3. Гишүүдийн тоо, 2018 он



Зураг 4.4. Гишүүдийн тоо, 2023 он



Эх сурвалж: KASE үйл ажиллагааны тайлан, 2018 ба 2023

Эрхэм зорилго:

Дотоодын бизнес эрхлэгчдэд шаардлагатай хөрөнгийг бүхий л төрлийн санхүүгийн хэрэгслүүдийг санал болгох замаар босгох, санхүүгийн систем дэх хөрөнгийг дахин хуваарилах болон хөрвөх чадварыг сайжруулахад шаардлагатай дэд бүтэц, платформоор хангах, дотоод, гадаадын хөрөнгө оруулагч нарт ил тод, нээлттэй хөрөнгө оруулалтын орчныг санал болгох замаар Казакстан улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах болно.

Зорилго:

Бүс нутагтаа тэргүүлэгч арилжааны платформ болж, оролцогчдын үнэ цэнийг өсгөнө.

KASE хөрөнгийн биржийг байгуулснаас хойш 2 жилийн дараа буюу 1995 онд анхны ерөнхийлөгч Назарбаев Банкуудын холбооны уулзалтын үеэр бүс нутгийн хэмжээний санхүүгийн чөлөөт бүс байгуулна хэмээн зарласан. 2004 онд Ерөнхийлөгч Назарбаев Казакстаны санхүүгийн зуучлагч нарын хуралд илтгэл тавихдаа мөн энэ тухай дурдсан байдаг. Улмаар 2005 оны 3 сард Дэлхийн хамгийн өрсөлдөх чадвар бүхий 50 улсын нэгт багтах Казакстаны стратегийг боловсруулсан. Энэхүү стратегийн хамгийн эхний хэсэгт Алмати хотыг бүс нутгийн хэмжээний санхүүгийн төв болгон хөгжүүлнэ гэж заасан. 2006 онд 6 сарын 5-нд Казакстан хууль баталж эрх зүйн тусгай дэглэм бүхий Алматигийн бүс нутгийн санхүүгийн төв байгуулна, мөн тусгай арилжааны платформ бүхий санхүүгийн төв нь хувьцааны арилжааны платформоор Алмати хотод үйл ажиллагаагаа явуулна гэж зааж өгсөн. Түүнчлэн тусгай шүүх байгуулах бөгөөд шүүхийн үйл ажиллагаа Казакстан улсын албан ёсны хэлнээс гадна Орос, Англи хэлээр явуулж болно гэж зохицуулсан. Энэхүү санхүүгийн төв амжилттай хэрэгжиж чадаагүй шалтгааныг дараах байдлаар тодорхойлсон байна (Murat Temirkhanov, 2022).

- Дотоодын үнэт цаасны зах зээл хөгжөөгүй, хөгжүүлэхгүйгээр гадаадын хөрөнгө оруулагчдыг татах боломжгүй,
- Засгийн газрын үнэт цаасны зах зээл хөгжөөгүй,
- Төр болон хувийн хэвшлийн түншлэлийн үр ашигтай механизм байхгүй,
- Төрийн өмчит компаниудын IPO амжилгүй болсон (12 тэрбум ам.доллар гэж төлөвлөж байсан боловч 300сая ам.доллар болсон)
- Компанийн үнэт цаасны зах зээлийн үнэлгээ хүлээлтэд хүрээгүй (ДНБ-ын 70 хувьд хүрнэ гэж төлөвлөсөн боловч 1 хувьд ч хүрээгүй)

2011 онд Казакстаны ихэнхи судлаачид Бүс нутгийн хэмжээний санхүүгийн чөлөөт бүс байгуулах стратеги төлөвлөгөө бүтэлгүйтсэнийг хүлээн зөвшөөрч эхэлсэн. Эдийн засагчид, эрдэмтэд шалтгааныг янз бүрээр тайлбарлаж байсан боловч үндсэндээ 2 гол хүчин зүйлс нөлөөлсөн гэж үзсэн (M.Z. Kenzhaliyev, 2022).

1. Эдийн засгийн хүчин зүйл

Алматигийн чөлөөт бүс байгуулах стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үед дэлхийн эдийн засагт хямрал нүүрэлсэн бөгөөд энэ нь Казакстаны эдийн засагт хүчтэй нөлөө үзүүлсэн. Түүнчлэн, Казакстан улсын Үндэсний Банкны Ерөнхийлөгчийн зөвлөх Айдархан Кузайновын үзэж байгаагаар Алмати санхүүгийн чөлөөт бүсийн ОУ-ын

хөрөнгө оруулагчдыг татах чадамжгүй байдал нь дотоодын компаниудын хэмжээ жижиг, эргэц багатай байсантай холбоотой байна.

2. Хууль, эрх зүйн системийн хүчин зүйл


Алмати СЧБ байгуулах хууль нь зөвхөн санхүүгийн зах зээлийг байгуулах тухай байсан. Энэхүү хууль тогтоомжид Алмати хотыг цогцоор нь хөгжүүлэх тухай огт тусгаагүй байна. Өөрөөр хэлбэл санхүүгийн бүхий л төрлийг болон үйл явцыг хамарсан хууль, тогтоомж, дүрэм, журам, түүнийг хэрэгжүүлэх найдвартай шүүхийн тогтолцоо, төлбөр тооцооны валют, татвар, визаны журам гэх мэт бүхий л зүйлсийг иж бүрэн зохицуулахгүйгээр гадаадын хөрөнгө оруулалтыг татах, санхүүгийн чөлөөт бүсийг хөгжүүлэх боломжгүй юм. Түүнчлэн АСЧБ амжилттай хэрэгжсэн нэг гол хүчин зүйл нь Английн эрх зүйн системийг хэрэгжүүлэхээр онцгойлон зааж өгсөн явдал юм. Учир нь нийтийн эрх зүйн систем нь зан заншлын эрх зүйд суурилан бий болсон буюу хүмүүсийн бизнесийн суурь харилцаанаас үүссэн. Олон зуун жилийн туршид дэлхийн хөгжлийг тэргүүлэгч улс орнуудын бизнес, санхүүгийн ертөнцийн харилцаанд заншил болон тогтсон тэрхүү жишгийг эрх зүйн системээр системчилсэн учраас хөрөнгө оруулагчид Английн эрх зүйн системд танил байхаас гадна итгэх итгэл нь өндөр байдаг байна.

Казакстан улсын эрх баригчид 2024 онд АСЧБ дэх АИХ хөрөнгийн биржийг KASE хөрөнгийн биржтэй менежментийн түвшинд нэгтгэж дотоодын зах зээлийн чадавхийг тэлэх стратеги баримтлан боломжит саналуудыг хувьцаа эзэмшигч нарт танилцуулахаар бэлдэж байна. АИХ хөрөнгийн бирж нь үнэт цаасны зах зээл болон урт хугацаат бондын зах зээлийг хөгжүүлэхэд түлхүү анхаарч ажиллах бол KASE хөрөнгийн бирж мөнгөний зах зээлд илүү төвлөрөн репо арилжаа, санхүүгийн үүсмэл хэрэгслэлийг хөгжүүлэх анхаарч ажиллана.

Анхны санхүүгийн төв болох Алмати хот, KASE хөрөнгийн бирж нь олон саад бэрхшээлтэй тулгарсан хэдий ч, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулсаар ирсэн бөгөөд АСЧБ-ийн хөгжил нь дотоодын зах зээлийн хөгжилд хэрхэн нөлөөлснийг хөрөнгийн зах зээлийн голлох үзүүлэлт болох ашигт ажиллагаа, зах зээлийн үнэлгээ, арилжааны тоо болон хэмжээ зэргийн хүрээнд харьцуулах замаар судлаачийн зүгээр тодорхойлохыг хичээсэн.

Тус хөрөнгийн биржийн 2014 оны 2022 оны хоорондох ашигт ажиллагааны үзүүлтийг харьцуулж үзэхэд цэвэр ашиг 4 дахин, өөрийн хөрөнгийн өгөөж 13.2-оос 30 хувь хүртэл өссөн бол нийт хөрөнгийн өгөөжийг 11.8-аас 0.1 болж буурсан байна. Нийт хөрөнгийн өгөөж буурсан шалтгаан нь нийт хөрөнгө 31.3сая ам.доллараас 26.1 тэрбум ам.доллар болж өссөнтэй холбоотой байна (Зураг 4.5-аас харна уу).

Зураг 4.5. Ашигт ажиллагааны үзүүлэлт



Эх сурвалж: KASE үйл ажиллагааны тайлан, 2018 ба 2023

Хөрөнгийн биржийн 2018 оны арилжааны үзүүлэлтийг 2023 оны арилжааны үзүүлэлттэй харьцуулахад нийт дүнгээрээ арилжааны хэмжээ 132 хувиар, өдрийн арилжааны дундаж тоо 293 хувиар, өдрийн арилжааны дундаж хэмжээ 134 хувиар тус тус өссөн байна (Зураг 4.6-аас харна уу).

Зураг 4.6. Арилжааны үзүүлэлт

Market sector	Volume USD mln		↑	Average daily number of deals		↑	Average daily volume of deals USD mln		↑
	2018	2023		2018	2023		2018	2023	
Securities Market	12,618.2	22,833.1	81%	601	3,715	518%	55.3	101.0	83%
Equities	1,508.3	685.1		585	3,204	448%	6.6	3.0	
KASE Global	-	76.2		-	237		-	0.3	
Corporate bonds	5,559.7	4,374.7		9	169	1778%	24.4	19.4	
Government securities	4,392.8	17,143.0	290%	6	21	250%	19.3	75.9	293%
IFO bonds	288.3	526.2	83%	1	2	100%	1.3	2.3	77%
Investment funds securities	1.0	24.1	2310%	1	67	6600%	0.1	0.1	
GDR	868.0	3.8		1	14	1300%	3.8	0.1	
Foreign currency	36,235.7	59,520.9	64%	315	596	89%	158.9	263.4	66%
Money market	297,626.3	722,101.0	143%	497	1,242	150%	1,305.4	3,195.1	145%
Repo transactions	205,310.7	598,917.8	192%	450	1,215	170%	900.5	2,650.1	194%
Foreign currency swap	92,315.6	123,183.1	33%	47	27		404.9	545.1	35%
Derivatives	-	64.6		-	0.1		-	0.3	
Total	346,480.2	804,519.7	132%	1,413	5,553	293%	1,519.6	3,559.8	134%

Эх сурвалж: KASE үйл ажиллагааны тайлан, 2018 ба 2023

Хөрөнгийн биржийн 2015 оны зах зээлийн үнэлгээг 2023 оны зах зээлийн үнэлгээтэй харьцуулахад 44 хувиар өссөн байх бөгөөд 2017 оны огцом өсөлтийг эс тооцвол 2019 оны хүртэл 40 гаран тэрбум ам.долларын хооронд тогтвортой байсан байна. 2020 оноос зах зээлийн үнэлгээ өсч эхэлсэн байх бөгөөд 2021 оны огцом өсөлтийг эс тооцвол сүүлийн 2 жил жигд эрчимтэй өсчээ (Зураг 4.7-оос харна уу).


Зураг 4.7. Зах зээлийн үнэлгээ



Эх сурвалж: KASE үйл ажиллагааны тайлан, 2018 ба 2023

Хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ буюу АИХ болон KASE хөрөнгийн биржийн зах зээлийн үнэлгээний нийлбэрийг Казакстан улсын ДНБ-тэй харьцуулж харвал 2018 онд 23 хувь байхад 2023 онд 47 хувь болж нэг дахин өссөн байна (Зураг 4.8-аас харна уу).


Зураг 4.8. Зах зээлийн үнэлгээ /Астана, KASE/



Эх сурвалж: KASE үйл ажиллагааны тайлан, 2018 ба 2023

Хөрөнгийн биржийн идэвхитэй жижиг хөрөнгө оруулагчдын 2018 оны тоог 2023 оны тоотой харьцуулж харвал 7.9 дахин өссөн үр дүнтэй байна (Зураг 4.9-өөс харна уу).


Зураг 4.9. Жижиг хөрөнгө оруулагчдын тоо



Эх сурвалж: KASE үйл ажиллагааны тайлан, 2018 ба 2023

Харин оршин суугч биш этгээдийн хөрөнгийн бирж дээрх хувьцааны арилжааны эргэлтийг харвал 2017 онд 5.2 хувь байхад 2023 онд 27.5 хувь болж 5.3 дахин өссөн байна. 2020 болон 2021 онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор уг үзүүлэлт огцом буурсан ч 2022 оноос эрчимтэй өсөж эхэлсэн байна (Зураг 4.10-аас харна уу).

Зураг 4.10. Оршин суугч бус этгээдийн хувьцааны арилжааны эргэлт



Эх сурвалж: KASE үйл ажиллагааны тайлан, 2018 ба 2023

KASE хөрөнгийн биржийн үзүүлэлт 2018 оноос 2023 оны хооронд илт сайжирсан байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, АСЧБ нь зөвхөн өөрийн нутаг дэвсгэр дотор хөгжих бус дотоодын зах зээлийн хөгжилд ч нөлөөсөн байна хэмээн дүгнэж байна.

Бүлгийн дүгнэлт

Казакстан улс нь ОУСТ байгуулахыг эртнээс эрмэлзэж ирсэн бөгөөд анхны санхүүгийн чөлөөт бүсийг Алматы хотод байгуулсан боловч амжилттай хэрэгжүүлж чадаагүй байна. Учир нь тухайн үеийн дэлхийн эдийн засгийн хямрал Казакстан улсад сөрөг нөлөө үзүүлсэн бөгөөд эдийн засгийн чадавхи болон төрийн өмчит компаниудын

нөөц бололцоо хумигдсан байсан. Нөгөө талаас тус бүсийг байгуулах төлөвлөгөө нь иж бүрэн бус зөвхөн санхүүгийн чөлөөт бүс байгуулах хуулиар хязгаарлагдаж байсан нь бодит байдал дээр хэрэгжих боломжийг хаасан байна.

Гэхдээ Казакстан улс нь өмнөх амжилтгүй туршлагаасаа суралцан АСЧБ-ийг байгуулахдаа дэлхийн шилдэг экспертүүдийг цуглуулан дотоодын мэргэжилтнүүдийг дэлхийн түвшинд сургахаас гадна чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт хэрэгжих хууль тогтоомж, дэд бүтэц, бизнесийн орчинг цогцоор нь шийдвэрлэсэн. Түүнчлэн хамгийн чухал хүчин зүйл нь Английн эрх зүйн системийг чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт бий болгосноор хөрөнгө оруулагчдын итгэлийг бий болгосон нь чөлөөт бүсийг амжилттай байгуулах суурь нөхцөл нь болсон байна.

ДҮГНЭЛТ

Далайн боомтод түшиглэн байгуулагдсан анхны чөлөөт боомт нь 1960-аад оноос хойш худалдааны, аж үйлдвэрлэлийн, үйлчилгээний гэх мэт олон төрөл, хэлбэрээр үүсч, хөгжсөөр дэлхийн улс орнуудын хөгжлийн нэг арга зам нь болжээ. Чөлөөт бүсийн гол давуу тал нь тухайн улсын хэмжээнд хэрэгжүүлэхэд өндөр эрсдэлтэй эдийн засгийн бодлогыг бага зардлаар, тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэгжүүлж үр ашгийг нь хүртэхээс гадна дотоодын зах зээлийг гадаад зах зээлийн сөрөг нөлөөллөөс хамгаалах боломжийг олгодогт оршдог. Хөгжиж буй улс орнуудын хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, шинэ ноу-хау, техник, технологийн дэвшлийг нутагшуулахын тулд бусад улс оронтой өрсөлдөхүйц бизнесийн болон татварын таатай орчинг бий болгосон чөлөөт бүс байгуулах нь түгээмэл болжээ (UNCTAD, 2019).

Санхүүгийн салбар ч энэ үйл явцаас ангид оршсонгүй. Өөрөөр хэлбэл санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхийн тулд санхүүгийн чөлөөт бүс байгуулах аргыг сонгон амжилттай хэрэгжүүлж байгаа олон жишээ байгаагаас БНСУ-ын Бусан, АНЭУ-ын Дубай, Абу Дхаби, Казаскстаны Астана санхүүгийн чөлөөт бүсийг дурдаж болох юм.

МУ-д хувьд социалист эдийн засгаас зах зээлийн чөлөөт эдийн засагт шилжихдээ нэг шатлалт банкны системийг хоёр шатлалт банкны систем болгон шинэчлэн зохион байгуулж, хөрөнгийн биржийг үүсгэн байгуулсан хэдий ч өнөөдрийг хүртэл санхүүгийн салбарын нийт хөрөнгийн 90 гаруй хувийг банкны салбар дангаар бүрдүүлж байна (МБ, СХЗ, 2023). Хөрөнгийн зах зээлийн арилжаа сүүлийн 2-3 жил эрчимжиж байгаа хэдий ч нийт зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь 12.35, хөрвөх чадвар 2.4 буюу хөгжиж буй 10 улстай харьцуулахад хамгийн сул үзүүлэлттэй нь байна (ДБ, 2019/2020). Түүнчлэн МҮХАТ-ын БОС-аар МУ-д бизнес эрхлэхэд санхүүжилтийн орчин муу, санхүүгийн зардал өндөр, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх шаардлагатай гэсэн үр дүн гарсан тул судлаачийн хувьд санхүүгийн зах зээлийн хөгжил сул байна хэмээн дүгнэж, санхүүгийн чөлөөт бүсэд тулгуурлан санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх боломжийг тодорхойлохыг зорьсон.

Санхүүгийн чөлөөт бүс байгуулах боломжийг судлах явцад Лондон хотод байрлах ОУ-ын тинк танк бодлогын судалгааны хүрээлэн Z/Yen жил бүрийн 3 болон 9 сард ОУСТ-үүдийг өрсөлдөх чадварын хувьд эрэмбэлж, үнэлдэг болохыг судалж мэдсэн. Түүнчлэн МУ-д СЧБ байгуулбал эдгээр ОУСТ-үүдийн нэгэн адил өрсөлдөх чадварын хувьд үнэлэгдэн, эрэмбэлэгдэх бөгөөд одоо байгаа 121 ОУСТ нь бидний хувьд шууд болон шууд бус өрсөлдөгчид болох юм. Иймд МУ-д санхүүгийн чөлөөт бүс байгуулах боломжийг санхүүгийн зах зээлийн өрсөлдөх чадварыг үнэлэх замаар тодорхойлохыг эрмэлзсэн бөгөөд Майкл Портерын Даймонд загвараар нийт 4 бүлэг, 19 хүчин зүйлсийг хоёрдогч өгөгдөл суурилан, 1-ээс 5 оноогоор /1 маш муу, 2 муу, 3 дунд, 4 сайн, 5 маш сайн/ үнэлэхэд МУ-ын санхүүгийн зах зээлийн өрсөлдөх чадвар дунд үнэлгээтэй гарсан. Судлаачийн зүгээс дунд үнэлгээ нь санхүүгийн чөлөөт бүс байгуулах боломж байгааг илэрхийлж байна гэж үзсэн боловч сайн үнэлгээтэй бүлэг хүчин зүйлс байхгүй байгаа нь өрсөлдөх давуу тал байхгүй байгааг харуулж байна гэж дүгнэж байна. Тодруулбал, өрсөлдөх чадварын 4 бүлгээс муу, эсхүл маш муу үнэлгээтэй бүлэг байхгүй байгаа нь санхүүгийн салбарын суурь хангалттай тавигдсан байна. Эсрэгээрээ, уг 4 бүлгээс сайн, эсхүл маш сайн үнэлгээтэй бүлэг байхгүй байгаа нь хангалттай хөгжсөн гэж үзэх хүчин

зүйлс мөн байхгүй байгааг харуулж байна. Түүнчлэн Казакстан улсын АСЧБ нь МУ-д байгуулагдах СЧБ-ийн шууд өрсөлдөгч байж болохоор байна.

Казакстан улс АСЧБ-ийг байгуулахаас өмнө СЧБ байгуулахыг оролдон бүтэлгүйтэж байсан туршлагатай байна. Анхны санхүүгийн чөлөөт бүс болох Алматыгийн бүс нутгийн санхүүгийн төвийг байгуулах тухай 1995 онд зарласнаас хойш 2005 онд төлөвлөгөө боловсруулан, бүс байгуулах тухай хууль баталж, эрх зүйн үндсийг тавьсан. Гэвч уг чөлөөт бүсийг амжилттай байгуулаж чадаагүй бөгөөд судлаачид үүний шалтгааныг эдийн засгийн болон хууль, эрх зүйн хүчин зүйлс нөлөөлсөн гэж үзсэн байна (M.Z. Kenzhaliyev, 2022). Нэг талаас тус бүсийг байгуулах үед дэлхийн эдийн засаг гүнзгий хямарсан нь Казакстаны эдийн засагт хүчтэй нөлөөлж эдийн засгийн чадавхи, нөөц бололцоог байхгүй болгосон. Нөгөө талаас зөвхөн чөлөөт бүс байгуулах тухай хууль тогтоомжийг баталж, эрх зүйн суурийг хангалттай бий болгоогүй нь нөлөөлсөн. Тодруулбал тус бүсийн санхүү, бизнес, хөрөнгө оруулалтын орчинг зохицуулсан хууль, тогтоомж хангалтгүй, тодорхой бус байхаас гадна чөлөөт бүс дэх дэд бүтэц, бизнес эрхлэгчдийн ажиллах, амьдрах орчинг цогцоор нь шийдвэрлээгүй буюу суурь нөхцөлийг бүрдүүлээгүйтэй холбоотой байна. Түүнчлэн эдгээр судлаачдын тодорхойлсон хүчин зүйлс нь судлагдсан байдлын судалгааны хүрээнд судалсан судлаач С.Батбуян болон Ж.Эрдэнэбулган тэргүүтэй судлаачдын бүтээлд тодорхойлсон МУ-д байгуулагдсан чөлөөт бүс амжилттай хэрэгжихгүй байгаа шалтгаануудтай ижил байгааг анхаарч үзэн цаашид ЧБ байгуулах, эсхүл одоо байгуу ЧБ-ийг хөгжүүлэхдээ уг алдааг засаж, сайжруулах шаардлагатай байна гэж дүгнэж байна.

Казакстан улс нь өмнөх алдаанаасаа суралцан хоёр дахь оролдлого болох АСЧБ-ийг амжилттай байгуулжээ. АСЧБ-ийг байгуулахдаа үндсэн хуулиндаа АСЧБ хэмээн нэрлэгдэх тусгай дэглэм бүхий нутаг дэвсгэрт, санхүү, бизнесийн харилцааг Английн эрх зүйн системийн хүрээнд зохицуулахаар өөрчлөлт оруулсан. Түүнчлэн чөлөөт бүс нь тусдаа шүүх болон арбиртыг үүсгэн байгуулж, бизнесийн маргааныг Английн преседентэд тулгуурлан шүүх болон арбитрын журмаар шийдвэрлэж байхаар зохицуулж өгсөн нь хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалт нь найдвартай, аюулгүй байгаа итгэлийг төрүүлж өгсөн байна. МУ-д байгуулагдсан чөлөөт бүс амжилттай хэрэгжихгүй байгаа шалтгааныг хөрөнгө оруулагчдын хөрөнгө аюулгүй, эрсдэл багатай байгаа итгэл төрүүлэх орчин бүрдээгүй байна гэж судлагдсан байдлын судалгаанд дурдсан О.Хишигмөнх судлаач дүгнэсэн байсан бөгөөд Казакстан улсын өмнөх амжилтгүй туршлагатай харьцуулан үзэхэд энэ нь үндэслэлтэй байна.

Хамгийн сүүлийн буюу 3 дахь бүлэгт санхүүгийн чөлөөт бүс байгуулах нь санхүүгийн зах зээлийн хөгжилд хэрхэн нөлөөлж байгааг Казакстаны дотоодын санхүүгийн зах зээлийн үзүүлэлтийг АСЧБ байгуулагдсан он буюу 2018 оныг 2023 онтой харьцуулах замаар үнэлсэн. Энэхүү харьцуулсан судалгааны хүрээнд дотоодын хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүд 132-оос 293 хувиар өссөн үр дүнтэй байгаа тул санхүүгийн чөлөөт бүсэд тулгуурлан санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх бүрэн боломжтой буюу судалгааны ажлын хүлээгдэж буй үр дүн батлагдсан.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Энэхүү судалгааны хүрээнд дараах онолын санал зөвлөмжийг боловсруулж байна.

1. МУ-ын санхүүгийн зах зээлийг санхүүгийн чөлөөт бүсэд тулгуурлан хөгжүүлэх боломж байгаа тул цаашид боломжийг бодит болгох арга замыг нарийвчлан судлахыг санал болгож байна.
2. МУ-ын үндсэн хууль болон Казакстан улсын үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг харьцуулан судлах замаар МУ-ын үндсэн хуульд санхүүгийн чөлөөт бүсэд Английн эрх зүйн системийг хэрэглэх тухай өөрчлөлт оруулах боломжийг нарийвчлан судлахыг санал болгож байна. \
3. АСЧБ-д Английн эрх зүйн системийг ашиглаж байгаа нь дотоодын хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаа болон тулгарч буй асуудлуудыг нарийвчлан судлахыг санал болгож байна.
4. Санхүүгийн чөлөөт бүс байгуулах газарзүйн байршлын нарийвчлан судлах шаардлагатай байна. Учир нь чөлөөт бүсийг амжилттай байгуулах гол хүчин зүйл нь бизнесийн орчинг цогцоор нь бүрдүүлэх шаардлагатай байгаа бөгөөд Замын-Үүд, Цагааннуур, Алтанбулаг зэрэг чөлөөт бүсүүдтэй адил дэд бүтэц, барилга байгууламж зэргийг шинээр бүтээн байгуулах буюу орон нутагт байгуулах нь амжилтгүй чөлөөт бүсийн тоог нэмэхээс өөр үр дүнгүй болохоор байна. Иймд, төвлөрсөн бүтэцтэй Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Сайншанд гэх мэт хот түшиглэн байгуулах боломжийг үнэлэх судалгаа хийхийг санал болгож байна.
5. Стратегийн хөрөнгө оруулагч, партнеруудыг тодорхойлох судалгаа хийхийг санал болгож байна. Казакстан улсын хувьд БНХАУ-ыг стратегийн хөрөнгө оруулагчаар сонгож, Бүс ба Зам санаачлагад тулгуурлан санхүүгийн чөлөөт бүсийг байгуулсан.
6. Чөлөөт бүсийг амжилттай хөгжүүлэхийн тулд бизнесийн орчныг цогцоор нь бүрдүүлэх, байнгын үйл ажиллагаанд шилжүүлэхээс өмнө чөлөөт бүсийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм журмыг бүрэн боловсруулахыг зөвлөж байна.
7. МУ-д байгуулагдсан болон байгуулахаар төлөвлөж буй чөлөөт бүсүүдэд олон улсын өндөр ур чадвар бүхий мэргэжилтэнг татах таатай нөхцөл бүрдүүлэх арга замыг нарийвчлан судлах, виз олголтын журам, ажиллах, амьдрах таатай орчинг хэрхэн сайжруулах алхамуудыг тодорхойлохыг зөвлөж байна.

НОМ ЗҮЙ

- Youssef, C. (2006). Capitals of Capital: A History of International Financial Centres, 1780-2005 (АНХНЫ ХЭВЛЭЛ). United States of America, New York: Cambridge University Press.
- United Nation, International Jacques Maritain Institute. (2000). Financial Globalization and Emerging Economies. (АНХНЫ ХЭВЛЭЛ). Santiago, Chile: United Nations Publication
- Kindleberger, P. (1974). The Formation of Financial Centers: A Study in Comparative Economic History. Princeton Studies in International Finance № 36. Retrieved from <https://ies.princeton.edu/pdf/S36.pdf>.
- Ngiam, K.J. (1996). The National Bureau of Economic Research. Chapter of Singapore as a Financial Center: New Developments, Challenges, and Prospect. Retrieved from <http://www.nber.org/chapters/c8569>.
- Sayuti, Sh. (2017). Tokyo as a Leading Global Financial Center: The vision under the spotlight again. ADB working papers № 758. Retrieved from <https://www.adb.org/sites/default/files/publication/327606/adbi-wp758.pdf>.
- Thang, C.N, Nhan, T.N, Duc, H.V. (2020). Necessary Conditions for Establishing an International Financial Center in Asia. Business&Management 7:1. Retrieved from <https://doi.org/10.1080/23311975.2020.1823597>.
- UNCTAD. (2019). World Investment Report 2019: Special Economic Zones. Retrieved from https://unctad.org/system/files/official-document/wir2019_en.pdf.
- Magpantay, L. (2011). Anatomy of a Financial Center`s Global Competitiveness in the Context of Micheal Porter`s model of National Competitive Advantage a Theoretical Analysis. University of Central Florida. Retrieved from <https://stars.library.ucf.edu/cgi/viewcontent.cgi?article=2200&context=honorstheses1990-2015>.
- Z/Yen. (2023) The Global Financial Centres Index 34. Retrieved from <https://www.longfinance.net/programmes/financial-centre-futures/global-financial-centres-index/>.
- Martine, A. (2019). The New York-London Financial Nexus in the Shadow of Brexit. Open Edition Journals. Retrieved from <https://journals.openedition.org/osb/3311>.
- Ann, M.C., Larry, N. (2011). Amsterdam and London as Financial Centers in the Eighteenth Century: Financial History Review. Retrieved from <https://eprints.lse.ac.uk/38799/1/Amsterdam%20and%20London%20as%20financial%20centres%20in%20the%2018th%20century%28Isero%29.pdf>.
- Zhanna, S., Sergey, Ya. (2017). Development Prospects of London as the World`s Financial Center in the Conditions of Brexit. Baltic Journal of Economic Studies 3(4). Retrieved from <https://ideas.repec.org/a/bal/journal/2256-074220173435.html>.
- Z/Yen. (2005). The Competitive Position of London as a Global Financial Centre. Retrieved from <https://www.zyen.com/documents>.

- Meng, G. (2003). The Theory and Practice of Free Economic Zone: A Case Study of Tianjin, People`s Republic of China. Retrieved from <https://d-nb.info/966590376/34>.
- ADB Institute. (2018). Financial Inclusion and Financial Literacy in Kazakhstan. ADB working papers № 876. Retrieved from <https://www.adb.org/sites/default/files/publication/460061/adbi-wp876.pdf>.
- Nazerke, P.K., Serik, B.M., Gulzat, K.K., Kairbek, T.A., Pernebek, K.U. (2024). The role of the Astana International Financial Centre in the capital market. Capital Markets Journal № 19. Available at <https://academic.oup.com/cmlj/article-abstract/19/1/86/7425592?redirectedFrom=fulltext>.
- МҮХАҮТ. (2020). “Монголын Бизнесийн Орчин 2020” судалгааны товхимол. Retrieved from <https://www.mongolchamber.mn/p/365>
- МҮХАҮТ. (2021). Хүнд суртлын индекс-2021 судалгааны тайлан. Retrieved from <https://www.mongolchamber.mn/p?c=7>.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Стратеги, бүтэц, өрсөлдөөн-Бизнесийн ерөнхий орчин

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	Эдийн засгийн орчин			3		
2	Бизнес эрхлэх зардал				2	
3	Татварын орчин			3		
4	Бизнесийн хууль, эрх зүйн орчин			3		

Эх сурвалж:

<https://www.mongolchamber.mn/resource/mongolchamber/File/2020/12/03/xuopjkh69by6gsqr/Business-sudalгаа-2020.pdf>

Хавсралт 2. Стратеги, бүтэц, өрсөлдөөн-Капиталын хөдөлгөөн

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	Капиталын хөдөлгөөний хяналт			3		
2	Валютын ханшийн нөлөө					1

Эх сурвалж:

https://resource4.sodonsolution.org/mongolchamber/File/2019/10/17/kgmdw7wnaabkz9hk/2_Sudalgaanii%20tilan_final_V20181224_web.pdf

Хавсралт 3. Стратеги, бүтэц, өрсөлдөөн-Зах зээлд шинээр нэвтрэх

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	Гадаадын санхүүгийн байгууллага зах зээлд нэвтрэхэд учрах саад				2	
2	Ирээдүйд зах зээлд шинээр нэвтрэхэд саад үүсэх эсэх			3		
3	Чадварлаг хүний нөөцийг татахад саад бий эсэх				2	

Эх сурвалж: <https://www.mongolbank.mn/mn/r/5490>, <https://nda.gov.mn>, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390388880621>

2024 оны мөнгөний бодлогод гадны банкны салбар нээх хууль, эрх зүйн орчинг бий болгох зорилт тавьсан. Түүнчлэн Алсын хараа-2050 бодлогын баримт бичигт олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах зорилгыг дэвшүүлсэн.

Ажлын байрны төлбөр болон гадаад ажилтаны тоог дотоодын ажилтны тоонд харьцуулан хязгаарлалт хийдэг бөгөөд жил бүр ЗГ гадаадаас ажиллах хүч авах тоог салбар бүрээр шинэчлэн тогтоож баталдаг.

Хавсралт 4. Стратеги, бүтэц, өрсөлдөөн-Хууль тогтоомжийн тэнцвэрт байдал

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	Хяналтын тогтолцоо талуудын эрх тэгш байдлыг хангасан эсэх			3		
2	Хууль тогтоогч, хэрэгжүүлэгч нар асуудлыг шийдвэрлэж буй байдал				2	
3	Хялбар, уялдаа холбоотой бүтэц бий эсэх				2	

Эх сурвалж: <https://www.mongolchamber.mn/p/365>,

https://resource4.sodonsolution.org/mongolchamber/File/2019/10/17/kgmdw7wnaabkz9hk/2_Sudalgaanii%20tilan_final_V20181224_web.pdf

Төрийн байгууллагын харилцаа, ёс зүй, асуудлыг шийдвэрлэх байдал, хурд муу гэж бөгөөд хоорондын уялдаа холбоо байхгүй гэж үнэлсэн байна.

Хавсралт 5. Стратеги, бүтэц, өрсөлдөөн-Хууль, эрх зүйн орчин

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	Нийтийн эрх зүйн системтэй эсэх				2	
2	Олон улсын гэрээ, конвенцид нэгдсэн эсэх			3		
3	Бизнес, санхүүгийн эрх зүйн орчны хууль тогтоомжид уян хатан өөрчлөлт хийгддэг эсэх		4			

Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/law?page=law&cate=27&active=1&page=1&sort=title&page=1>

Иргэний эрх зүйн системтэй бөгөөд ОУ-ын гэрээ, конвенцид нэгдсэн. Компанийн тухай хуульд 8, банкны тухай хуульд 20, үнэт цаасны тухай хуульд 11 удаа нэмэлт өөрчлөлтийг тухайн хуулиуд батлагдсанаасаа хойш хийсэн байна.

Хавсралт 6. Стратеги, бүтэц, өрсөлдөөн-Дотоод өрсөлдөөн

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	Бизнесийн нэгдэх, нийлэх эрх олгогдсон эсэх		4			
2	Өрсөлдөөний эсрэг үр ашигтай бодлого, хууль тогтоомжтой эсэх		4			

Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/law?page=law&cate=27&active=1&page=1&sort=title&page=1>

Компанийн тухай хуулиар нэгдэж, нийлэх эрхийг олгож зохицуулсан. Өрсөлдөөний тухай хуулийг батлахаас гадна “Шудрага өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө” газраас өрсөлдөөний тухай бодлого болон монополь, давамгайл байдалтай аж ахуйн нэгжүүдийг салбар бүрээр тодорхойлон хяналт тавьж ажилладаг.

Хавсралт 7. Хүчин зүйлсийн нөхцөл байдал-Хүний нөөц

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	Санхүүгийн салбарт ОУ-ын түвшиний өндөр ур чадвар бүхий хүний нөөц бий эсэх			3		
2	Судалгаа, шинжилгээ, технологийн чиглэлийн хүний нөөц бий эсэх			3		
3	Төслийн удирдлагаар мэргэшсэн хүний нөөц бий эсэх			3		

Эх сурвалж: <https://www.mongolchamber.mn/p/365>

Хүний нөөц байгаа хэдий ч ОУ-ын түвшиний өндөр ур чадвартай хүний нөөц хангалттай эсэх талаар нарийвчилсан судалгаа байхгүй. Иймд цаашид уг судалгааг нарийвчлан хийх шаардлагатай.

Хавсралт 8. Хүчин зүйлсийн нөхцөл байдал-Эрх зүйн орчны дэд бүтэц

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	Санхүүгийн салбар дахь ЗГ-ын оролцооны түвшин			3		
2	ЭЗ-ийн тогтвортой өсөлттэй эсэх		4			
3	ЗГ-ын үйл ажиллагаа шилэн, ил тод эсэх			3		

Эх сурвалж: <https://www.mongolchamber.mn/p/365>, World Bank, Mongolian Economic Outlook 2023, https://resource4.sodonsolution.org/mongolchamber/File/2019/10/17/kgmdw7wnaabkz9hk/2_Sudalgaanii%20tilan_final_V20181224_web.pdf

ЗГ-ын асуудлыг шийдвэрлэх байдал удаан, уян хатан бус хэдий ч нөгөө талаас бизнес эрхлэгч нарт хамгийн их дэмжлэг үзүүлдэг этгээд ЗГ байна. Мөн дэлхийн банкны судалгаагаар ковид-19 цар тахал гарснаас бусад онуудад эдийн засгийн байнгын тогтвортой өсөлттэй байсан байна.

Хавсралт 9. Хүчин зүйлсийн нөхцөл байдал-Мэдээлэл, харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэд бүтэц

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	Найдвартай харилцаа холбооны бүтэц байгаа эсэх		4			
2	Өндөр хурдны интернэтэд холбогдсон эсэх		4			
3	Дэлхийд өрсөлдөхүйц мэдээллийн технологийн хэрэглээ, мэдлэг бий эсэх		4			

Эх сурвалж: <https://www.mongolchamber.mn/p/365>

19 хүчин зүйлсээс хамгийн өндөр үнэлгээтэй хүчин зүйлс байсан.

Хавсралт 10. Хүчин зүйлсийн нөхцөл байдал-Амьдралын чанар

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	ОУ-ын хэлний хэрэглээ				2	
2	Нийгэм, соёл, урлаг, спортын олон төрлийн үйл ажиллагаа явагддаг эсэх		4			
3	Улс төр, нийгмийн байдал тогтвортой эсэх				2	

Эх сурвалж: <https://www.ef.com/wwen/epi/>, <https://www.mongolchamber.mn/p/365>,
<https://www.mongolchamber.mn/p/366>

Хавсралт 11. Хүчин зүйлсийн нөхцөл байдал-Барилга байгууламж, нийтийн тээврийн дэд бүтэц

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	ОУ-ын хэлний хэрэглээ			3		
2	Нийгэм, соёл, урлаг, спортын олон төрлийн үйл ажиллагаа явагддаг эсэх			3		
3	Улс төр, нийгмийн байдал тогтвортой эсэх			3		

Эх сурвалж: <https://worldpopulationreview.com/country-rankings/road-quality-by-country>

ОУ-ын судалгаагаар авто замын чанар дунд гэж үнэлэгдсэн. БНХАУ болон ОХУ-ыг холбосон авто болон төмөр замын сүлжээ байгаа боловч хангалттай бус байна.

Хавсралт 12. Хүчин зүйлсийн нөхцөл байдал-Газарзүйн байршлын давуу тал

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	ОУ-ын худалдаа төв болж байсан түүх бий эсэх			3		
2	Дэлхийн хөрөнгийн зах зээлийн ажиллах цагийн хуваарьтай давхцал бий эсэх		4			

Арвангуравдугаар зууны үеийн Монголын эзэнт гүрний байгуулсан торгоны зам нь одоогийн МУ-ын нутаг дэвсгэрийг дайран өнгөрч байгаагүй боловч өнөөгийн БНХАУ-

ын Бүс ба Зам санаачлагад нэгдсэн. Түүнчлэн Азийн хөрөнгийн зах зээлийн ажлын цагийн хуваарьтай МУ-ын хөрөнгийн биржийн ажиллах цагийн хуваарь давхцдаг.

Хавсралт 13. Эрэлтийн нөхцөл байдал-Дотоод эдийн засгийн орчин

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	Эдийн засгийн өсөлттэй бүс нутагт байрладаг эсэх		4			
2	ДНБ тогтвортой өсдөг эсэх		4			
3	Инфляцийн түвшин бага байдаг эсэх					1

Эх сурвалж: <https://sudalгаа.gov.mn/pdf/mongol-ulsyn-bschilsen-khgzhliyn-onolyn-ndes-negdsen-argazy-argachl-qmj>, <https://www.mongolchamber.mn/p/365>

БНХАУ-тай хөрш зэргэлдээ байрладаг нь эдийн засгийн хувьд өсөлт хийх боломжийг бий болгодог бөгөөд МУ-ын ДНБ тогтвортой өсөлттэй байна. Инфляцийн түвшин өндөр байдаг нь бизнес эрхлэхэд хамгийн их хүндрэл үзүүлдэг хүчин зүйлс байна.

Хавсралт 14. Эрэлтийн нөхцөл байдал-Капиталын эх үүсвэр

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	Үнэт цаас болон хадгаламжийн зуучлалын хэрэгцээ өсч байгаа эсэх		4			
2	Хөрөнгө оруулалтад зарцуулах илүүдэл нөөц байгаа эсэх			3		

Эх сурвалж: <http://www.frc.mn/resource/frc/Document/2023/03/10/mzq70lzbtfv0dbd/Toim%202022%20urult%202023.03.10.pdf>, <https://www.1212.mn/mn/statistic/file-library/view/65217112>

2018 онтой харьцуулахад үнэт цаасны арилжаа 2.4 дахин, бондын арилжаа 79 лахин, хувьцааны арилжаа 63 хувиар өссөн байна. ДНБ-ийн 18 хувийг хадгаламж эзэлдэг байхад дэлхийн бусад улсууд 26.9 хувь байна.

Хавсралт 15. Эрэлтийн нөхцөл байдал-Дотоодын хэрэглэгч

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	Нэг хүнд ноогдох ҮНО-ын түвшин өндөр эсэх				2	
2	Бичиг үсэг тайлагдсан байдал	5				
3	ЭЗ болон санхүүгийн мэдээллийн урсгал чөлөөтэй эсэх		4			

Эх сурвалж: <https://www.1212.mn/mn/statistic/file-library/view/65217112>

МУ-ын нэг хүнд ноогдох ҮНО нь 3.73 ам.доллар буюу дундаас доогуур орлоготой бөгөөд МУ-ын нийт хүн амын 99 хувь нь бичиг үсэг тайлагдсан. Түүнчлэн мэдээлэл хүртээмж байдаг гэж МҮХАТ-ын судалгаанд үнэлэгдсэн.

Хавсралт 16. Эрэлтийн нөхцөл байдал-Дотоод зах зээл болон оролцогчдын уян хатан байдал

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	Санхүүгийн бус үндэстэн дамнасан корпораци байдаг эсэх			3		
2	Дээд боловсролтой хүмүүст ажлын байр хангалттай байдаг эсэх			3		

Эх сурвалж: <https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/BASELINE-STUDY-ON-SUPPLY-AND-DEMAND-FOR-SELF--AND-WAGE-EMPLOYMENT-FOR-CURRENT-AND-FUTURE-WORK.-MON.-pdf.pdf>, <https://www.mongolchamber.mn/p/365>

МҮХАТ-ын БОС-нд 200-аас дээш ажилтайн том ангилалд багтах ААН-ийн 21 хувь нь гол өрсөлдөгчид нь гадаадын хөрөнгө оруулалттай АНН хэмээн хариулсан байна. Ажлын байрны захиалга буурсан байгаа ч дээд боловсролтой хүмүүсийн ажлын байрны эрэлт, нийлүүлэлт тэнцвэртэй байна.

Хавсралт 17. Холбоотой болон дэмжих салбарууд-Дэлхийн зах зээлийн интеграцичлалын нөлөөний цар хүрээ

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	Дотоодын хөрөнгө оруулагчид дэлхийн хөрөнгийн зах зээлд оролцдог эсэх					1
2	ОУ-ын хөрөнгө оруулагчид дотоодын хөрөнгийн зах зээлд оролцдог эсэх					1
3	ОУ-ын стандарт болон сайн туршлагыг нэвтрүүлсэн эсэх			3		

Эх сурвалж: <https://marketinfo.mn/infographic/detail/21270>,
<https://legalinfo.mn/mn/law?page=law&cate=27&active=1&page=1&sort=title&page=1>

Дотоодын хөрөнгийн зах зээлд оролцогчдын 97 хувийг дотоод, 3 хувийг гадаадын хөрөнгө оруулагчид бүрдүүлж байна. ОУ-ын стандартын тухайд ОУНББС-ыг мөрдөхийг хуульчлан зохицуулахаас гадна, ISO стандарт түгээмэл нэвтэрсэн.

Хавсралт 18. Холбоотой болон дэмжих салбарууд-Дэмжигч салбарын өсөлт

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	ОУ-ын аудит, НББ-ийн байгууллага дотоодын зах зээлд үйл ажиллагаа явуулдаг эсэх		4			
2	Инноваци, мэдээллийн технологийн салбар хөгжиж байгаа эсэх		4			
3	Хамгийн сүүлийн үеийн харилцаа холбооны хөгжил, дэвшил, техник, технологи нэвтэрсэн эсэх		4			

Эх сурвалж: <https://publicadministration.un.org/egovkb/en-us/Data-Center>,
<https://www.mongolchamber.mn/p/365>

ОУ-ын аудит, НББ-ийн дэлхийн ТОП-4 компани дотоодын зах зээлд салбараа нээн, үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. НҮБ-ын судалгаагаар харилцаа холбооны дэд бүтцийн хөгжил, техник, технологийн дэвшил нэвтэрсэн байдлыг эрэмбэлэхэд нийт 193 улсаас МУ 74-т эрэмбэлэгдсэн байна.

Хавсралт 19. Холбоотой болон дэмжих салбарууд-Холбоотой салбарын чанар

№	Үнэлгээний хүчин зүйлс	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1	Боловсролын чанар				2	
2	ОУ-ын санхүүгийн институциудын салбар байдаг эсэх		4			
3	Эрүүл мэнд, аялал жуулчлалын салбарын хөгжил		4			
4	Тогтвортой тээвэр, логистикийн сүлжээ бий болсон эсэх				2	

Эх сурвалж: <https://sudalгаа.gov.mn/pdf/tRuclT>, <https://www.mongolchamber.mn/p/365>

МУ-ын нийт хүн амын 33 хувийг дээд боловсролтой хүмүүс эзэлдэг боловч боловсролын чанар хангалттай бус байгаа нь их, дээд боловсрол олгож буй сургуулиуд дэлхийд доогуур эрэмбэлэгдэж байгаагаас харагдаж байна.

ОУ-ын санхүүгийн институци болох ОУВС, ДБ, АХБ, ЕСБХБ зэрэг олон байгууллагуудын салбар МУ-д үйл ажиллагаа явуулдаг. Аялал жуулчлалын салбар эрчимтэй сэргэж байна.

Харин тээвэр, логистикийн хувьд далайд гарцгүй, төмөр зам, авто замын сүлжээ хангалттай бус байна.